

MONGOLIAN ECONOMY

2015 оны 11 сар. № 20 (099)

www.mongolianeconomy.mn


ЭДИЙН ЗАСАГ
ХӨРСӨН ДЭЭРЭЭ БУУХ ЦАГ

БИЗНЕС
"МАНАЙ САЛБАРТ МАШ САЙХАН ИРЭЭДҮЙ БИЙ"

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ
Хуурамч найзууд

Т.Доржханд:

Хүндээ хөрөнгө оруулах нь монгол төрийн бодлого байх ёстой



Дэлхийн эдийн засгийн замын зураг
бүтэн жилийн турш тантай хамт

Дэлхий 2016

Дэлхий нийтийн ирээдүйн таамаг

The Economist Таны ирэх
жилийн хөтөч

The Economist сэтгүүлийн
“THE WORLD IN 2016” жилийн
дугаарыг Монгол дахь албан ёсны тусгай
зөвшөөрөл эзэмшигч **“Mongolian Economy”**
сэтгүүл монгол хэлээр эрхлэн гаргах гэж
байна.

2016.01 сард танд хүрнэ



Утас 94092904, 94092905, 70115476, 70115477
www.marketing@mongolianeconomy.mn
www.info@mongolianeconomy.mn





С Э Р Э Л Т
ТАКС ТМЗ ХХК

ТАНИЛЦУУЛГА

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан “Сэрэл” ХХК нь “Сэрэлтакс ТМЗ” ХХК-ийг үүсгэн байгуулж Сангийн сайдын 2015 оны хоёрдугаар сарын 16-ны өдрийн 37 тоот тушаалын тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Харилцагчиддаа татвараа хуулийн дагуу үнэн зөв тодорхойлоход нь туслах үндсэн үүрэгтэй манай хамт олон татварын эрх зүйн орчныг тасралтгүй судалж шинжлэн, харилцагчдынхаа үйл ажиллагаанд учирч болох татварын аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, татварын эрсдэлгүй ажиллуулах үндсэн зорилт тавин ажиллаж байна.

Бид харилцагчдаа шаардлагатай мэдээлэл, зөвлөмжөөр цаг тухайд нь бүрэн хангах, аливаа эрсдлийг богино хугацаанд арилгах, заавар зөвлөмжийг хууль тогтоомжын хүрээнд хамгийн энгийн ойлгомжтой хувилбараар хүргэхийг зорьж, татварын хуулиудын өөрчлөлт, шинэчлэлүүдийг анхааралтай судалж мэдээллэн ажиллаж байна.

- Нягтлан бодох бүртгэлийн аутсорсинг үйлчилгээ
- Татварын зөвлөх үйлчилгээ
- Бусад зөвлөх үйлчилгээ

Хаяг: Чингэлтэй дүүрэг 1-р хороо
Энхтайваны гудамж, Denver оффис, 304 тоот
Утас/Факс: 99093541, 88002321

НЭГ ДУГААР 15,000₮
УЛИРАЛ /6 ДУГААР/ 90,000₮
ХАГАС ЖИЛ /12 ДУГААР/ 180,000₮
ЖИЛ /24 ДУГААР/ 360,000₮

18,000₮

Үүсгэн байгуулагч, Эрхлэгч:

Д.Бэхбаяр / 9999-4248

Үүсгэн байгуулагч, Орлогч эрхлэгч:

И.Отгонжаргал / 8800-6228

Сэтгүүлийн редактор:

Б.Үүрийнтуяа

Англи хэлний редактор:

О.Түвшин

Орчуулагч:

Б.Энхмөнх

Вэб редактор:

Б.Энхцэцэг

Сэтгүүлчид:

Г.Орхон

Ц.Элбэгсайхан

Дизайнер:

Б.Сэр-Од

Маркетингийн менежер:

Д.Барянжав / 9409 2904/

Э.Зоригт /9409 2905/

ХАЯГ

Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг.

I хороо, Энхтайвны өргөн чөлөө.

Экспресс тауэр. 1101 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан,

ш/ х-2762

WWW.MONGOLIANECONOMY.MN

INFO@MONGOLIANECONOMY.MN

Утас/Факс: 976 - 7011 5476

"Улаанбаатар принт" ХХК-д хэвлэв

WWW.UBPRINT.MN

Борлуулах цэгүүд:

"Интер ном"

"Цэцэг төв"

"Минж плаза"

"Алтантүлхүүр" номын дэлгүүр

"Номин" супермаркетин бүх салбар

"Макс" супермаркетин бүх салбар

"Фреско" супермаркет

BTSI супермаркет

"Аз орчлон" номын дэлгүүр

"Билэ" их дэлгүүрийн номын тасаг

"Гранд Плаза" дахь супермаркет

"Мир" номын дэлгүүрийн


"GRAND PLAZA"

"METRO MALL"

"SKY" супермаркет

"Улаанбаатар" их дэлгүүр

"Мах mall" дэх салбарууд



“ P16



Тогмидын Доржханд. 1977 онд төрсөн. Нийслэлийн 2-р дунд сургууль, МУИС-ийг Төрийн санхүүгийн чиглэлээр төгссөн бол Японы Хитоцубаши Их Сургуульд Төрийн бодлого, эдийн засгийн онол мэргэжлээр магистрт суралцаж дүүргэсэн. Тэрбээр 1999 онд Сангийн яамны Төсвийн бодлогын газарт мэргэжилтнээр орсон цагаас тус яаманд 15 жил ажиллажээ.

Түүний ажиллаж байсан албан тушаалаас дурдвал, Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлого, зохицуулалтын...

“ P10



Төсөв батлах процесс асуудалтай, тооцооллоо муу хийдгээс орлого дутдаг, төлөвлөгөө биелдэггүй гэх шүүмжлэл бий. Хэдий өдгөө эдийн засгийн байдал тун бараан байгаа ч УИХ-д өргөн бариад буй 2016 оны төсвийн төсөлд нэлээд...

ЭДИЙН ЗАСАГ

- 10 Хөрсөн дээрээ буух цаг
- 12 “Mongolian Economy”-ийн асуулт
- 13 Төсөвт анхаарсан мөнгөний бодлого
- 16 Т.Доржханд: Хүндээ оруулсан хөрөнгө оруулалтын өгөөж хамгийн өндөр байдаг. Энэ нь монгол төрийн бодлого байх ёстой
- 23 Хөдөлмөрийн хуулийг урт настай болгоё гэвэл
- 24 ИС.Мөнхбат: Намуудын төлөвшилтийг хангахад чиглэсэн эрх зүйн зохицуулалт хэрэгтэй
- 26 Халх голд юу болоод байна вэ?
- 30 “Skype” хочтой Эстони эргэлт

БИЗНЕС

- 34 Д.Баасан: Манай салбарт маш сайхан ирээдүй бий
- 38 CAREC хөтөлбөр дэд бүтцийг чухалчилж байна

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ

- 39 Хуурамч найзууд
- 41 Зүүн Ази, Номхон далайн орнууд
- 43 Кристан Лагард: Би маш тодорхой байхыг хүсэж байна
- 47 Дэлхийн газрын тосны үнийн уналт болон Монгол

“ P30



Дэлхийн олон орны иргэд дунд компьютер программчлал нь нүдний шил хамар дээрээ “тохсон”, олноос тасархай онцгой...

Танилцуулга

Монгол улсын санхүүгийн салбарт арилжааны банкууд голлох үүргийг гүйцэтгэж ирсэн ч амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой иргэд, бичил бизнес эрхлэгчдэд санхүүгийн зөвлөгөө өгөх, зээлийн үйлчилгээ үзүүлж ядуурлыг бууруулах, өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-ууд өөрсдийн хувь нэмрээ оруулан ажиллаж байна. Монгол улсын эдийн засгийн өсөлтийг дагаж бичил санхүүгийн салбарт төвлөрөн ажиллаж байсан зарим арилжааны банкуудын стратеги аажмаар өөрчлөгдөн орон зайгаа тэлж, зах зээлийн томоохон салбарууд руу шилжиж байна. Мөн томоохон банкуудын хувьд бичил бизнес эрхлэгчдэд хүрч үйлчлэх боломж нь хязгаарлагдмал байдаг ба ББСБ-ууд илүү уян хатан, шуурхай ажиллах боломжтой байдаг билээ. Иймд сүүлийн үед Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ)-ны тусгай зөвшөөртэй ББСБ-ууд олноор байгуулагдах болсон бөгөөд үүнийг дагаад бүтээгдэхүүн үйлчилгээ нь сайжирч, цар хүрээ нь өргөжиж байна.

Ард Кредит ББСБ (Ард Кредит) нь 2011 онд ББСБ-ын тусгай зөвшөөрөлтэй үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш бичил болон жижиг зээлийн чиглэлээр Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж ирсэн бөгөөд орчин үеийн дэвшилтэт аргачлалыг ашиглан бичил зээлийн үйлчилгээг хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэх эрхэм зорилготойгоор ажиллаж байна. Бид зөвхөн зээлийн үйлчилгээ эрхлээд зогсохгүй харилцагчиддаа өндөр өгөөж бүхий Итгэлцлийн үйлчилгээг санал болгон үйлчилгээнийхээ цар хүрээг өргөжүүлж ирсэн билээ. 2013 онд компанийн хувьцаа эзэмшигчдийн бүтцэд томоохон өөрчлөлтүүд орсон бөгөөд Ард Кредит нь Ард Санхүүгийн Нэгдэл (АН)-ийн шууд хөрөнгө оруулалттай компани болон өөрчлөгдөж салбартаа олон жилийн мэдлэг, туршлага хуримтлуулсан удирдлагын багийг бүрдүүлэн ажиллаж байна.

Бид бичил зээлийн үйлчилгээгээ зөвхөн Улаанбаатар хотын иргэдэд олгоод зогсохгүй алслагдсан хөдөө орон нутгийн малчид, бизнес эрхлэгчдэд Хөдөөгийн Бичил Санхүүгийн Хөгжлийг Дэмжих Холбооны франчайз хадгаламж зээлийн хоршоодын сүлжээг ашиглан хүрч үйлчилж байгаа билээ. Тус холбоо нь Монгол улсын нутгаар тархан байршсан 51 хадгаламж зээлийн хоршоог өөртөө нэгтгэсэн, нийт 13,000 гаруй гишүүнтэй холбоо юм. Мөн түүнчлэн манай байгууллага нь харилцагчиддаа түргэн шуурхай, зардал багатай үйлчилгээ үзүүлэх зорилгоор зээлийн өргөдлийг цахим хэлбэрээр хүлээн авдаг болсон бөгөөд цаашид гар утас, нийгмийн сүлжээ, интернэт гэх мэт орчин үеийн технологийг ашиглаж зээлийн үйлчилгээг илүү хялбар байдлаар харилцагчиддаа хүргэх зорилго тавин ажиллаж байна.

АН нь санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа тэргүүний компаниудад хөрөнгө оруулалт хийж, зах зээл дэх байр суурь, өрсөлдөх чадвар болон үнэ цэнийг нь нэмэгдүүлэх, өөрийн хөрөнгө оруулагчдад өндөр өгөөж өгөх зорилт тавин ажиллаж байгаа үндэсний санхүүгийн холдинг компани юм.

ББСБ-ын зах зээлийн мэдээлэл

/2015 оны II р улирлын байдлаар/



ББСБ-ын тоо 423 ↑ 29.8%

Хөдөө орон нутагт **47**(11.1%)
Улаанбаатар **376**(88.9%)
Гадаад хөрөнгө оруулалттай **21**(5%)



Нийт актив 554.5 ↑ 25% /тэр бум/
Банкны салбарт **2.6%**




Нийт зээлийн багц 362.3 ↑ 34% /тэр бум/
Банкны салбарын **3.2%**

Хугацаа хэтэрсэн 6.7%


7.8% Чанаргүй зээл



Зээлийн дундаж хүү 2.6% ↓



85.5% Хэвийн зээл



Чанаргүй зээл: /28.4 тэр бум/
Өмнөх оны мөн үеэс 84.7% өссөн байна.

Санхүүгийн салбарт
Чанаргүй зээл: 836.8 тэрбум буюу 7.7%
Өмнөх оны мөн үеэс 64.4% өссөн байна.

МОНГОЛД

ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР

Чанартай боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн Ядуурал бууруулах Японы сангийн хоёр сая ам.долларын техник туслалцааны хоёр төслийн гэрээнд Монгол Улсын Засгийн Газар ба Азийн хөгжлийн банк гарын үсэг зурав.

Тус бүр нэг сая ам.долларын санхүүжилттэй эдгээр төсөл нь тэгш хүртээмжтэй боловсрол эзэмшүүлэхэд чиглэсэн шинэчлэлийг удирдан явуулах, Улаанбаатар хотын гэр хороололд амьдарч буй эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад чиглэх юм.

Боловсролын салбарын техник туслалцааны төсөл нь хоёр жил буюу 2017 оны долдугаар сар хүртэл, эрүүл мэндийн салбарын төсөл 2016 оны наймдугаар сар хүртэл хэрэгжих юм.

МОНГОЛ УЛС НҮБ-Д



НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулганы үеэр Нью-Йорк хотноо болсон НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн гишүүдийг сонгох сонгуульд Монгол Улс НҮБ-ын гишүүн 172 орны саналыг авч, тус байгууллагын Хүний эрхийн зөвлөлийн гишүүнээр сонгогдлоо. Ази, Номхон далайн бүлэгт ногдож буй таван суудлын төлөө нийт долоон орон өрсөлдсөн бөгөөд Монгол Улс хамгийн их саналыг авсан байна. Манай улстай өрсөлдсөн Арабын Нэгдсэн Эмират Улс 159, Киргиз 147, БНСУ 136, Филиппин 113 улсын саналыг тус тус авч, Хүний эрхийн зөвлөлийн гишүүнээр сонгогджээ.

Монгол Улс НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн гишүүнээр 2016-2018 онд ажиллах бөгөөд хүний эрхийг хамгаалах чиглэлээр олон улсын хамтын нийгэмлэгийн үйл хэрэгт хувь

нэмрээ оруулах, олон улсын хэмжээнд шийдвэр гаргах түвшинд ажиллах боломжтой болж байгаа юм.

ТЭЭВЭР

НИТХ-ын ээлжит бус зургадугаар хуралдаан болж нийслэлийн тээврийн цахим төлбөрийн системтэй холбоотой цогц асуудлыг хэлэлцэн баталлаа. Тухайлбал, цахим картаар үйлчлүүлэгч 30 минутын дотор дараагийн автобусанд дамжин суувал нэг удаа үнэгүй байхаар батлав. Үүнийг хэрэгжүүлэхэд салбарын алдагдал 2,1 тэрбум төгрөг болж 2015 онд 20,3 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэсэн тооцоо гарсан байна. Мөн оюутнуудын хичээлдээ ирж, явах нийтийн тээврийн зардлыг нийслэлийн төсвөөс санхүүжүүлэхээр болов. Нийтийн тээврийн хэрэгслээр хичээлдээ явах зайлшгүй шаардлагыг хангаж байгаа оюутан картаа захиалж, мэдүүлэг бөглөх бөгөөд нутгийн захиргааны байгууллага тухайн сурагч, оюутанд хичээлдээ ирж буцахдаа



нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих тодорхой тооны эрх бүхий карт олгож сар бүрийн 1-ний өдөр цэнэглэж өгч байхаар зохицуулжээ.

ОЛОН НИЙТИЙН БОЛОВСРОЛ

Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, БСШУЯ, их дээд сургуулиуд болон санхүүгийн зах зээлийн оролцогч холбогдох төрийн бус байгууллагуудтай хамтран “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг боловсруулж, хэрэгжүүлэхээр болов. Хөтөлбөрийн зорилго нь санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн сахилга батыг өндөржүүлэх, шударга өрсөлдөөнийг бэхжүүлэх, санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүртээж

Тус хөтөлбөр хэрэгжсэнээр иргэдийн санхүүгийн сахилга батыг сайжруулах, санхүүгийн зөв шийдвэр гаргах чадварыг дээшлүүлэх, урт хугацаатай хуримтлал болон санхүүгийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, санхүү, банкны системд итгэх олон нийтийн итгэлийг дээшлүүлэх, цаашлаад Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлт хөгжлийг дэмжих боломжтой болно. Дэлхийн банкнаас 2012 онд Монгол Улсын санхүүгийн салбар дахь бүтээгдэхүүн үйлчилгээг хүртэж буй харилцагчид тэдгээрийн эдийн засаг, санхүүгийн мэдлэг, боловсролын өнөөгийн байдлыг олон улсын түвшинтэй харьцуулан судалсан байна. Судалгаанд хамрагдагсдын 30 орчим хувь нь хүүгийн талаар, 60-аас дээш хувь нь инфляци хадгаламжид нь хэрхэн нөлөөлөх талаар огтхон ч ойлголтгүй байжээ. Нийт хүн амын 50-иас бага хувь нь даатгал болон валют арилжааны талаар, 30 хүрэхгүй хувь нь МХБ-ийн бүтээгдэхүүнүүдийн



талаар мэдэж байжээ.

ДЭЛХИЙД

ХЯТАД -ОРОСЫН САНХҮҮГИЙН ЗӨВЛӨЛ

Хятадын дорно умард хязгаарт орших Хар мөрөн мужын Харбин хотноо Хятад-Оросын санхүүгийн зөвлөл байгуулагдлаа. Тус зөвлөл Оросын 17, Хятадын 18 санхүүгийн



байгууллагаас бүрдэж байгаа бөгөөд Хятадын хувийн өмчийн банк болох Харбины банк болон Оросын Сбербанкны санаачилгаар байгуулагджээ. Уг байгууллагын гол зорилго нь хил дамнасан худалдааг дэмжих. Үүнээс гадна харилцаа, хэлэлцээр, мэдээлэл солилцоо, дотоодын мөнгөн тооцооны механизм, санхүүжилтийн механизм болон цахим худалдаа зэрэг шинэ салбарыг дэмжих зорилготой юм. БНХАУ нь ОХУ-ын хамгийн том худалдааны түнш бол ОХУ БНХАУ-ын ес дэх том түнш билээ. Ялангуяа АНУ болон Европын Холбооны улсууд эдийн засгийн хориг арга хэмжээ авснаас хойш, ОХУ дорно зүг рүү анхаарлаа хандуулж эдийн засгийн боломжуудыг хайж эхэлсэн бөгөөд ингэснээр хоёр орны худалдаа өсөн нэмэгдэж 2014 онд хамгийн өндөр түвшинд буюу 95.3 тэрбум ам.долларт хүрчээ.

“ВОЛЬКСВАГЕН”-Ы УТАА ЯЛГАРУУЛАЛТ



"Вольксваген"-ы утаа ялгаруулалтын дуулиан одоог хүртэл үргэлжилсээр байгаа бөгөөд тус компанийн чанар хариуцсан тав дахь захирал аравдугаар сарын 20-нд ажлаасаа халагджээ. Есдүгээр сард АНУ-ын Байгаль орчныг хамгаалах агентлаг тус компанид цэвэр агаарын тухай хуулийг зөрчсөн тухай мэдэгдэл хүргүүлсэн юм. Байгаль орчныг хамгаалах агентлаг Вольксваген компани лабораторийн утаа ялгаруулалтын туршилтыг хууран мэхлэхийн тулд хөдөлгүүрийн тодорхой хэсгүүдийг програмчилж байсныг илрүүлсэн аж. Уг хууль бус програмчлал нь туршилтаар азотын ислийн ялгаруулалтын стандартад нийцэж байгаа мэт гарч байсан боловч үнэн хэрэгтээ 40 дахин их хий ялгаруулж байжээ. Тус компани энэхүү

програмыг суулгаснаас хойш буюу 2009 оноос 2015 он хүртэл дэлхий даяар 11 сая автомашин үйлдвэрлэсэн байна. Компанийн хэд хэдэн өндөр түвшний албан тушаалтнууд, тэр дотор "Вольксваген" группын гүйцэтгэх захирал албан тушаалаасаа буусан бөгөөд шинэ удирдлагууд сонгогджээ. Компанийн зүгээс энэ хугацаанд үйлдвэрлэсэн 11 сая автомашиныг дахин тоноглоно гэж зарласан ч үүнийг хийхэд ихээхэн цаг шаардагдах юм. Хэдийгээр тус компани урьд өмнө орж байгаагүй хүнд байдалд орсон ч германчууд "Вольксваген"-д итгэл хүлээлгэсэн хэвээр байгааг Германы "Bild" сонингоос явуулсан судалгаанаас харж болох.

ВЕНЕСУЭЛИЙН ХЯМРАЛ

Венесуэл улс эдийн засгийн хямралтай байгаа бөгөөд ОУВС-гийн таамаглаж буйгаар Энэ онд тус улсын ДНБ 10 хувиар агшиж тус онд хамгийн их эдийн засгийн хохирол амсах улс болно гэжээ. Тус улсын Ерөнхийлөгч



Николас Мадуро өссөөр байгаа инфляцийг хязгаарлах зорилгоор үнийн хяналтыг сайжруулна гэдгээ амлажээ. Хэдийгээр Мадурогийн засгийн газар 2015 онд инфляци 85 хувьтай, 2016 онд 60 хувьтай байна гэж тооцоолсон ч Мүүдис зэрэг байгууллага тус улсын инфляци гурван оронтой тоотой байна гэсэн таамаглалыг дэвшүүлсэн аж. Ерөнхийлөгч үнийн хяналт бүх бараа болон үйлчилгээг хамарч эхэлнэ гэж мэдэгдсэн бөгөөд ашгийн хэмжээ 30 хувиас давахгүй гэсэн боловч хэрэгжилтийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг өгсөнгүй. Газрын тосны үнийн уналт тус улсын эдийн засаг болон төсвийг улам хүндрүүлсээр байна. ОПЕК-ийн гишүүн Венесуэл улсын ДНБ-ий дөрөвний нэгийг газрын тос эзэлдэг юм. Тус улсын парламентын сонгууль

арванхоёрдугаар сард болох бөгөөд урьдчилсан санал асуулгаар сөрөг хүчин ялалт байгуулах магадлалтай байгаа юм. Учир нь иргэд одоогийн засгийн газрыг хямралыг даван туулахад хангалтгүй ажиллаж байна гэж үзэж байгаа аж.

ХЯТАД-АВСТРАЛИЙН ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ ГЭРЭЭ

Австралийн Төлөөлөгчдийн хурал Хятад-Австралийн чөлөөт худалдааны гэрээг (ChAFTA) аравдугаар сарын дундуур баталжээ. Тус худалдааны гэрээний гол зохицуулалт нь шилжих хөдөлгөөний зохицуулалт бөгөөд Австралийн Хөдөлмөрийн намаар удирдуулсан эвслийн засгийн газар шинэчлэлт хийхийг зөвшөөрч гадаад ажилчдыг хайж эхлэхээс өмнө австраличуудыг ажилд авах талаар хүчин чармайлт хийх болно гэжээ. Мөн гадаад ажилчдын ажлын нөхцөл австраличуудынхаас доогуур байх ёсгүй зэрэг хуулийн өөрчлөлт ч орох аж. Худалдааны гэрээнд зургаадугаар сард Тони Абботт Ерөнхий сайдаар



ажиллаж байх үед гарын үсэг зурсан боловч хэрэгжиж эхлэхийн тулд хууль тогтоох байгууллагын зөвшөөрөл шаардлагатай байсан юм. Зургаадугаар сараас аравдугаар сарын хооронд гэрээний талаарх хэлэлцээр ширүүн өрнөж байсан бөгөөд экс Ерөнхий сайд сөрөг хүчинтэй зөвшилцөх хүсэлгүй байсан бол шинэ Ерөнхий сайд Малколм Турнбалл хэлэлцээр хийх үүд хаалгыг нээлттэй болгож өгсөн юм. Хууль батлагдсаны дараа ч Австралийн зарим үйлдвэрчний эвлэлийнхэн уг гэрээг эсэргүүцсэн хэвээр байгаа аж. Харин бизнесийнхэн энэхүү гэрээг эерэгээр хүлээн авсан бөгөөд Хөдөлмөрийн нам болон сөрөг хүчин зөвшилцөлд хүрч чөлөөт худалдааны гэрээг баталж чадсандаа баяртай байгаа юм. ■



“ТӨСӨВ-2016”

Хөрсөн дээрээ буух цаг

Ц.Буян

Төсөв батлах процесс асуудалтай, тооцооллоо муу хийдгээс орлого дутдаг, төлөвлөгөө биелдэггүй гэх шүүмжлэл бий. Хэдий өдгөө эдийн засгийн байдал тун бараан байгаа ч УИХ-д өргөн бариад буй 2016 оны төсвийн төсөлд нэлээд гэгээлэг төсөөллүүд тусгажээ. Тухайлбал, “Уул уурхайн томоохон төслүүдийн хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлснээр төсвийн орлого нэмэгдэх боломжтой” хэмээсэн нь сонгуулийн жилийн “поп” улс төрийн шуугиан дунд биелэх магадлал хэр их бол гэсэн эргэлзээ төрүүлнэ.

Мөн “Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хууль хэрэгжиж эхэлснээр далд эдийн засаг буурах, татвар төлөгчийн илрээгүй байсан орлого, хөрөнгө ил болж, тэдгээрийг

хууль ёсны бүртгэл хяналтад оруулж татварын бааз суурь өргөжсөнөөр ирэх онд татварын орлого нэмэгдэх боломж бүрдэнэ” гэжээ. Гэхдээ хямрал, эдийн засгийн хүндрэлийн үед далд эдийн засаг гэгдэж байгаа нуугдмал хөрөнгө хэдийнэ шавхагдсан, байлаа ч төсвийг “түнтийлгэх” хэмжээнд хүрэх магадлал тун бага гэдгийг эдийн засагчид хэлж буй.

Төсвийн орлого 6.9 их наяд төгрөг буюу ДНБ-ий 25.3 хувь, зарлага 7.8 их наяд төгрөг буюу ДНБ-ий 28.6 хувь байхаар төлөвлөжээ. Нийт орлогын 79 хувь нь татварын орлого байх аж. Орлого бүрдүүлэх зарим эх сурвалжаас дурдвал ирэх онд “Оюу Толгой” 774.1, “Эрдэнэт үйлдвэр” 587.5 мянган тонн зэсийн баяжмал, 3023.4 тонн молибдены баяжмал

үйлдвэрлэн борлуулахаар төсвийн төсөлд тусгажээ. Түүхий эдийн үнэ өсөхөөргүй байгаа ч Оюутолгойн олборлолт нэмэгдсэнээр төсвийн орлого нэмэгдэнэ гэж тооцжээ.

Түүнчлэн авто бензин, дизелийн түлшний албан татвараас 11 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлэх аж. Нэг сая тонн авто бензин дизелийн түлш импортлохоор тооцож. Мөн суудлын автомашины импорт 10.8 мянгад хүрч, түүний татвараас улсын төсөвт 51 тэрбум төгрөг төвлөрүүлэх юм.

Гэхдээ үүнээс илүүтэй чухал асуудал бол бодлогын хувьд эдийн засагтаа хэр наалдаж байна вэ гэдэг. Төсөв, мөнгөний бодлогыг уялдаагүй болгож байгаа зүйл нь төсвийг алдагдалтай батлах асуудал. Тухайлбал, ирэх оныг төсвийг 902

тэрбум төгрөгийн алдагдалтай төсөл өргөн барьжээ. Түүнчлэн энэ алдагдал нь ДНБ-ий 3.3 хувийг эзэлж байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн зургадугаар бүлэг дэх “Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх” заалтыг мөн зөрчиж байгаа юм. Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр нь шинээр гаргах 1.3 их наяд төгрөгийн Засгийн газрын дахин санхүүжих үнэт цаас. Өмнөх жилүүдэд гаргасан Засгийн газрын үнэт цаасны үндсэн төлбөрт мөн дээрхтэй ижил хэмжээний төгрөгийг ирэх жил төлөх юм.

Төсвийг их наядын алдагдалтай батлах шалтгаан нь төсвийг тэлэх шаардлага. Монгол Улсын өрсөлдөх чадварыг сулруулдаг гол хүчин зүйл дэд бүтцийг хөгжүүлэхэд төсвийн хөрөнгө оруулалт ихээхэн үүрэгтэй. Гэвч тоон үзүүлэлтээс харахад төсөв тэлсэн жилүүдэд инфляци өсч, агшсан жил нь буурч байсан зүй тогтол ажиглагдана. Ялангуяа сонгуультай жилүүдэд төсвийн тэлэлт огцом ихэсч, 10, 20 хувь давсан өндөр инфляци үүсч байжээ. Тэгэхдээ эдийн засаг жил бүр 17-20 хувь өсөх юм шиг гэгээлэг төсөөллөөр баясгаж байв.

Түүний зэрэгцээ Монгол Улсад их хэмжээний гадаадын шууд хөрөнгө оруулалт урсан орж ирсэнд урамшсан удирдлагууд төсвөө улам алдагдалтай батлаж иржээ. Өмнөх жил нь 4.6 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт Монголд орж ирэхэд 2012 оны төсвийн зарлагыг 1.3 их наяд төгрөгөөр нэмж, төсвийн тэнцлийг 1.2 их наяд төгрөгийн алдагдалтай баталсан байх юм. Төсвийн зарлага нь орлогоороо санхүүжих ёстой. Орлого нь зарлагаа нөхөж дийлэхгүй бол үлдсэнийг зээл, тусламжаар санхүүжүүлнэ. 2011 оноос хойш өнөөг хүртэл нийт төсвийн алдагдал 3.5 их наяд төгрөгт хүрээд байна. Энэ нь өнөөдөр Монгол Улс яагаад өрийн дарамтанд орох болсны тайлбар болно.

Энэ их тэлэлт нөгөө талдаа хувийн хэвшлийнхэнд хүссэн хүсээгүй татварын дарамт болж очиж байна. Түүний хэрээр аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулахад бэрхтэй болж,

Банк санхүүгийн байгууллагуудын зэсийн үнийн төсөөлөл /ам.доллар тонн/

№	Байгууллага	Төсөөлөл
1	Barclays PLC	5,625.0
2	IMF	5,138.7
3	Westpac	5,272.0
4	Standard chartered	5,325.0
5	Intesa Sanpaolo SpA	5,138.0
6	Itau Unibanco Holding SA	5,150.0
7	Toronto-Dominion Bank/Toronto	5,232.2
	2016 оны төсөвт	5,268.7

Уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үнийн төсөөлөл

Нэр төрөл	Хэмжих нэгж	Биег хэмжээ	Үнэ
Алт	тонн	23.6	1,156 \$/унци
Экспорт	тонн	10.1	
Дотоод	тонн	13.5	
Нүүрс (экспорт)	сая тонн	19.5	32.8-54.8 \$/тн
Цайр	мян тонн	95.0	2,200 \$/тн
Зэсийн баяжмал	мян тонн	1,361.6	5,268.7 \$/тн
Төмрийн хүдэр	мян тонн	5,000.0	34.8-43.2 \$/тн

Татварын орлого зарлагын харьцаа /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2013 он	2014 он	2015 оны эхний хагас жил гүйц	2015 ХБГ	2016 төл
Нийт татварын орлого	5,072.7	6,145.1	2,530.5	5,145.7	5,527.0
Нийт татварын зардлын хэмжээ	359.7	720.9	264.7	622.3	675.3
Нийт татварын зардлын татварын орлогод эзлэх хувь	7.1%	11.7%	10.5%	12.1%	12.2%

Хувьчлах байгууллага, худалдах объектийн жагсаалт /тэрбум төгрөг/

Өмч хувьчлалын орлого	2016 он
A.1. Хувьчлах байгууллага	80.0
1. Төрийн банк	75.0
2. Хөрөнгийн бирж	5.0
A.2. Худалдах объектууд	91.0
Нийт дүн	171.0

Эх сурвалж: Сангийн яам

тэндээс ажилгүйчүүдийн эгнээнд шилжигсэд нэмэгдсээр.

Энэ жилийн төсвийн урсгал зардал 92 хувийн биелэлттэй байна. Энэ нь цалин хөлс, нийгмийн даатгал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал зэрэг ажил гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай зарлага юм. Гэтэл хөрөнгийн зардлын гүйцэтгэл ердөө 50 хувьтай байна. Үүнд барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, төсвөөс эргэн төлөгдөх хөрөнгө оруулалт буюу концессын гэрээний дагуу төлөх зардал зэрэг багтана. Орлогын биелэлт төлөвлөсөндөө хүрэхгүй байгаагаас ирээдүйн хөгжлийн хөшүүрэг болох дэд бүтцийн бүтээн байгуулалтын зардлыг “гэвчихэд” хүрч байна.

Гэвч одоогийнхоос илүү хэмнэж, хасч, хойшлуулах боломжгүй тул улс төрийн өндөр албан тушаалтнуудын цалинг бууруулах, төсөвт тодотгол хийх саналыг Ерөнхий сайд дэвшүүлсэн.

Ирэх оны төсөвт ч урсгал зардлаа багасгах шаардлагатай байгааг онцолж байна. 2010-2013 онд төрийн захиргааны байгууллагуудын орон тоо ихээр нэмэгдэж, бүтэц томорсон. Эдийн засгийн өсөлтийг даган бий болсон бүтэц сааралтын үед чиг үүргийн давхардлыг бий болгож төсвийн үр ашгийг бууруулж байна гэж үзжээ.

Иймээс төсвийн алдагдлыг бууруулах бодлого баримтлах аж. Тухайлбал, 2016 оны наймдугаар сарын 1-нээс яамдын тоог өс болгож, Мэдээллийн технологи, шуудан харилцаа холбооны газрыг татан буулгах бол нэгдүгээр сарын 1-нээс эхлэн Төрийн өмчийн хороо, Худалдан авах ажиллагааны газар, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс зэрэг байгууллага, агентлагуудыг татан буулгах санал оруулаад байна. ■

“MONGOLIAN ECONOMY”-ИЙН АСУУЛТ

АСУУЛТ: СОНГУУЛИЙН ЖИЛИЙН ТӨСВИЙГ АЛДАГДАЛГҮЙ БАТАЛЖ ЧАДАХ БОЛОВ УУ. ТӨСВИЙН ХАРИУЦЛАГА, САХИЛГА БАТЫГ ХАНГАХЫН ТУЛД ЮУНД АНХААРАХ ЁСТОЙ ВЭ?

Ц.Даваадорж /Эдийн засагч, доктор/



-Төсвийг алдагдалгүй батлах боломжтой. Сонгууль болох гэж байгаа учир гэдэг ч юм уу, улс төрийн шалтгаан байж болох ч эдийн засгийн нөхцөл байдлаас харж, ирээдүйгээ бодсон шийдвэр гаргах хэрэгтэй.

Төсвийн сахилга бат, хариуцлагыг сайжруулахын тулд миний бодлоор төсвийн байгууллагуудыг өөрсдөө тодорхой хэмжээний орлого олж, түүнийгээ өөрөө мэдэж зарцуулах эрхийг нээж өгөх. Төвлөрсөн төсөв байгууллагуудыг хэт хамааралтай, төсвийн санхүүжилтийг харсан идэвхгүй болгож байна. Их мөнгө татан төвлөрүүлж, буцааж тараадаг зарчим нь хэт ачаалалтай байгаа учраас сахилга бат сулрах шалтгаан болж байна. Харин ийм ийм тодорхой зардлыг төсвөөс гаргах боломжгүй гэж зааж өгөөд, байгууллагын орлогоос шууд зарцуулах боломжийг нээж өгснөөр төсвийн ачаалал багасч, сахилга бат сайжирна. Ялангуяа төрийн үйлчилгээний байгууллагууд, шинжлэх ухааны байгууллагууд үйл ажиллагаагаараа орлого олох боломжтой. Харин захиргааны байгууллагуудын хувьд энэ нь зохимжгүй.

Б.Мөнхсоёл /Үндэсний стратегийн хүрээлэнгийн гүйцэтгэх захирал/

-Нөхцөл байдлыг бодитоор харвал боломж багатай. Уг нь Төсвийн

тогтвортой байдлын тухай хуулийг төсвийн алдагдлыг аль болох бага байлгахыг зорьж гаргасан. Гэвч эдийн засаг санхүүгийн нөхцөл бүрдээгүй учраас хуулиа өөрчилсөн шүү дээ. Үүнд хэд хэдэн шалтгаан байна.

Нэгдүгээрт, өнөөдөр эдийн засгийн хүндрэлтэй байдлаас болоод компаниуд ажлын байраа цомхтож, зарим нь хаалгаа барьсан. Гэтэл төсвийн орлогын гол эх үүсвэр аж ахуйн нэгжийн орлогын албан татвар болон хүн амын орлогын татвар. Аж



ахуйн нэгжүүд нь санхүүгийн нөхцөл байдал хүнд байгаа, ажлын байраа хадгалж чадахгүйгээс төлөвлөсөн хэмжээгээр орлого бүрдэхгүй байх нөхцөл байдал бий болоод байна.

Хоёрдугаарт, Монгол Улс өрөнд баригдчихлаа гэдгийг бүх хүн ярьж байна. Чингис бонд, Самурай бондын эргэн төлөлтийн хугацаа болж байгаа учир юун Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг мөрдөх манатай болно. Бондын хөрөнгийг эргэж төлөгдөх ашигтай төсөлд хуваарилж чадаагүй, зарцуулалт муу хийсний үр дүн эргээд төсөвт дарамт болж байна.

Гуравдугаарт, УИХ-ын гишүүд хязгааргүй эрх мэдэлтэй байна. Сангийн яам болон мэргэжлийн хүмүүс төсвийн төслөө боловсруулаад өргөн барихад нь улс төрийн зорилгоор дураараа өөрчилдөг. Нөхцөл байдал ямар байгааг мэдсээр байж тойрогтоо нэр хүнд олохын төлөө л эрх мэдлээ ашиглаж байна.

Дөрөвдүгээрт, хэлсээр, ярьсаар байгаад алдаатай баталдаг. Түүнээс болоод төлөвлөгөө биелэхгүй төсөвт жилдээ нэг бус удаа тодотгол хийхэд хүрч байна.

Тавдугаарт, хамгийн том эрсдэл сонгууль болох гэж байна. Эдийн засгаа бодох уу, эсвэл эргэж сонгогдохоо бодох уу. Үүнийг эдийн засагч, энгийн хүмүүс хэлж чадахгүй. Ямар ч хяналтын тогтолцоо байхгүй байна. Хариуцлага хяналтын тогтолцоог сайжруулах, төсвийн мөнгийг хууль бусаар зарцуулж байгаа хүмүүст нь хариуцлага тооцох, гишүүдийг эргэж татдаг механизмтай болох зэрэг олон жил яригдаж байгаа асуудлыг шийдэхээс нааш төсөв хариуцлага, сахилга баттай болохгүй.

Ж.Үнэнбат /Компанийн засаглалын хөгжлийн төвийн гүйцэтгэх захирал/



-Төсвийг алдагдалгүй батлах нь юу л бол. Уул уурхайн бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс шалтгаалж эдийн засаг сэргэж байсан үед ч алдагдалтай л баталж ирсэн. Ер нь алдагдалгүй төсөв баталж байсан түүх байхгүй. Алдагдалгүй төсөв батлах тухай санаа нь үнэхээр чин сэтгэлээс гарсан бол эрүүл үзэгдэл бөгөөд төсвийн тогтвортой байдалд чиглүүлэх чухал алхам гэж үзэж байна. Түүгээр ч зогсохгүй төсвийг дунд хугацаанд тэнцвэржүүлэх бодлогоо тууштай баримтласай гэж хүсэх юм. Харин

тэгж чадах эсэх нь улс төрийн эр зоригоос хамаарах, Засгийн газар гэхээс илүү УИХ төсөв батлахад давамгайлдаг тул эргэлзээ төрүүлдэг. Засгийн газраас өргөн барьсан төсөвт аливаа зардал нэмэхийг хориглосон зохицуулалт хэрэгтэй.

Н.Дашзэвэг /Монгол дээд сургуулийн захирал, академич/



-Ирэх жилийн төсвийг алдагдалгүй баталчихвал 2017, 2018 оны гадаад өрийг төлөхөд сайн нөлөө үзүүлэх юм. Одоо ахиж өр нэмэх хэрэггүй ээ. Тэгээд төсвийг хэтрүүлж зарсан албан тушаалтанд нь хариуцлага тооцож, ажлаас нь халдаг болж байж сахилга

баттай болно.

Л.Ариунаа /Удирдлагын академийн тэнхмийн эрхлэгч, дэд профессор/

-Эдийн засгийн байдал хүнд байгаа учир алдагдалгүй батлах гэж хичээх хэрэгтэй. Гэхдээ зайлшгүй шаардлагатай хөрөнгө оруулалтыг хамаагүй хасч танаж болохгүй.



Хуульдаа захирагдаж л ажиллах ёстой. Ирэх оны төсвийн төслийг харахад зарим хөрөнгө оруулалт нь зайлшгүй биш, тэвчиж болохоор харагдаж байна. Алдагдлыг заавал хязгаарт нь тултал өндөр байлгах шаардлагагүй.

Төсвийн сахилгыг сайжруулъя

гэвэл ил тод байлыг сайжруулах хэрэгтэй. Иргэдэд ойлгомжтой сайн мэдээлэл өгөх, тэдний татварын мөнгийг нь юунд зарцуулж байгааг мэдэх эрхтэй. Мөн шийдвэр гаргагчдад маш сайн мэдээлэл өгөх ёстой.

Өнөөдөр манай төсөв хэтэрхий задгай байна. Задгай гэдэг нь олон хуудастай, эмх цэгцгүй, мэргэжлийн бус байтугай мэргэжлийн хүн үзээд шууд дүгнэлт хийх боломжгүй. Нэлээд их цаг хугацаа зарцуулж байж дүгнэлтэд хүрэх хэрэгтэй болно. Одоогийн төлөвлөж байгаа байдал нь, нэг хөтөлбөрийн нэр тавьчихаад ард нь нэг тоо бичдэг.

Түүнийгээ интернэтэд байршуулчихаад ил тод болчихлоо гэж андуурч байна. Эдийн засгийн тооцоолол тодорхой байх. Тэр тоо юунд үндэслэж гарч ирсэн нь шууд хараад ойлгогдохоор байх. Тэгж байж, иргэд төлсөн татвар нь ямар зүйлд зарцуулагдаж байгаа, тэр нь зөв, энэ нь буруу гэж хэлэлцэх боломжтой болно. Тийм нөхцөл бүрдээгүй болохоор захиран зарцуулагчид хүний мөнгөнд нэлээд үрэлгэн байх шиг. ■

МӨНГӨНИЙ БОДЛОГО

Төсөвт анхаарсан мөнгөний бодлого

Ц.Элбэгсайхан


Эдийн засгийн байдал дордсоор буй энэ үед бизнес эрхлэгчдийн зовлон нь зээл авах, зээл төлөх болжээ. Монголын хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчээр ажиллаж байсан Д.Ангар “Чанаргүй зээл өссөөр байгаа нь банкуудыг зээл олгох нөхцлөө чангатгахад хүргэж байна” хэмээсэн юм. Нэг үгээр хэлбэл, зээл авна гэдэг нь нэлээд зоригтой аавын хүүгийн хийх ажил болж хувирчээ. Есдүгээр сард

олгосон зээлийн дундаж хүү жилийн 18.7 хувь байх жишээтэй.

Монгол Улсад зээлжих зэрэглэлээр хамгийн найдвартай гэж үнэлэгдэх Засгийн газрын гаргаж буй үнэт цаасны хүү жилийн 15 хувь. Богино хугацаат зээлийг Засгийн газар нь ийм өндөр хүүгээр авч байгаа тохиолдолд хувийн хэвшил урт хугацаатай, бага хүүтэй зээл авах нь бараг мөрөөдөл болж хувирна. Учир нь урт хугацаат зээлийн эрсдэл их учир хүү ямагт

өндөр тогтдог бол хувийн хэвшил зээлжих зэрэглэлээр сул учир Засгийн газраас бага хүүтэй зээл авах боломж тэг хувь. Тиймээс богино хугацаатай, өндөр хүүтэй Засгийн газрын бонд банкуудын хувьд салж чадахааргүй “амттан” болж байгаа аж.

Өнгөрсөн оны мөнгөний бодлогод тусгасанчлан жилийн инфляци нэг оронтой тоонд багтаж, зорилтот түвшин долоон хувиас доош ороод байна. Онолоор бол инфляци, мөнгөний



хүү харилцан хамааралтайгаар өсч буурдаг. Инфляцийн түвшин ингэж буурч байхад эсрэгээрээ зээлийн хүү өссөөр байгаа нь гажууд гэмээр үзэгдэл болж байна. Зээлийн дундаж хүү есдүгээр сарын байдлаар жилийн өмнөх үеэс 0.4 нэгж хувиар өсчээ. Гэтэл инфляци жилийн өмнө 13 хувьтай байв. Харин өнгөрсөн есдүгээр сарын инфляци 4.9 хувь.

Ийнхүү инфляци, зээлийн хүү хоёр туйл руу тэмүүлэх болсон гол шалтгаан нь бодлогын хүүн дээр зангилагдаж байна гэж Д.Ангар үзэж байгаа юм. Төв банк бодлогын хүүг 2013 оны зургадугаар сарын 24-нөөс хойш хоёр ч удаа өсгөсөн. Өнөөдөр бодлогын хүү 13 хувь байгаа бөгөөд Төв банкны үнэт цаасны дундаж хүү 13.1 хувь байна. Ийм тохиолдолд Засгийн газар бага хүүтэй бонд гаргах боломжгүй болж, энэ нь хувийн хэвшлийнхэнд дам дарамт болж буй аж. Энэ “түгжээг” мулталж, бодлогын хүүг инфляцийн түвшин рүү ойртуулж байж Засгийн газар ч, хувийн хэвшил ч бага хүүтэй зээл олж чадах бөгөөд нөгөө талд банкуудын зээлийн чанар сайжирч,

тогтолцоо бүхэлдээ эрүүлжих ажээ.

Инфляци буурч, гадаад худалдаа, урсгал данс, төлбөрийн тэнцлийн алдагдал буурч, зарим нь ашигтай гарч байхад мөнгөний бодлого улам хатуурч байгаагийн цаана ч мөн шалтгаан буй. Мөнгөний бодлого боловсруулагчдын зүгээс өгч буй тайлбар нь төсвийн бодлого хэт зөөлөн явж ирсэнтэй холбоотой юм. Сүүлийн жилүүдэд төсөв их хэмжээгээр тэлж, түүний хэрээр алдагдал өссөөр ирсэн. Энэ алдагдал зах зээл дээр ам.долларын эрэлт бий болгож, төгрөгийн ханш сулрах шалтгаан болж байгаа учир мөнгөний бодлогыг хатууруулах шаардлагатай болжээ.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2016 онд баримтлах бодлогын баримт бичиг”-ийг боловсруулахдаа дээрх нөхцөл байдлыг залруулахад чиглүүлжээ. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2016 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын тогтоолын төсөлд “... төсвийн нэгдмэл байдлыг хангасан зохистой бодлого хэрэгжүүлж улсын төсвийг алдагдалгүй байлгаж...” гэж тусгасан байна. Хатуу

бодлого хэрэгжүүлж ирсний үр дүнд макро түвшин харьцангуй тогтвортой болж ирсэн тул үүнийгээ хадгалах нь чухал. Гэхдээ эдийн засгийн ихээхэн ачааг үүрч яваа хувийн хэвшлийнхнээ дэмжих бодлого хэрэгтэй. 2018 оныг хүртэл инфляцийг 5-7 хувь байлгах зорилт тавьж байгаа аж. Монголбанкны зүгээс импорт огцом өсөхгүй бол ханшийн огцом өсөлт бий болохгүй, инфляци зорилтот түвшинд тогтох бололцоотой гэж тооцсон байна. Энэ нөхцөлд төсвийн бодлогыг хатууруулж, төсвийг хариуцлагатай болгосноор бодлогын хүүг суллах боломж нээгдэх аж. Ингэж чадвал Д.Ангарын хэлсэнчлэн хэн хэнд харилцан ашигтай нөхцөл бүрдэж, тогтолцоо доголдолгүй урагшлах гарц харагдаж байна. Монгол Улс ойрын хугацаанд зээлээр санхүүжих эрх зүйн гарц үгүй. Тиймээс эдийн засгийн энэ мухардлаас гарах үлдсэн ганц сонголт нь төсвийг алдагдалгүй батлах болж байна. Цаашид зээлийн санхүүжилтад найдалгүйгээр төсвөө алдагдалгүй баталдаг болчихвол эдийн засаг “тэгшрэх” боломж байсаар. ■

ТООН МЭДЭЭЛЭЛ

ЭДИЙН ЗАСГИЙН ЭЭРЭГ/СӨРӨГ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН 2007-2015/06



Эх сурвалж: YCX, Сангийн яам, Монголбанк, Гаалийн Ерөнхий газар



Олон улсын валютын сангийн Захирлуудын зөвлөлийн Ази, Номхон далайн орнуудыг хариуцсан гүйцэтгэх захирлын зөвлөх.

Т.Доржханд:

Хүндээ оруулсан хөрөнгө оруулалтын өгөөж хамгийн өндөр байдаг. Энэ нь монгол төрийн бодлого байх ёстой

Д.Бэхбаяр

Тогмидын Доржханд. 1977 онд төрсөн. Нийслэлийн 2-р дунд сургууль, МУИС-ийг Төрийн санхүүгийн чиглэлээр төгссөн бол Японы Хитоцубаши Их Сургуульд Төрийн бодлого, эдийн засгийн онол мэргэжлээр магистрт суралцаж дүүргэсэн. Тэрбээр 1999 онд Сангийн яамны Төсвийн бодлогын газарт мэргэжилтнээр орсон цагаас тус яаманд 15 жил ажиллажээ.

Түүний ажиллаж байсан албан тушаалаас дурдвал, Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлого, зохицуулалтын хэлтэст мэргэжилтэн, Зээл тусламжийн нэгдсэн бодлого зохицуулалтын газрын дэд дарга, Төслийн санхүүжилт, өрийн удирдлагын газрын дарга, Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газрын дарга,

Япон улсын Сангийн яамны Үндэсний татварын агентлагт дадлагажигч ажилтан, АХБ-ны Засгийн газрын худалдан авах ажиллагааны төслийн зөвлөх, тус банкны Төв Азийн бүс нутгийн Эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн зохицуулагч, НҮБ-ын “Их түмэн бүс” хөтөлбөрийн үндэсний зохицуулагч зэрэг болно. Харин 2013 оноос АНУ-ын Вашингтон хотноо Олон улсын валютын сангийн Захирлуудын зөвлөл дэх Ази, Номхон далайн орнуудыг хариуцсан гүйцэтгэх захирлын зөвлөхөөр ажиллаж байна.

Мөн тэрбээр Оксфорд, Харвардын их сургуулиудад санхүүгийн онол, төслийн санхүүжилт мэргэжлээр сурч, мэргэжил дээшлүүлжээ.

ӨДӨРТ 18 ЦАГ АЖИЛЛАЖ, АЖЛААР НУХЛУУЛЖ БАЙСАН ЗАЛУУСЫН НЭГ, БИ

-Монголоос ОУВС, Дэлхийн банкинд цөөнгүй монгол ажилладаг юм билээ. Харин таныг дэлхийн хэмжээний санхүү, эдийн засгийн байгууллагын удирдлагын түвшинд хүрч ажиллаж буй анхны монгол гэж ойлгоод байгаа.Тус байгууллагад ажиллах болсон шалтгаан нь юу байна, ямар ажлын шаардлага тавигддаг вэ?

-Өмнө нь ОУВС-гийн Удирдах зөвлөлд монгол хүн ажиллаж байсан эсэхийг сайн мэдэхгүй байна аа. Дэлхийн банкинд бол ажиллаж байсан. Ер нь хүсэл зорилго байвал хэн ч ажиллаж болох нээлттэй талбар шүү дээ. Миний хувьд 1999 онд Сангийн яаманд орсон цагаас эхлэн энэ байгууллагад ажиллаж, туршлага хуримтлуулах битүү мөрөөдөлтэй болсон. Тухайн үед ОУВС-гийн эдийн засагчид Монголд ирэхэд нь бодлогын олон шийдэл дээр хамтран ажилладаг байлаа. Нуулгүй хэлэхэд бид ч бас тэднээс маш их суралцсан.

Энэхүү албан тушаалд эдийн засгийн онолын мэдлэг, бодлого боловсруулах туршлага, өөрийн болон бүс нутгийн орнуудыг төлөөлж ажиллах боломжтой зэрэг мэргэжлийн шаардлага тавьдаг. Мөн өмнө нь өөр улсад ажиллаж байсан эсэх, англиас бусад хэлний мэдлэгтэй бол давуу тал гэж үнэлэгддэг. Ер нь олон улсын байгууллагуудад тавьдаг ерөнхий шалгууруудыг бүгдийг л давах хэрэгтэй болно.

-Олон улсын санхүү, мөнгөний харилцааг зохицуулдаг байгууллагын удирдлагын түвшинд ажиллах нь монгол хүнд маш их туршлага, мэдлэг өгөх нь мэдээж. Ямархуу туршлага, мэдлэг мэдээлэл олж авсан бол?

-ОУВС-гийн төвд ажиллана гэдэг нь маш их мэдлэг, туршлага олж авдаг юм байна. Тиймээс аль болох олон монгол ирж ажиллаасай гэж хүсэж байна. Дэлхийн санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах үндсэн зорилготой байгууллага учраас дэлхийн хэмжээний сайн мэргэжилтэн, судлаачид ажилладаг. Мэргэжлийн хувьд ч ихэд бэхжсэн

байгууллага. Энд ажиллахын давуу тал нь тухайн улс орнуудын эдийн засгийн бодит мэдээлэл, судалгааны бааз архив нь маш баялаг, тэдгээр нь ажилтнууддаа нээлттэй байдаг. Тиймээс тус байгууллагын нийт эдийн засагчийн 95 хувь нь Ph.D зэрэгтэй бөгөөд судалгааны ажил хийж, тодорхой бүтээл гаргасан судлаачид болон бодлого боловсруулах ажлын туршлагатай хүмүүс байдаг. Мөн Нобелийн шагналт эдийн засагчид, дэлхийд нэр хүнд бүхий сургуулиудын профессорууд тогтмол ирж лекц уншин, онолын маргаан өрнүүлнэ. Эдгээр нь тус байгууллагын ажилтнуудыг хөгжүүлэх, тэдгээрийн бүтээмжийг ихэд дээшлүүлэхэд чиглэдэг. Би энэ байгууллагын бүтэц, ажлын стандартууд болон системийг сонирхон судалж байгаа. Олон улсын стандартыг өөрийн улс руу шингээх шаардлагатай бөгөөд үүний тулд тэр бүтцэд нь ажиллаж туршлагажсан

“ Шинэ өсөлтийн онолоор хүн, хүний мэдлэг нь голлох хүчин зүйл юм гэж тайлбарласнаараа онцлог. Хязгаарлагдмал нөөцийг хүнээр, тэдний мэдлэг чадвараар өсгөх боломжтой гэсэн санаа. ”

байвал тухайн жишгийг маш хялбараар тогтоож болно гэж боддог.

Миний хувьд Захирлуудын зөвлөлөөр хэлэлцэж байгаа аливаа бодлогын бичиг баримт болон гишүүн орнуудын эдийн засгийн үнэлгээ дээр голчлон ажиллаж байна. Манайхтай төстэй байгалийн баялаг ихтэй улс орнуудын бодлогын алдаа оноо, амжилтуудыг харьцуулж харахад их сонирхолтой дүр зургууд харагдаад байгаа.Тухайлбал, ОУВС нь 188 гишүүнтэй бөгөөд жил бүр гишүүн орнуудынхаа эдийн засгийн байдалд үнэлгээ өгдөг. Дээрх гишүүн орнуудын 45 орчим улс нь байгалийн баялагтай,

түүнийгээ экспортолж амьдардаг бөгөөд ихэнх нь хөгжиж буй орнууд байдаг.

Эдгээр улсад улс төр нь тогтворгүй, засаглал нь сул, чадамжгүй, засгийн эрх барьж байгаа намууд нь дан ганц популист амлалтаар хөөцөлдөж өрсөлдсөөр өөрийн орны эдийн засгаа татан унагасан түүхүүд олон бий. Их танил сонсогдож байна уу. Тэгэхээр гол санаа нь дэлхийгээр дүүрэн манай улстай ижил төстэй гашуун түүхүүд байна. Гагцхүү бид тэдгээрийг уншиж судлаад бодлогодоо авах гээхийн ухаанаар хандаж тусган ажиллах шаардлагатай юм.

-ОУВС-гийн гол зорилго, бодлогын талаар ярина уу. Тус байгууллагын бодлогыг буруушаах, шүүмжлэх хүмүүс олон байдаг. Тухайлбал, АНУ-ын бодлогыг хэрэгжүүлэгч гээд л.

-Үндсэн зорилго нь улс орнуудын мөнгө санхүүгийн хамтын ажиллагааг дэмжих, дэлхийн санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангахад чиглэдэг. Мөн олон улсын худалдаа болон эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгоход анхаарч ажилладаг. Ажил хийж буй аливаа байгууллагуудын хувьд мэдээж шүүмжлэлтэй асуудлууд гардаг.

Тухайлбал, Зүүн Өмнөд Азийн хямралын үед бүх улсад ижилхэн бодлогын "жор" хэрэглэж зарим улсын хямралыг улам хүндрүүлсэн гэж зарим эдийн засагч шүүмжилдэг. Гэхдээ барьж буй бодлого нь аль нэг тал, улс орны эрх ашгийг хамгаалсан гэхээсээ илүүтэй эдийн засгийн онолыг удирдлага болгон ажилладаг гэж ойлгож болно.

Ер нь шийдвэр гаргахад саналын эрхээр Европын орнууд давамгайлдаг, тиймдээ ч гүйцэтгэлийн удирдлага нь Европоос ихэвчлэн томилогддог. Харин сүүлийн үед хөгжиж буй орнууд тухайлбал, БРИКС-ийн орнуудын дуу хоолой болоод тэдгээрийн байр суурь илүү бэхжиж байгаа.

-Та Сангийн яаманд 10 гаруй жил тогтвортой ажиллажээ. Тус яаманд анх орж байсан үеэ дурсвал?

-Миний хувьд Монгол Улсад төрсөн, монгол ахуйд өсөж хүмүүжсэн

монгол хүн. Шилжилтийн үед хүн бүр төрөөс зайлсхийж байх үед би оюутны ширээнээсээ л төрийн бүтцийн яаманд мэргэжилтнээр орж байлаа. Өдөрт 18 цаг ажиллаж, ажлаар нухлуулж байсан залуусын нэг. Үүгээрээ байнга бахархдаг. Ажилдаа анхлан очих өдөр манай яамны Төсвийн бодлогын газрын дарга Л.Дашдорж намайг хүлээн аваад "Сангийн яам чамд өндөр цалин өгөхгүй, орон сууц бол бүр ч өгөхгүй, таван жилдээ сургалтад хамруулахгүй, гэр бүлтэй ч болох цаг чамд бараг л гарахгүй шүү. Харин чамд ажил л өгнө" гэж билээ.

Тэгээд л ажлаа авангуут үнэхээрийн их ажилд дарагдаж байсан даа. Төсөв зохиох үе ч ирж хоёр сарын турш ажил дээрээ хоносон. Усанд орохгүй удахаар хүний биенээс эвгүй үнэр гардаг гэдгийг тэр үед мэдэрч билээ. Ажил амьдралын гараагаа ийм л яамнаас эхэлж, цаг наргүй ажиллаж, хажуугаар нь сурч, суралцахын төлөө зорьж байсны хүчинд битүүхэн мөрөөдөж байсан байгууллагадаа ажиллахад хүрсэн.

-Та Сангийн яамны хоёр ч газрын даргаар ажилласан мэднэ. Эдийн засгийн бодлогын яаманд ямар ажил, төсөл дээр ажиллаж, ямар үр дүнд хүрч байсан бол?

-Төсвийн бодлого, төсвийн хариуцлага, сахилга батыг сайжруулах чиглэлд л их ажилладаг байлаа. Төсвийн орлого тасарсан үед бид татварын орлогын суурийг өргөжүүлэхээр хуулийн олон төсөл дээр ажиллаж, төсвийг хэмнэх талд ч мөн Монголд шинэ шинэ системүүдийг нэвтрүүлсэн нь улсад их хэрэгтэй ажлууд байсан.

Тухайлбал, 2000 оны эхээр бид зарлага санхүүжилтын шинэчлэл хийхээр болж, Засгийн газрын худалдан авах ажиллагааны хуулийн төслийг боловсруулж батлуулан олон журам боловсруулж, өөрийн орны хөрсөнд буулгасан. Үр дүнд нь төсвийн урсгал болон хөрөнгийн зардлыг 5-10 хүртэл хувиар бууруулсан нь тухайн үед олзуурхмаар үзүүлэлт байв. Мөн төрийн өмчийн том компаниуд болон төсөвт байгууллагуудын хооронд шууд гэрээ байгуулдаг явдлыг зогсоож, нээлттэй тендер

шалгаруулалт явуулдаг болсон нь төсвийн хариуцлага, ил тод байдлыг бий болгоход, авлигыг бууруулахад чухал түлхэц үзүүлсэн.

Төрийн албан хаагчийн тангараг өргөөд төрдөө удаан хугацаанд ажиллаад ирэхээр хүний зүрх сэтгэл аяндаа төр, олон нийтийн сайн сайхны төлөө цохилдог, хийж буй ажлаасаа ханамж аваад эхэлдэг юм билээ. Америк руу ирэхээсээ өмнө Өрийн удирдлага болон Баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулсан нь цаг үеэ олсон ажил байж гэж баярлаж явдаг. Эдгээр шинэчлэл нь

шударгаар, хичээнгүйлэн зүтгэх, уйгагүй хөдөлмөрлөж ажиллах тийм л нөхцөлийг төрөөс нь бүрдүүлж, сэтгэлгээнд нь суулгаж өгсөн тул япончууд залхуурна гэдгийг мэдэхгүй байна. Ингэж хөдөлмөрлөж байж улсаа хөгжүүлнэ, улс нь хөгжвөл өөрсдөө сайхан амьдарна гэдгээ мэдэрсэн улс.

Японы засаглалын систем нь Сингапур улсынхтай төстэй. Засгийн газар нь ажилтнууддаа өндөр шаардлага тавьж, төрийн албан хаагчийн олон шалгалт авдаг. Үр дүнд нь түвшин ялгахгүйгээр чадвартай нь төрийн албан хаагч болж, сайн



Нобелийн шагналт эдийн засагч Жорж Акерлофын хамт. 2014 он. АНУ

төсвийн сахилга бат, эдийн засгийн мөчлөг сөрсөн төсвийн дүрмийг бий болгож байгаагаараа урт хугацаанд маш чухал ач холбогдолтой юм аа.

-Таныг Японы Сангийн яаманд ажиллаж байсан гэж сонссон. Японы төрийн бодлогын гол яам хэрхэн ажилладаг, систем нь ямар байдаг, ажилтнууд нь хэрхэн ажилладаг бол гээд л сонирхмоор зүйлс олон байна.

-Тиймээ, Японд сурах үедээ тус улсын Сангийн яаманд нэг жил гаруй хугацаанд дадлагажигч ажилтан хийсэн юм. Онол, мэдлэг, туршлага хуримтлуулах том боломж байлаа. Бид япон хүний хөдөлмөрч, нягт нямбай байдлыг сайн мэддэг боловч хүмүүсийг ажил хийлгэдэг системийг нь харин тэр бүр мэддэггүй болов уу. Иргэд тухайн албандаа үнэнч

ажиллавал албан тушаал дэвшээд явахын хирээр хариуцлага ч нэмэгддэг систем.

Энэ нь 1868 оны Мэйжигийн сэргэн мандалтын үеэс эхлэлтэй бөгөөд өнөөг хүртэл улам батжуулан мөрдсөөр байгаа юм. Товчхоноор хэлэхэд хагас цэргийн зохион байгуулалттай ажиллахыг шаарддаг. Нэгэнт та төрийн ажил хийж буй бол ажил хийхгүй байх, элдэв шалтаг тоочих, өвдөх ч бараг эрхгүй байдаг. Таниас зөвхөн гүйцэтгэл л шаарддаг. Иймд дурын хүн төрд ажиллаж чаддаггүй учир иргэд нь төрийн албан хаагчдаа ихэд хүндэлдэг. Тухайлбал, Сангийн яамны ажилтнуудыг нийгмийн элитүүд гэж нийтээрээ хүлээн зөвшөөрч харьцдаг, ажилтнууд нь ч яаманд ажиллаж буйгаараа бахархаж, илүү сайн үр дүн үзүүлэхийг хичээдэг.

Гол давуу тал нь засаг солигдоход сайдаар ирсэн хэнбугай ч ажилтнуудыг өөрчлөх ёсгүй, бодлого ч тогтвортой явдаг систем. Төрийн залгамж халаа тасардаггүй, маш тогтвортой мөрдөгддөг гэсэн үг. Төрийн бодлогын хувьд улс төрөөс шалтгаалан савлахгүй байх нөхцөлийг хуулиар баталгаажуулсан байдаг.

Тухайлбал, Парламент нь улсын төсвийг хэлэлцэхдээ 10 хувиас дээш өөрчлөлт оруулах эрхгүй бөгөөд хэрэв энэ үзүүлэлт давбал Ерөнхий сайд Парламентаа тараах эрхтэйгээр зохицуулсан байдаг. Ийм

төрийн бодлогын зохицуулалт манайд өнөөдөр зайлшгүй хэрэгтэй байна.

-Та Японд байхдаа Нобелийн шагналт Штиглицийн эдийн засгийн онолын номыг монгол хэлнээ орчуулсан байдаг?

"Төрийн эдийн засгийн онол" нэртэй ном л доо. Японд би Төрийн бодлого, эдийн засгийн онолын чиглэлээр магистрт сурч байхдаа Штиглицийн энэ номыг хичээл дээр үзэж судалдаг байв. Харин нэг өдөр номын зохиогч Японд ирж, лекц уншиж, Нобелийн шагнал авсан

бүтээлээ танилцуулсан юм. Лекц нь их сонирхолтой.

Номыг нь үзэж судалсан, дээр нь зохиогч нь номынхоо талаар дэлгэрэнгүй ярьсан нь надад их сэтгэгдэл төрүүлсэн тул эх хэлнээ орчуулсан. Уншаад байх тусам бидэнд их тустай ялангуяа төрд эдийн засгийн бодлого боловсруулж буй хүмүүст маш их хэрэгтэй ном гэж ойлгоод орчуулахыг зорьсон.

-Номын гол агуулгын талаар товч тайлбарлавал?

-Номын зохиогч Штиглиц нь өөрөө



Захиралтайгаа хамт. ОУВС-гийн захирал Кристан Лагардын өрөөнд 2015 он. Вашингтон ДС. АНУ

өнөө үеийн эдийн засагчдын хувьд хүлээн зөвшөөрсөн тэргүүлэх эрдэмтэн бөгөөд орлогын ялгаатай байдал, хөрөнгийн эрсдэлийн удирдлага, засаглал, олон улсын худалдааны чиглэлээр түлхүү судалгааны ажил хийдэг хүн. Түүний бусдаас ялгагдах онцлог нь эдийн засаг дахь үр ашигтай төрийн зохицуулалтыг дэмждэг, асуудалд илүү прагматик ханддаг эдийн засагч.

Номын гол агуулга нь нийгмийн харилцаа дахь Засгийн газрын үүрэг, оролцоо нь ямар байх ёстой, төр эдийн засгийг ямар арга хэрэгслээр удирдах, тухайлбал, үр ашигтай, ил тод татварын системийн загварыг хэрхэн боловсруулах, түүнд тулгуурласан зарлага, санхүүжилтийн бодлогыг хэрхэн хэрэгжүүлэх гэх мэт онолын асуудлыг бодит жишээн дээр тайлбарласан байдаг.

ХУГАЦАА АЛДАХ ТУСАМ ИЛҮҮ ТӨЛБӨРӨӨР ХҮНДРЭЛИЙГ ДАВАХ БОЛНО

-Эдийн засгийн онол талаасаа Монголын эдийн засгийг хэрхэн хөгжүүлэх боломж байна вэ?

-Хөгжиж буй эдийн засагтай манай улсын хувьд эдийн засгаа хөгжүүлэх асуудлыг өсөлтийн онолтой холбож ярих нь зөв байх. Эдийн засгийн өсөлтийн олон онол бий. Эдгээрээс хамгийн сүүлийн үеийн хүлээн зөвшөөрөгдөөд байгаа нь Шинэ өсөлтийн онол юм. Товчхоноор хэлбэл, өмнөх стандарт өсөлтийн онолууд бол газар болон хөрөнгийг өсөлтийн гол хүчин зүйлс гэж авч үздэг байсан бол Шинэ өсөлтийн онолоор хүн, хүний мэдлэг нь голлох хүчин зүйл юм аа гэж тайлбарласнаараа шинэлэг. Хязгаарлагдмал нөөцийг хүнээр буюу тэдний мэдлэг чадвараар өсгөх боломжтой гэсэн санаа. Харин үүнийг хэрэгжүүлэхийн тулд төр хүнээ боловсруулах чиглэлээр зайлшгүй хөрөнгө оруулалт хийх шаардлагатай байдаг. Хувь хүмүүс болоод компаниуд энэ чиглэлээр хөрөнгө оруулах хөшүүрэг нь бага байдаг тул төрийн хийх ёстой ажил гэж үздэг.

Одоо Монголынхоо нөхцөлд байдлыг үнэлээд үзье. Манай улс 1.0-3.0 их наяд ам.долларын газар доорх

нөөцтэй. Хүн ам гурван сая. Үүнээс мэдлэг чадвартай хүний нөөц гэвэл бүр цөөн. Тэгэхээр манайд хөрөнгө нь хангалттай, харин мэдлэг чадвартай боловсон хүчний нөөц бага байна. Тэнцвэргүй, тогтворгүй нөхцөл байдал үүссэн байгаа учраас хүндээ, тэдний боловсролд хөрөнгө оруулахгүйгээр тогтвортой, урт хугацааны өсөлтийг бий болгож чадахгүй гэсэн санаа юм. Өөрөөр хэлбэл, өөрсдийн мэдлийн хөрөнгийг өөрсдөө ашиглах, хамтарч ашиглах, тохиолдолд үр ашгийг шударга хуваарилах боломжгүй гэсэн үг. Иймд бид монгол хүнээ бүтээж, хөгжүүлэхэд анхаарах нь чухал. Ер нь хүндээ оруулсан хөрөнгө оруулалтын өгөөж хамгийн өндөр байдаг. Энэ бол монгол төрийн бодлого байх ёстой.

-Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн хүнд үед ОУВС-гаас манай Засгийн газарт хандаж мэргэжлийн зөвлөгөө, анхааруулга өгсөн. Харин манай төр, засаг хүлээж авдаггүй, эсвэл зөвлөгөөг үл ойшоодог байдал гаргадаг тухай мэргэжлийн хүмүүс хэлдэг. Хямралаас гарах ямар зөвлөгөө өгөөд байгаа бол?

-Манай улсын төлбөрийн тэнцэлд дарамт үүссэн, мөн санхүүгийн нөхцөл байдал сул байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалт буурсан, дэлхийн зах зээл дээр түүхий эдийн үнэ унасан нь зарим талаараа нөлөөлж байгаа. Хамгийн гол нь төсвийн болон мөнгөний хэт сул бодлого нөлөөлсөн. ОУВС хамгийн сүүлд буюу 2015 оны дөрөвдүгээр сард Монголын эдийн засагт хийсэн үнэлгээний тайландаа тодорхой зөвлөмжүүдийг өгсөн. Тухайлбал:

- Монгол Улсын Хөгжлийн банкны зарцуулалтыг оролцуулаад нийт төсвийн алдагдлыг бууруулах, мөн Засгийн газрын өрийг зохистой түвшинд барих болон төлбөрийн тэнцлийг хангахын тулд мөнгөний бодлогыг чангалах.

- Төсвөөр дамжин хийх ёстой Хөгжлийн банкны санхүүжилтүүд болон Монголбанкны хөтөлбөрүүдийг төсөвт нэгтгэх.

- Валютын ханшны уян хатан байдлыг хадгалах.

- Банкуудын нөөц болон өөрийн хөрөнгийн нөөцийн зохистой байдлыг хангуулах, банкны салбарын хяналт

шалгалтыг бэхжүүлэх.

- Хөгжлийн банк болон Монголбанк дахь засаглалын шинэчлэлийг хийх.

- Уул уурхайн томоохон төслүүдийг хөдөлгөх, хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, өсөлтийг дэмжих арга хэмжээг авах.

- Нийгмийн аюулгүй байдлын сүлжээг бэхжүүлж, ядууст чиглүүлэх нь зүйтэй гэсэн зөвлөмжүүд өгсөн.

-Тэгвэл манай Засгийн газар дээрх зөвлөмжүүдийг мөрдөхгүй байгаа шүү дээ.

-Засгийн газар болон Монголбанкны зүгээс эдгээр ажлыг эхлүүлээд явж байна гэж ойлгож байгаа. Харин цаг хугацааны хувьд хожуу арга хэмжээ авсан. Цаашид төрөөс богино хугацаанд бодлогын тохируулгаа хийхгүй бол хугацаа алдах тусам илүү төлбөрөөр хүндрэлийг давах болно.

-Монгол өрийн хямралд орж, гүйлгээний чадваргүй болж болзошгүй улсуудын эхний байруудад явж байгаа олон улсын байгууллагуудын судалгаа бий. Ямар үзүүлэлт, ямар нөхцөлөөр энэ судалгааг гаргаж тавьдаг талаар та тодорхой мэдээлэл өгнө үү?

-Өрийн тогтвортой байдлын шинжилгээгээр төрөл бүрийн шалгуур үзүүлэлтүүдийг ашигладаг. Тухайлбал, хуримтлагдсан өрийн үлдэгдэл, өрийн үйлчилгээний чадвар, мөн эдийн засгийн өсөлт болон экспортын төсөөлөлд тулгуурласан өрийн динамикийг тооцдог.

Өрийн тогтвортой байдлын үнэлгээгээр Монгол Улсын одоогийн өр хэтэрхий өндөр түвшинд байна гэсэн дүгнэлтэд хүрсэн. Ялангуяа дэлхийн түүхий эдийн зах зээлийн орчин муудаж улмаар экспорт болон гадаадын хөрөнгө оруулалтын төлөв муу байгаа энэ нөхцөлд өрийн эрсдэл өндөр байхаар байна. Тэгэхээр Засгийн газрын зүгээс бодлогын алдаануудаа засч, тохируулгаа яаралтай хийвэл манай улсын зээлжих зэрэглэл сайжирч, одоогийн өрийг илүү хямд өрөөр санхүүжүүлэх боломж бүрдэнэ. Энэ нь эрсдэлийг бууруулах чухал арга хэрэгсэл юм.



ОУВС, Дэлхийн банк болон ОУСК зэрэг олон улсын байгууллагад ажиллаж буй монголчуудын хамт. Вашингтон ДС. 2013 он

-Уул уурхайн салбарын манай эдийн засагт үзүүлэх нөлөөг ямар байдлаар хүлээх вэ? Цаашид урт хугацаандаа эдийн засгийн тогтвортой өсөлтийг хэрхэн бий болгох вэ?

-Монгол нүүрс, зэсийн маш их нөөцтэй учир уул уурхайн салбар Монгол Улсын эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэсээр байх болно. Оюутолгойн хоёрдугаар шатны бүтээн байгуулалт болон Тавантолгойн хөрөнгө оруулалтын асуудлууд шийдэгдсэн тохиолдолд богино болон дунд хугацаанд хөрөнгийн дотогшлох урсгал эрчимжиж экспортын орлого өснө гэсэн төсөөлөл байгаа. Нэгэнт уул уурхайгаас хамаарсан эдийн засгийн бүтэцтэй орны хувьд Баялгийн санг яаралтай үйл ажиллагаанд оруулах, мөн Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах замаар өнөөгийн мөчлөг дагасан төсвийн бодлогыг засварлах зайлшгүй шаардлагатай.

Цаашид тогтвортой эдийн засгийн өсөлтийг бий болгохын тулд инфляцийг бага түвшинд тогтворжуулах, ханшийг уян хатан, өрсөлдөх чадвартай байлгах, төсөв мөнгөний оновчтой бодлого баримтлах замаар макро эдийн засгийн орчныг эрүүлжүүлэх хэрэгтэй. Харин урт хугацаанд хүртээмжтэй өсөлт, ажлын байрыг бий болгохын тулд Монголын давуу талд нийцүүлсэн хөдөө аж ахуй, аялал жуулчлал зэрэг бусад салбарыг дэмжих ёстой. Эдгээр салбарын үйл ажиллагаа эрчимжсэнээр үнийн

хэлбэлзэл өндөртэй уул уурхайн бүтээгдэхүүний эдийн засагт үзүүлэх нөлөө буурч, ДНБ-ий өсөлт илүү хүртээмжтэй, өмнөхөөсөө бага хэлбэлзэлтэй болно.

МОНГОЛ ГАДААД ӨРИЙНХӨӨ ХУВЬД АРГЕНТИН УЛСЫН АРААС АЛХАЖ ЯВАА

-Та ОУВС-д ажиллах хугацаандаа Монгол Улстай холбоотой ямар нэг шийдвэр гаргахад оролцсон уу?

-Анхлан ажлаа авахдаа Монгол, Узбек, Микронез гурван улсыг хариуцаж, тус орнуудад олон удаа очиж, эдийн засгийн байдалд нь үнэлгээ өгч, асуудлыг нь ОУВС-гийн Захирлуудын зөвлөлд оруулж хэлэлцүүлж ажилласан.

Өөрийн оронтой холбоотойгоор шийдсэн ажлуудаас нэлээд цаг хугацаа болон ажиллагаа шаардсан нь Монгол Улсын ОУВС дахь зээлжих ангиллыг ахиулах байсан. Тус сангийн ажилтнуудтай хамтран судалгаа хийж, дунд орлоготой оронд тавигддаг шалгуурт нэмэлт өөрчлөлт оруулж, Захирлуудын зөвлөлөөр батлуулсан юм. Санаачилгатай байвал ажил хийж болох юм байна гэсэн итгэл үнэмшил авч, дотроо ихэд олзуурхсан. Учир нь манай улс өмнө нь ОУВС-гийн хувьд бага орлоготой орны статустай, буурай хөгжилтэй орнуудын жагсаалтад байсан юм. Хэрэв эдийн засаг хямраад ОУВС-гаас яаралтай мөнгө авах тохиолдолд 150-200 сая ам.долларын зээл авах боломжтой

гэсэн үг. Харьцангуй бага мөнгөний эрхтэй байсан.

Харин өнөөдөр Монгол дунд орлоготой орны статустай болсон бөгөөд тус сангаас 500-600 сая ам.долларын зээл авах боломжтой болж өөрчлөгдсөн.

Ер нь ОУВС-гийн Захирлуудын зөвлөлийн хурлаар гишүүн орнуудын том, жижиг олон асуудлыг хэлэлцдэг. Миний хувьд хамгийн сонирхолтой нь Аргентиний өрийн асуудал байсан. Учир нь манай улс гадаад өрийнхөө хувьд яг энэ улсын араас алхаж яваа шүү дээ. Тус улс анхлан олон улсын зах зээлээс бонд босгож, манайхтай ижил жилийн 4-5 хувийн хүүтэй зээлсэн байдаг. Гэтэл төсвийн тэлэлтээ хянаж чадахгүй, дээр нь өрийг өрөөр санхүүжүүлж явсаар сүүлдээ хүү нь жилийн 24 хувьд хүрсэн. 2001 оноос өрөө төлж чадахгүй гэдгээ зарлаж эхэлсэн бөгөөд одоо ч байдал хэвээр байна. Өрөө төлж чадахгүй тохиолдолд тухайн улсын аливаа хөрөнгө зээлдүүлэгчийн мэдэлд очдог нь их том эрсдэл юм.

-Дэлхийн эдийн засгийн ирээдүйн төлөв байдал ямар байна вэ?

-2015 оны эхний хагаст дэлхийн эдийн засгийн өсөлт буурсан нь хөгжиж буй эдийн засаг цаашид ч удааширч, хөгжсөн эдийн засгуудын сэргэлт сул байхыг илтгэж байна. Дэлхий нийтийн өсөлт 2015 онд 3.1 хувьтай байх төлөвтэй. Энэ нь 2014 оныхоос үл ялиг доогуур үзүүлэлт ч, долдугаар

сард шинэчлэн гаргаж байсан WEO-ийн (дэлхийн эдийн засгийн төлөв) таамаглалаас доогуур байгаа юм. Улс орнууд болон бүс нутгийн төлөв харилцан адилгүй байна.

Өмнөх жилтэй адил хөгжсөн эдийн засгуудын өсөлт бага зэрэг дээшлэх бол хөгжиж буй эдийн засгууд, мөн шинээр үүсч буй зах зээлтэй орнуудын эдийн засгийн өсөлт буурах магадлалтай. Өөрөөр хэлбэл, түүхий эдийн үнэ буурч, валютын ханш суларч, мөн санхүүгийн зах зээлийн тогтворгүй байдал нэмэгдэж байгаа нь шинээр үүсч буй зах зээлтэй орнуудын болон хөгжиж буй эдийн засгуудын эрсдэл нэмэгдэхэд хүргэж байгаа юм.

Харин дэлхий нийтийн идэвх 2016 онд эрчээ авах төлөвтэй харагдаж байна. Хөгжсөн эдийн засгууд 2014 оноос аажмаар сэргэж эхэлсэн, цаашид ч сэргэх хандлагатай байна. Ялангуяа эдийн засгийн хүнд байдалд буй Бразил, ОХУ болон зарим Латин Америкийн орнын өсөлт 2015 онд тогтворжиж, 2016 оноос сайжрах төлөвтэй байна.

-Америк дахь монголчуудын амьдрал ямар байна вэ?

-Энд ирээд олон монголтой уулзаж, сайхан нөхөрлөлөө. Олон

улсын байгууллагад ажилладаг 20 гаруй монгол байдаг. Бидний уулзаад ярьдаг халуун сэдэв бол цаг ямагт эх орон минь юм. Ер нь гадаадад амьдардаг монголчууд илүү эх оронч, нутаг орныхоо түүх, соёлыг илүү судалж, үр хүүхэддээ өвлүүлэх гэж оролддог юм байна. Манай Вашингтон ДС-д амжилттай бизнес эрхэлж буй монголчууд олон бий. Тэд маань өөр хоорондоо хамтран ажиллаад үр дүнд хүрч байгааг харахаар урамтай шүү. Ер нь монголчууд маань хүний нутагт сайн амьдарч байгаа.

ОУВС-д ажиллах хугацаа хэзээ дуусгавар болох вэ? Хэзээ Монголдоо ирэх вэ?

-Хугацааны хувьд гэрээ байгуулаад хоёр жилээр сунгаж ажилладаг. Миний эхний гэрээ удахгүй дуусгавар болж байгаа. Гэрээгээ дахин сунгахгүйгээр эх орондоо очно. Монголд салбар салбарын мэдлэг боловсролтой, залуус үзэл бодлоороо нэгдэн улс орондоо хүчээ өгөхөөр нэгдсэн зохион байгуулалтад орж байгаад үнэхээр талархаж байгаа. Монголдоо очиж тэдгээр залуустай хамтран ажиллаж, улсынхаа хөгжилд өөрийн чадах хувь нэмрээ оруулах бодолтой байгаа.■

Түүнээс таны хообий юу вэ хэмээн асуухад бөмбөгтэй л бол бүх төрлийн спортод дуртай гэсэн юм. Ялангуяа сагсан бөмбөгт илүү сонирхолтой. Мөн шатар, даам тоглоно. Ууланд аялж, олон үндэстний ахуй соёлтой танилцах, сайхан кино үзэх, уран зураг цуглуулах, ном унших гээд олон хообийтой. Харин Америкт очсоноосоо хойш хүүхдүүддээ хоол хийж, зочиддоо мах шарж өгөх шинэ хообийтой болжээ. Дөчин насны босгыг алхаж буй Т.Доржханд дөрвөн хүүхдийн аав. Тиймээс аавын үүргээ сайн биелүүлэхийн төлөө хичээдэг гэсэн. Том хүү нь ахлах сургуулийн сурагч бол бага нь дөнгөж дөрвөн сартай.

Түүний ажлын нэг өдөр хэрхэн өнгөрдгийг сонирхоход өглөө 06.00 цагт босч гучин минут гүйнэ. Дараа нь хүүхдүүдээ сургуульд хүргээд ажил дээрээ очно. Тэрбээр ажлын найман цаг зогсоогоороо ажилладаг аж. Учир нь ОУВС-гийн ширээнүүд нь дээш, доош чөлөөтэй хөдөлгөх боломжтой учир босоогоороо ажиллахад амар байдаг гэлээ. Долоо хоногт гурван удаа хуралдах Зөвлөлийн хуралд бүс нутгийнхаа орнуудын эдийн засгийн талаар мэдээлэл, асуудал оруулж хэлэлцүүлэх ёстой тул өдөржин бичиг цаас, компьютертэй ажиллана. Ажлын цаг дуусахад хүүхдүүдээ сургуулиас нь аваад гэртээ харьж тэднийхээ дуртай хоолыг хийж өгдөг гэнэ. Түүний эхнэрийг Сийлэн гэдэг. Мөн санхүү, эдийн засгийн мэргэжилтэй, АНУ-д 10 гаруй жил сурч боловсорсон бүсгүй аж.

Т.Доржханд мэдлэг боловсрол, туршлага олж авахад багагүй хугацааг зарж, нэлээд өндөр түвшинд бэлтгэгдсэн боловсон хүчин. Гадаад, дотоодын байгууллагуудад ч ажиллаж чамгүй туршлага хуримтлуулахын зэрэгцээ гэр бүлээ ч төвхнүүлж амжиж. Ийм л эх орны ирээдүй болсон залуу улсынхаа хөгжилд сурсан мэдсэнээ зориулахаар Монголдоо удахгүй ирнэ.



Т.Доржханд Дэлхийн банкны төвд



ХУУЛЬ ТӨРХИЙН ӨМНӨ

Хөдөлмөрийн хуулийг урт настай болгоё гэвэл

Ц.Сайхан

Монгол Улсад хөдөлмөрийн харилцаа бүрэлдэн тогтож байна. “Хөдөлмөрийн тухай хууль” 1999 онд батлагдсанаас хойш ажил олгогч, ажилчин хооронд шинэ төрлийн харилцаа, технологи бий болжээ. Өнгөрсөн хугацаанд нийт 18 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан ч одоогийн мөрдөж буй хууль шинэ тутамд бий болж байгаа харилцааг зохицуулж чадахгүй болжээ. Ингээд хуулийг бүхэлд нь харж, шинэчлэл хийх шаардлага цаг хугацааны эрхээр бий болсон. Ерөнхийдөө “хөрснөөс нэлээд хөндийрсөн” учраас хуулийн хэрэгжилт төдий хэрээр цалгар болж. Ялангуяа жижиг аж ахуйн нэгжид “хууль” гэж ярихын ч хэрэггүй байдал бий болсон нь нууц биш.

УИХ-д өргөн бариад байгаа “Хөдөлмөрийн тухай” хуулийн төслийн давуу тал нь шинэ нэвтэрсэн харилцааг нэлээд нарийн зохицуулж өгсөнд оршино. Тухайлбал, бүрэн бус цаг, жасаа буюу уул уурхайн компаниудад нэвтрээд байгаа урт хугацаат ээлжийн ажил, хөдөлмөрийн гурвалсан харилцааг тун чиг нарийн хуульчилжээ. Хуулийн төсөл бүхэлдээ нөр их хөдөлмөр шингэсэн том ажил болсныг мэргэжилтнүүд хэлж байгаа юм.

Шинэ хууль батлагдсанаар өнөөдөр зохицуулахад ихээхэн төвөгтэй байгаа хувийн хэвшлийн ажилчдын цалин

урамшууллын тогтолцоог зохицуулах боломжтой болох аж. Гэвч нэг асуудал урган гарсан нь байгууллагын дотоод ардчилал. Хуулийн шинэчилсэн найруулгад ажиллах хүчний эрх ашгийг нэлээд сайн хамгаалсан, хөдөлмөрийг нь үнэлэх зохицуулалт, зүйл заалт олон оржээ. Шөнийн ээлжинд ажилласан ажилтанд үндсэн цалингийн 15 ба түүнээс дээш хувиар тооцож нэмэгдэл олгох, долоо хоногийн амралтын өдөр ажилласан ажилтанд дундаж цалин хөлсийг нь хоёр дахин нэмэгдүүлж олгох гэх мэт. Одоогийн хуулиар амралтын өдрийн цалин 1.5 дахин тооцож олгох ёстой.

Гэхдээ нөгөө талд ажил олгогчдод эдгээр заалтууд ихээхэн санхүүгийн дарамт болохуйц байгаа юм. Тухайлбал, “жасаа эхлэх болон дуусахад ажил олгогч ажилтныг ажилдаа ирэх, буцах боломжоор үнэ төлбөргүй хангах үүрэгтэй бөгөөд энэ хугацааг ажилласан цагт нь оруулж тооцох” заалт бий. Зарим ажилчин хөдөө орон нутгаас олон дамжин ирж ажиллах нь бий тул хуулийн заалтын дагуу компани ихээхэн хэмжээний нэмэлт зардал гаргана. “Хаана амьдарч, ажиллах нь хүний эрх учир энэ зүйл заалтад ямар менежмент хийхээ би мэдэхгүй байна” хэмээн нэгэн гадаадын хөрөнгө оруулагч Монголын бизнесийн зөвлөлийн гишүүдийн уулзалтын үеэр хэлж байв.

Эдийн засгийн хүндрэл, хямралын үед аж ахуйн нэгжүүд, ялангуяа компаниудад энэ дарамт их хүнд тусч болох бөгөөд орон тооны цомхтгол хийхэд хүрэх эрсдэл байгааг “Минтер Элписон” хуулийн фирмийн Монгол дахь түнш хатагтай Элизабет Эллис сануулж байна. Ийм үзэгдэл бий болоход эдийн засагт асар хохиролтой. Нэг үгээр хэлбэл, ажилгүйдэл газар авна.

Хэдийгээр хөдөлмөрийн харилцааг зохицуулахад чиглэж буй гэх боловч хуулийн заалтууд захиргаадсан шинж чанар агуулж байгааг тэрбээр хэлж байлаа. Жишээ нь, Хөдөлмөрийн хугацаатай гэрээг зөвхөн тодорхой тохиолдлуудад байгуулахаар тусгасан. Хугацаатай гэрээг байгуулахад дээд тал нь хоёр жилээр хатуу тогтоосон байна.

Засгийн газар, үйлдвэрчний эвлэл, ажил олгогч эздийн холбооны оролцоотой “Хөдөлмөрийн маргаан зохицуулах гурван талт хороог” шинээр байгуулах аж. Бүтцийн хувьд нийслэл, дүүрэг, аймаг, сумын түвшинд байгуулж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Энэ нь улсын төсвийн зардал нэмэгдэх нэг шалтгаан болохоос гадна “Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль”-ийн дагуу хөдөлмөрийн харилцааны ганцаарчилсан маргааныг шүүхийн шатнаас өмнө болон шүүхийн шатны

явцад ч зуучлагчийн оролцоотойгоор эвлэрүүлэн шийдвэрлэх эрх зүйн орчин бүрдсэн байтал ахин хороо байгуулах шаардлага байхгүй хэмээн эдийн засагч Ч.Хашчулуун үзэж байгаа аж. Түүнчлэн тус хороог байгуулснаар ажил олгогч, ажилчны хооронд үүссэн маргааныг шүүхээс өмнө хэлэлцэх нэг дамжлага бий болж маргаан шийдвэрлэх процесс удаашрах нөхцөл бүрдэнэ хэмээн Элизабет Эллис үзэж байгаа юм. Ингэснээр хоёр талын аль нь ч цаг хугацаа, хөрөнгө мөнгөөр хохирно гэлээ.

Хамрах хүрээ өргөсч байгаа ч хуульд тодорхойгүй зүйлс бас байгаа аж. Тухайлбал, хуулийн төсөлд бичсэнээр “гэр бүлийн онцлог хариуцлага бүхий ажилтан” гэж хүүхэд болон гэр бүлийн бусад гишүүдээ асрах үүрэг хүлээнээр ажил, үүрэг гүйцэтгэх, дэвших бололцоо нь хязгаарлагдаж байгаа ажилтан хэмээн тодорхойлжээ. Энэ ажилтанд хөдөлмөрийн уян хатан зохицуулалт хэрэглэх заалт бий. Эцэг эхчүүд хүүхдээ цэцэрлэгт хүргэж

өгснөөр өглөө ажилдаа хоцрох, орой цэцэрлэгээс нь авахын тулд цагаасаа эрт явах шаардлагатай болдог. Энэ тохиолдол хуулийн зохицуулалтад багтаж байгаа эсэх, хэрэв тийм бол олон зуун ажилтантай компаниуд ажлын цагаа хэрхэн зохицуулах гээд асуудал урган гарч байна. Түүнчлэн ижил үнэ цэнэтэй ажил гүйцэтгэж байгаа ажилтны үндсэн цалин тэнцүү байхаар тусгажээ. Гэвч илүү үнэ цэнэтэй ажил гэдгийг хэрхэн ойлгох, ажилчид маргаан үүсгэвэл тэдний ажлын үнэ цэнэ ижил эсвэл ялгаатай болохыг хэрхэн тогтоож шийдвэрлэх гэх мэт асуултын хариулт олдохгүй байгаа юм.

Хуулийн төсөл агуулгаараа дэвшилттэй боловч яг одоогийн хувилбарт засч сайжруулах зүйлс бий тухай Хувийн хэвшлийг дэмжих үндэсний зөвлөлийн Ерөнхийлөгч Ч.Хашчулуун, Монголын бизнесийн зөвлөлийн “Хуулийн ажлын хэсэг” тодорхой санал дэвшүүлж хэлэлцүүлээд байгаа юм. Хамгийн чухал гэж хэлж болох өөрчлөлт гэвэл

талуудын харилцаанд хэт нарийн “дектатор” тогтоох хэрэггүй. Ажилтан, ажил олгогч нар зарим асуудлыг шууд хоорондоо хэлэлцэж шийддэг байх нь зүйтэй хэмээн Элизабет Эллис үзэж байгаа юм. Тэрбээр “Монгол Улсад хөдөлмөрийн харилцаа бүрэлдэн тогтох явц үргэлжилж байгаа, шинэ төрлийн харилцаа үүсч бий болсоор байгаа учир хэтэрхий хатуу зүйл заалтууд эргээд бодит байдал дээр хэрэгжих магадлал муутай” гэсэн. Уг хуулийн төслийг Үйлдвэрчний эвлэл, Засгийн газар, Ажил олгогч эздийн холбоотой хэлэлцсэн боловч бодитой ажлын байр бий болгож байгаа аж ахуйн нэгжүүдийн саналыг сонсоогүй нь дутагдалтай болсон. Мөн анхнаасаа хуулийг “цагаан цаасан” дээр эхлэлгүй хуучин хуулийн зүйл заалтыг засах, заримыг нь хасах, нэмэх байдлаар ажилласан нь бодит байдалтай нийцэхгүй болох үндэс болсон гэлээ. Хууль батлах үйл явцад олон санал, шүүмжлэл гарч, засвар хийгддэг учир дээрх алдаа дутагдлыг залруулах боломж нээлттэй билээ.■

УЛС ТӨР



С.Мөнхбат: Намуудын төлөвшилтийг хангахад чиглэсэн эрх зүйн зохицуулалт хэрэгтэй

Ц.Сайхан

Монголын өнөөдрийн эдийн засгийн хүндрэлийг улс төрийн тогтворгүй байдалтай холбон үзэх нь их байгаа. Тиймээс цаашид намуудын улс төрийн бодлого шийдвэр гаргаж, төр удирдах чадамж, Сонгуулийн хуулийн тухай гээд олон асуудалд зөв гарц, шийдэл хэрэгтэй байгаа. Энэ талаар ч нийгэмд олон байр суурь өрнөж байна. Үүнтэй холбоотой улс

төрийн хүрээнд өрнөж буй зарим асуудлын талаар МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Улс төр судлалын тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор С.Мөнхбаттай ярилцлаа.

-Улс төрийн өнөөгийн нөхцөл байдлыг судлаач хүний зүгээс хэрхэн харж байна. Засаг тогтворгүй байгаа нь тогтолцоотойгоо

холбоотой юу?

-Өнөөдрийн нөхцөл байдал олон хүчин зүйлстэй холбоотой. Эдийн засаг, улс төрийн тогтолцооны хүндрэлээс үүдсэн улс төр, засаглалын хямрал гүнзгийрсэн тийм цаг үе. Улс төрийн хүрээнд парламентат ёсны хямрал бий болох нэлээд таатай хөрс бүрдчихлээ. Засгийн эрх барьж байгаа нам, эвслийн хэрэгжүүлж буй бодлого

нийгмийн үр өгөөж тааруухан байна. Дээрээс нь зах зээлийн харилцааг зөв хөгжүүлэх эдийн засгийн сайн бодлогогүйн улмаас эдийн засаг саармагжиж, өнөөдөр төсвийг бүрдүүлж чадахгүй хэмжээнд хүртлээ хүнд байдалд орж байна. Энэ бүхэн нь эцсийн дүндээ, тухайн улс оронд улс төрийн сайн бодлого хөтөлбөр гаргах шаардлага хэрэгцээ, нөгөө талдаа түүнийг боловсруулж, хэрэгжүүлдэг тулхтай, төлөвшсөн улс төрийн нам, хүчин ямар их үүрэг рольтой вэ гэдгийг тод харуулж байна.

Гэтэл манайд бодит байдал эсрэгээрээ шахуу байна. Тухайлбал, улс төрийн нам хүчнүүдийн бодлого боловсруулах чадамж, түүнийгээ хэрэгжүүлж нийгмийн үр өгөөж гаргах байдал их сул байна. Намууд бодлого гаргах чадамжаа нэлээд алдчихлаа. Дээрээс нь нам доторх бүлэг фракцуудын албан тушаалын төлөөх тэмцэл маш их гүнзгийрчээ. Энэ бүхэн нь Засгийн газрын тогтвортой үйл ажиллагаанд нэлээд сөрөг нөлөө үзүүлж байна. Мөн Засгийн газрыг тогтвортой ажилууллах Үндсэн хуулийн хамгаалалт их сул байна. Эрх мэдэл хуваарилалтын зарчим нь алдагдсан. Энэ бүхэн ард иргэдийн төр засаг, улс төрийн институцид итгэх итгэлийг бууруулж цаашлаад нийгэм, улс төр эдийн засгийн хямрал үүсгэх үндсэн нөхцлийг бүрдүүлж байна.

-Тэгвэл намуудын бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх шаардлагатай болж байна уу?

-Намуудын бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, дотоод ардчиллыг хөгжүүлэх, иргэдийн оролцоонд суурилсан бодлого боловсруулдаг механизмыг хөгжүүлэх шаардлага намуудад бий. Мөн санхүүжилтийг ил тод болгох эрх зүйн орчны зохицуулалт хийх нь намын хөгжил төлөвшилтийг хангахад чиглэгдэн хийх чухал реформ мөн.

Сүүлийн үед улс төрийн намуудын хуулиас хэтийдсэн улс төржилт төрийг хямраадаг боллоо. Үүний хамгийн ноцтой сөрөг үр дагавар нь тогтсон хэм хэмжээ, дүрэм, журмаа намууд нь эргээд эвддэг, өөрийн эрх ашигт нийцүүлдэг, өөрөөр хэлбэл хуулийн засаглал тогтоох бус хуулиар засаглах хэлбэр агуулга руу орох шинж

хандлага руу гулсан орж буй явдал юм. Ийм байдал нь ардчилсан төрийн үйл ажиллагаанд маш том хор уршгийг бий болгох үүд хаалгыг нээж болох юм. Энэ бүхэн мөн л намын төлөвшилтэй холбоотой.

-Зарим улстөрч намыг гишүүнчлэлгүй болгох хэрэгтэй гэсэн байр суурь илэрхийлж байгаа. Монгол Улсад ингэх боломж бий юу?

-Намыг гишүүнчлэлгүй болгох нь одоохондоо манайд арай эрт байна. Учир юунд гэвэл манай намууд төлөвшил, хөгжлийнхөө тодорхой шатыг давж ардчиллын тогтвортой институци болж чадаагүй байна. Ийм учраас намуудын төлөвшилтийг хангахад хүчтэй нөлөө үзүүлдэг гол фактор болсон гишүүнчлэлийг АНУ гэх мэт өрнөдийн хөгжингүй орнуудтай адил болгочихвол нийгэм төр хоёрыг холбогч гүүр болдог үндсэн чиг үүргээ намууд алдахад хүрнэ. Нөгөө талаар манай намуудын хэв маяг кокус намын хэв маягт хамаардаггүй. Баруун Европоос эхтэй олон түмний намын хэв маягаар хөгжиж буй намууд юм. Тийм болохоор юуны урьд гишүүнчлэлийн асуудлаар оролдох нь хэр оновчтой бол.

Гурав дахь гол шалтгаан нь Монголын намуудын үзэл баримтлал, үзэл суртал, үнэт зүйлс сонгогчдын улс төрийн чиг баримжаа болтлоо нийгэмд бэхжээгүй учир гишүүнчлэлгүй болчихвол намуудын бодлого, үйл ажиллагаа нэг хүний, нэг хэсэг бүлгийн давуу эрх мэдэл бий болж нам улам бүр олон түмнээс хөндийрөх болно. Харин гишүүнчлэлийг чанаржуулах, бодитой болгох тал дээр эхний алхмуудаа хийх нь зөв гэж бодож байна. Ингэснээр намууд гишүүдийн оролцоон дээр суурилж бодлого, хөтөлбөрөө гаргаж, нэр дэвшигчдээ тодруулдаг болох нь дотоод ардчиллыг бэхжүүлэх үндэс болно.

Иймээс намын төлөвшил, хөгжлийг хангахын тулд дараах асуудлуудад анхаарал хандуулах шаардлага зайлшгүй тавигдана. Нэгдүгээрт намын санхүүжилт. Хоёрдугаарт, бүтэц зохион байгуулалтын ил тод нээлттэй, дотоод ардчилал. Гуравдугаарт намын бодлого, үйл ажиллагаа, үнэт зүйлсийн төлөвшилт зэргийг анхаарах нь зүйн

хэрэг бөгөөд эдгээрийг цогцоор нь анхаарч эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгтэй.

-Үндсэн хуулийг өөрчлөх тухай, сонгуулийн тухай хуулийн асуудлыг улс төрчид хөндөж байна. Таны өмнө хэлсэн парламентат ёсны хямрал бий болох эсэхэд дээрх хуулийн асуудлууд нөлөөлөх хүчин зүйл болох болов уу?

-Үндсэн хууль тэр бүр оролдоод байдаг бичиг баримт ч биш л дээ. Гэхдээ нийгмийн хөгжлийн шаардлагаар, амьдралаас урган гарч буй шинэ нөхцөл байдал, тухайлбал улс төрийн хүрээнд үүсч буй ээдрээ будлиантай цаашид ямагт сөрөг үр дагавар авч ирж болох зохицуулалтууд дээр анхаарч засаж сайжруулах асуудал бол байж болно. Энэ утга, агуулгаар үндсэн хуулиндаа зарим өөрчлөлт оруулах шаардлага амьдралаас урган гарч байна. Энд юуны урьд төрийн байгуулал гэсэн Үндсэн хуулийн гуравдугаар бүлэгт зарчмын өөрчлөлт оруулах цаг болсон гэж үздэг. Ингэж дүгнэж буйн гол агуулга нь төрийн нэг цогц эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн гурван салаа мөчирт хуваарилж харилцан хамаарал, хяналт-тэнцлийн механизмыг нарийн тогтоож өгөхөд чиглэх ёстой гэж харж байгаа. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн гурван чиг үүргийг эн тэнцүү түвшинд хуульчилж, харилцан бие биеэ нөхцөлдүүлдэг, бас хянадаг түвшинд баталгаажуулж төлөвшүүлэх учиртай юм.

-Тэгэхээр та Үндсэн хууль тийм чадамжгүй болсон гэж үзэж байна уу?

-Үндсэн хууль бүхэлдээ чадамжгүй гэж бий хэлээгүй. Том агуулгаар нь харах юм бол манай Үндсэн хууль муу хууль биш. Би ч тэгж дүгнээд байгаа юм биш. Манай тэргүүлэх эрдэмтэн судлаачид, гаднын судлаачид бас тэгж дүгнэдэг. Зөвхөн тус хуулийн гуравдугаар бүлэг буюу төрийн байгуулалын хэсэг дэх төрийн эрх мэдэл хуваарилалтын зарчмыг хуульчлан тогтоосон байдал, түүнийг тойрсон ээдрээ, маргааныг нэг мөр засаж залруулахад чиглэсэн өөрчлөлтүүдийг хийх нь зүйтэй гэж харж байгаа.■



14 ХОНОГИЙН СЭДЭВ

Хөдөлмөрийн үндэсний нам/ХҮН/-аас “Халх гол” чөлөөт бүс байгуулах тухай судалгааны дүнг танилцууллаа

УИХ-ын гишүүн С.Ганбаатар 75 дугаар тогтоолыг цуцлуулахаар шийдэв

Халх гол сумын иргэд Р.Бурмаа сайдыг хүлээн авсангүй

-Р.Бурмаа сайд Халх гол сумын газар ашиглалттай холбоотой ноцтой баримт дэлгэлээ

Халх голд юу болоод байна вэ?

И.Отгонжаргал

Манай сэтгүүл “14 хоногийн сэдэв” нэртэй шинэ булан нээж байна. Сэтгүүл гарах хугацаанд өрнөж буй олон үйл явдал, халуухан мэдээллийн өрнөл дундаас хамгийн их яригдаж буй нэг сэдвийн олон өнцгийн огтлолцолыг олж бичих юм. Энэ удаа хөдөө аж ахуйн Халх гол чөлөөт бүсийн тухай хөндөж байна.

Энэ сэдэвтэй холбоотой мэдээлэл өнгөрсөн зунаас үүдэлтэй ч хэсэг намжмал байдалтай байсан бол сүүлийн 14 хоногт дахин хүчтэй яригдаж, шилээ дарсан олон үйл явдал өрнөлөө.

Асуудал юунаас эхлэв. Хөдөө аж ахуйн “Халх гол” чөлөөт бүс байгуулах тухай УИХ-ын 75 дугаар тогтоол 2015 оны долдугаар сарын 9-нд гарсан байдаг. Тиймээс энэ тогтоолын эргэн тойронд дээрх олон үйл явдал өрнөөд байгаа билээ.

Эхний мэдээлэл. Хөдөлмөрийн үндэсний нам/ХҮН/-ын дэргэдэх “Хүн хөгжил” бодлого судалгааны хүрээлэнгээс Хөдөө аж ахуйн Халх

гол чөлөөт бүс байгуулах УИХ-ын шийдвэрт өгөх урьдчилсан дүгнэлтийг сошиал ертөнцөд тавив. Уг судалгааны дүнгэлтэд: Хөдөө аж ахуйн чөлөөт бүс байгуулах тухай шийдвэр нь үндэсний болон салбаруудын хөгжлийн бодлоготой уялдаагүй, хүнсний урт хугацааны аюулгүй байдал, байгаль орчин, хөрс, ургамал, ан амьтан, усны нөөцөд үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийг үнэлээгүй, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын зүйл заалтуудтай ноцтой зөрчилдсөн. Мөн хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг дэмжихийн тулд яагаад заавал чөлөөт бүсийн хувилбарыг, тэр тусмаа Халх гол бүсэд сонгож байгаа үндэслэл, төсөл хэрэгжсэнээр Монголын эдийн засагт ямар үр ашиг авчрах тухай тооцоо судалгаа байхгүй байна. Иймд чөлөөт бүс байгуулах, хөгжүүлэх талаар судалгаа, нөлөөлөл, эрсдэлийн үнэлгээг дахин сайтар хийлгэж, төслийн загварын шинэчлэл, бодлогын шийдвэрийг эргэж харах, залруулах шаардлагатай гэж үзжээ.

**Буун дуу,
бөмбөгдөлтийн
галд сүйрээгүй
Халх голын сав
газар энх цагт эрх
мэдэлтнүүдийн
шунал, сонирхолд
сүйдэх дээрээ тулаад
байгаа хэрэг үү**

Чөлөөт бүсийн тухай ойлголтоос авахуулаад түүхэн хөгжил, бодлого, хэрэгжилт, дэлхийн чиг хандлага, хөдөө аж ахуйн чөлөөт бүс гэж байдаг эсэх гээд нэлээд өргөн хүрээнд хийсэн гурван бүлэг, 12 сэдэвтэй уг судалгаанаас чөлөөт бүсийн тухай цогц мэдээлэл авч болохоор байгаа нь тун олзуурхууштай зүйл юм. “Сохорсон биш завшив” гэдэгчлэн хөдөө аж ахуйн Халх гол чөлөөт бүс байгуулахтай холбоотойгоор чөлөөт бүсийн тухай бүрэн судалгааны материалтай болоод авлаа, Монгол Улс. Дуулиан болоод буй чөлөөт бүс байгуулагдсан ч эс байгуулагдсан ч нэлээд ул суурьтай хийсэн уг судалгааг оюутнаас эхлээд хууль тогтоогчид

чөлөөт бүс болбол манай яамнаас тэнд орж ирж байгаа гадаад ажиллах хүчний тоо хэмжээг хянах боломжгүй болно” гэсэн шалтгаан хэлүүлээд амжсан. Түүний гарын үсэг цуглуулах ажиллагаа цаашаа хэр явахыг харахыг хүссэн хүн цөөнгүй бий биз ээ.

Халх гол чөлөөт бүсийн асуудал ар араасаа хөврөх тусам улам шуугиан дэгдээх болов. Уг ажлыг гардан хариуцаж буй Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа өнгөрсөн сарын 21-22-нд Халх голд томиллолтоор очсон боловч сумын иргэд түүнтэй уулзахыг хүссэнгүй. Халхголчууд түүнийг хүлээж авахгүй гэдгээ илэрхийлж, “Сайд таныг УИХ-ын 75 дугаар тогтоолыг цуцлуулчихаад ирвэл хадаг барьж

доо. Уг нь бол хэргийн эзэн хэнгэргийн дохиур болсон хүн нь өөрөө очиж байхад харин ч сайхан уулзаад, сайн ярилцаж, болох болохгүйгээ учирлаж ойлгуулж болох байлаа. Бурмаа сайдыг өмөөрөх гэсэндээ үүнийг бичсэнгүй, болж байгаа үйл явдлаас харахад манайд газар нутгаа хамгаалах гэсэн хийрхэл газар аваад байх шиг. Нэг үгээр, халхголчуудын гаргаж байгаа ааш авир цаана нь уг асуудлыг улстөржүүлэх хэсэг бүлгийн сонирхол нуугдаж, нэлээд зохион байгуулалтад ороо юу даа гэсэн бодол хэнд ч төрөхөөр байв. Хариуд нь Бурмаа сайд хэдий зорьсон зорилго нь бүтэлгүйтсэн ч орон нутгийн томиллолтоо үргэлжүүлж



Фотос Б.Бямба-Очир

“Халх гол” чөлөөт бүс байгуулах тухай УИХ-ын 75 дугаар тогтоолыг эсэргүүцэж жагсаа

хүртэл хүссэн цагтаа аваад үзсэн ч хэрэгтэй дэг ээ.

Үйл явдлын дараагийн өрнөл УИХ-ын гишүүн С.Ганбаатарын үйлдэл. Халх гол чөлөөт бүс байгуулах шийдвэр нь буруу гэсэн ХҮН намын хөдөлгөөнийг идэвхтэй дэмжигч төрийн түшээд бол УИХ-ын бие даагч гишүүд юм. Тэд Халх гол чөлөөт бүсийг төвхнүүлэх ажлыг санаачилж, гардан хийхээр шулуудсан төр, засгийн хүмүүсээс урьтаж тус суманд очиж уулзалт хийж, нутгийн зон олны аж амьдралтай танилцаж ирээд, халхголчууд зээр зээл хоёроор амьдарч байна гэдэг үгийг “моод” болгосон. Тэгвэл саяхан С. Ганбаатар гишүүн УИХ-ын 75 дугаар тогтоолыг хүчингүй болгуулахаар “ангийн нөхөд”-өөсөө гарын үсэг цуглуулж эхэлсэн тухайгаа телевизийн ярилцлагад орох үеэрээ мэдэгдлээ. Тэрбээр хамт нэвтрүүлэгт орсон Хөдөлмөрийн сайд Г.Баярсайханаар “Хэрвээ Халх гол

угтана. Цуцлуулахгүй бол буу барьж угтана” гэж хатуу үгээр дайрч доромжилж, сайдыг ам нэлэгэсэнгүй буцаав. Аливаа асуудалд уужуу тайван ухаанаар ханддаг монголчууд тэр дундаа гүндүүгүй, эгэл боргилоороо алдартай хөдөөний ард түмний төлөөлөл төрийн сайдыг ийнхүү хэлэх хэлэхгүй үгээр доромжлон буцааж байгаа тухай зурагтын мэдээг харсан үзэгчдийн нүд орой дээрээ гарсан нь лав. “Хүн хэлээрээ мал хөлөөрөө” гэдэг ардын сайхан үгийг санаж, ажлаа хийж яваа хүнтэй үг сольж болмоор сон. Тэгээд эмэгтэй хүнийг тийм муухай хатуу үгээр доромжилж бараг барьж авч, зодох нь холгүй байгааг юу гэж ойлгох вэ. Бурмаа сайд тэднийг хоёр үг солих нь битгий хэл, царайг нь харахыг хүсэхгүй байхаар юу хийсэн бэ. Төрийн түшээд бүтэх бүтэхгүй шийдвэр гаргаж л байдаг, үнэхээр буруу бол ард түмнээрээ хэлэлцүүлээд тогтоол шийдвэрийг цуцлуулж болдог

Дорнод аймгийн Хилийн цэргийн застав, отрядын албан хаагчидтай уулзалт хийж, Халх гол сумын газар ашиглалтын талаарх ноцтой мэдээллүүд олж ирж, хэвлэлээр зарлав. Түүний гаргаж тавиад байгаа баримтууд хэрвээ хөдлөшгүй үнэн бол Халх голын сав газарт хэдийнэ дотоод, гадаадынхны шунал бугшжээ гэлтэй. Р. Бурмаа сайд сонинд өгсөн ярилцлагадаа “Бид чөлөөт бүсийн талаар цаг алдаж нутгийн иргэдэд мэдээлэл хийхээр очжээ. Өнгөрсөн хугацаанд тэдэнд мэдээллийг нэлээд гуйвуулж хүргэсэн байна. Ялангуяа сумын удирдлагуудынх нь хууль бус шийдвэр илчлэгдэх болонгуут тэрийгээ нуун далдлах гэж иргэдийг нэлээд төөрөгдүүлсэн байна. Тэдэнд чөлөөт бүсийн талаар ямар ч мэдээлэл алга” гэж онцолжээ. Мөн тэрбээр 2009 онд Халх гол сумын Засаг дарга Ц.Сүхбаатар, ИТХ-ын дарга Ц.Насанхүү нарын гарын үсэгтэй

“Хансолмо” гэдэг БНСУ-ын хөрөнгө оруулалттай компанид 30 мянган га газрыг мал аж ахуй, тэжээлийн таримал тарих зориулалттайгаар ашиглах тогтоолыг гаргасан байгаа юм. Мөн одоогийн Засаг дарга В.Мөнхтайван нэлээд олон мянган газрыг компаниудад өгсөн байна. Жишээлбэл, “Соёмбо буудай” компанид 1621 га газрыг 15 жилийн



**С.Ганбаатар гишүүн
75 дугаар тогтоолыг
цуцлуулж чадаад,
орон нутгийн оодорсон
дарга нарын эрх
мэдлээ хэтрүүлэн
ашигласан асуудалд
нь хариуцлага
тооцчихвол
халхголчууд тайван
амьдрах болов уу.
Үгүй л бололтой.
Р.Бурмаа сайдын
мэдээлснээр бол ашигт
малтмалын хайгуулын
лиценз тус нутгийг
онилон байгаа аж.**



хугацаатай ашиглах зөвшөөрлийг олгосон. Энэ компанийн ард Хятадын 95 хувийн хөрөнгө оруулалттай “Ergian Deyu organic Agriculture” гэдэг компани байдаг юм байна. Түүнчлэн “Үйзэн тал” гэдэг компанид 7000 га газар гээд Засаг дарга Мөнхтайван 7-8 үйлдлээр газрын зөвшөөрөл хууль бусаар өгсөн байна” гэж мэдэгдэв. Сайд энэ тухай УИХ, Засгийн газарт мэдээлэл хийх аж.

Ямартай ч Бурмаа сайдын хувьд салбарынхаа тариаланчдын холбооны тэргүүн Л.Цанадэлэгтэй хэл үгээ ололцохгүй хонь, чоно болоод байсан бол алс зайдуу сумын удирдлагуудтай

газрын асуудлаар арсалдахаар боллоо. Тэрбээр “Юун түрүүнд газар ашиглалтын талбай дээр хууль зөрчсөн үйл ажиллагааг таслан зогсоох хэрэгтэй. Үүний дараа чөлөөт бүсийн асуудлыг ярих нь зөв” гэснийг бодоход асуудал цаашаа нэлээд гүнзгийрч өрнөх шинжтэй болов.

Уг нь бол Халх голын орчимд атаршсан 30 мянган га талбайг газар тариалангийн зориулалтаар ашиглах нь зүйтэй гэсэн Засгийн газрын 2010 оны дөрөвдүгээр сард гаргасан тогтоол байдаг аж. 2011 онд орон нутаг руу энэ тухай санал тавьж байсан ч удаатай юм байна. Халх голын сав газарт хөдөө аж ахуйн үйлдвэрлэл явуулах талбайг нэмэгдүүлэх тухай судалгаа, шийдвэр цөөнгүй жилийн өмнөөс сонсогддог байсан. Гэхдээ өнөөдрийнх шиг хөдөө аж ахуйн чөлөөт бүс байгуулна гэж ил зарлаагүй л болохоос.

Мөн өнгөрсөн өдрүүдэд Монгол Улсын Ерөнхий сайд асан Ж.Наранцацралт агсны Халх голын сав газрыг ашиглахдаа байгаль экологийн хувьд нэлээд болгоомжтой хандах ёстой. Нэг хэсэгтээ тийшээ үйлдвэрлэл эрхлэх гэж яарах хэрэггүй юм гэсэн утгатай яриа өгч байсан нь сошиал ерөнцөд тавигдсан нь олон хүнд Халх голын газраар оролдох хэрэггүй, орхих нь зөв юм байна гэсэн ойлголтыг өгөө болов уу. Тогтоол шийдвэр гаргасан төр, засгийн холбогдох хүмүүс үүнийг олж үзээ байлгүй дээ гэж найдъя. Уг нь бол бодлого шийдвэр гаргагчид энэ мэтийн зүйлийг тогтоол шийдвэр гаргахаасаа өмнө ой ухаандаа оруулсан байх учиртай.

Ямар ч байсан Халх голын асуудал дээр огт улстөргүйгээр тавигдах нэг үнэн газар тариалан эрхлэх бол хуурай, эмзэг хөрс, дээрээс нь хаврын улиралд хүчтэй шороон шуурга балбадаг нутгийн онцлогийг нь бодолцон маш болгоомжтой хандах ёстой гэдгийг хашир туршлагатай агрономчид, хөдөө аж ахуйн эрдэмтэдийн төлөөлөл учирладаг билээ.

Нэг см хөрс бий болоход 300-500 жил зарцуулагддаг гэсэн судалгаа байдгийг галт тэрэг хөдөлгөхөөсөө өмнө бодоход илүүдэхгүй. Гэтэл Халх

голд 500.000 га талбайд хөдөө аж ахуйн чөлөөт бүс байгуулахаар байгаа нь иргэдэд хачирхал төрүүлж басхүү болгоомжлоход хүргээд буй юм. Экологийн хувьд эмзэг мэдрэмтгий газар ийм том талбайд чөлөөт бүс байгуулах нь эдийн засгийн хувьд хэр үр ашигтай байх бол оо гэдэг асуудал. Бурмаа сайд Халх гол сумын иргэдэд Чөлөөт бүсийн талаарх ерөнхий төлөвлөгөөний санал, судалгаагаа танилцуулахаар очсон гэж байгаа боловч өнөөдрийн байдлаар тэнд хаана нь ямархуу үйл ажиллагаа эрхлэх вэ гэдэг талаар тийм ч тодорхой мэдээлэл алга байна.

Харин Хүнс, хөдөө аж ахуйн сайд “хөдөө аж ахуй уул уурхайгаас илүү ашигтай салбар гэдгийг харуулах хүсэл надад бий. Хөдөө аж ахуйн чөлөөт бүс байгуулснаар богино хугацаанд буюу гурав дахь жилээс нь үр дүн гарна. Махнаас гэхэд 400 сая ам.долларын ашиг олох судалгаа хийсэн. Төсвийн орлого тасарчихаад цалин мөнгөө хасах дээрээ тулаад байгаа энэ үед хөдөө аж ахуйгаас орлого оруулах боломжтой” хэмээн тайлбарлажээ. Түүний энэ тайлбар нь иргэдийн дунд байгаа Бурмаа яагаад заавал хөдөө аж ахуйн чөлөөт бүс байгуулах гээд зүтгээд байгаа юм бол гэсэн асуултад хариулт болох бололтой.

Тэгвэл С.Ганбаатар гишүүн 75 дугаар тогтоолыг цуцлуулж чадаад, орон нутгийн оодорсон дарга нарын эрх мэдлээ хэтрүүлэн ашигласан асуудалд нь хариуцлага тооцчихвол халхголчууд тайван амьдрах болов уу. Үгүй л бололтой. Бурмаа сайдын мэдээлснээр бол ашигт малтмалын хайгуулын лиценз тус нутгийг онилон байгаа аж. Өөрөөр хэлбэл, энэ онд хайгуулын лиценз олгохоор зарлагдсан талбай энд бий гэнэ.

Халх гол хөдөө аж ахуйн чөлөөт бүсийн асуудал цаашид хэрхэн шийдэгдэхийг бид дараа уншигчиддаа үргэлжлүүлэн хүргэх болно.

Эцэст нь хэлэхэд буун дуу, бөмбөгдөлтийн галд сүйрээгүй Халх голын сав газар энх цагт эрх мэдэлтнүүдийн шунал, сонирхолд сүйдэх дээрээ тулаад байгаа хэрэг үү гэж гайхмаар.■

MONGOLIAN ECONOMY

MONGOLIAN ECONOMY

"Don't expect others to ask to dance"
Partners Linked Through History

www.mongolianeconomy.mn

MONGOLIA: HEART OF DEMOCRACY

Here Comes Cash Floods

Гүнзгий мэд

ТОМИЛОЛТ

“Skype” хочтой Эстони эргэлт

Б.Энхцэцэг

Дэлхийн олон орны иргэд дунд компьютер программчлал нь нүдний шил хамар дээрээ “тохсон”, олноос тасархай онцгой сэтгэн бодох чадвартай “ноомой” хүмүүсийн хийдэг ажил, зориглодог талбар гэх хэвшмэл ойлголт түгээмэл. Харин Балтийн тэнгисийг буландан оршдог Эстони хэмээх жижигхэн улс ард олноороо энэ ойлголтыг эвдэж, дэлхийн хөгжлийн чигийг шинээр тодорхойлж буйтай Монголын сэтгүүлчдийн төлөөлөл танилцлаа. Өдгөө тэднийг “E-stonia” гэдгээр нь олон улс илүүтэй таних болсон нь цахим ертөнцийг хөгжлийнхөө хөл болгож чадсантай нь холбоотой.



Эстони улсын нийслэл Талинн дахь хуучин хот

Фотое Ж.Хулан

Эстони 2007 онд бүх нийтийн сонгуулийг интернэтээр өгөх боломжтой болгосон анхны орон болсон бол энэ жил цахим иргэншлийг бусад улсын иргэдэд санал болгож буй мөн анхны орон боллоо. Интернэтийн сүлжээ аалзны тор мэт хэрсэн энэ улс нэг хүнд ногдох гарааны бизнесийн тоогоороо дэлхийд тэргүүлдэг. Таван минутад татвараа төлөөд, эрүүл мэндийн үзлэг мэдээллээ цахим орчинд хадгалан хянаж, автомашиныхаа зогсоолын төлбөрийг утасныхаа аппликейшнээр төлж, цахим иргэний үнэмлэх, гарын үсэг хэрэглэдэг цаасгүй, цахим орон. Тэгвэл 1.3-хан сая хүнтэй ердөө 45.000 ам.км газартай тэд яаж ингэж чадаваа?

Хэдийгээр Эстони нь Монголоос 5137 километрийн зайд оршдог Европ бүсийн жижиг орон ч эрс тэс уур амьсгалтай, жилийн дөрвөн улиралтайгаараа манайхтай төстэй. Гэвч ялгаатай нь тэнгисийн эргийг хөвөөлөн оршдогийн хувьд далай ээж Эстонийн цаг агаарыг чиглүүлэгч алтан гадас нь. Монголоос ирсэн сэтгүүлчид бид тэнгис тогтуун, тэнгэр цэлмэг байхад очсон ч далайгаас эхтэй салхи нь тайван алхах боломж өгөлгүй дотор жихүүцүүлж, дотогш тэмүүлэхэд хүргэж байлаа. Боломжгүйгээс болох хүртэл нь явсан эстоничуудын хийж бүтээснийг чихээрээ сонсож, нүдээрээ үзэх гэж явсан аялал биднийг нийслэл Талинд авчирлаа. Танихгүй хүнд тааламжгүй

ч, танилцаад ирвэл идэж буй тавагтаа хоолоо ч өгөхөөс буцдаггүй тийм л хүмүүс дээ гэж бидний аяллын хөтөч эстоничуудыг тодорхойлсон. Тэнгэр баганадсан биш ч орчин үеийн ур хийцтэй барилгуудтай шинэ хот дунд хуучин хот нэлээд зайг эзлэх нь аялал жуулчлалын салбарын хувьд соронз, эдийн засгийн хувьд мөнгө үржүүлэгч.

Мэдээллийн технологи, бизнесийн зангилаа болсон нийслэл Талин нь 150 гаруй технологийн компанийг өлгийдөн өсгөж буй газар. Эстонийн дотоодын зах зээл маш жижиг учир гарааны бизнес эрхлэгчид анхнаасаа л гадаад зах зээл рүү хараагаа бэлчээж, бизнесээ төлөвлөхөд хүрдэг. Тиймдээ ч Эстониос угшилтай “Skype” компанийн замналд олон

бизнесүүд хөтлөгдөн урагшилдаг. Дэлхийн банкны мэдээгээр Эстони улсад 2011 онд л гэхэд 14.000 шинэ бизнес үүдээ нээсэн байдаг нь 2008 оныхоос 40 хувиар өссөн үзүүлэлт. Тэр дундаа өндөр технологийн салбар тус улсын нийт ДНБ-ий 15 хувийг эзэлж байна. Эстонид 1980 оны үед ахлах сургуулийн эрэгтэй сурагч бүр рок од болохыг хүсдэг байсан бол өдгөө өсвөр насныхан бүгд шинийг санаачилж, бизнес эрхлэгч болохыг хүсэх болжээ. Эстони хүүхдүүдэд дөнгөж таван настайгаас нь кодчиллол заадаг нь цаасан дээр бус компьютер дээр зураг зурахыг зааж байгаатай агаар нэг.

Өдгөө Эстони гэхээр дэлхий нийт хүн амын дийлэнх хоёр зүйлийг нэн тэргүүнд онцолдог нь нэгдүгээрт “Skype”, хоёрдугаарт Олимпт гаргасан амжилт. Эстоничуудын хөгжүүлсэн “Skype” цахим талбарын амжилт тус улсыг өндөр технологийн дэвжээнд хурдаа авахад хүчтэй нөлөөлсөн. Хэдэн зуун сая хувь хүн, бизнес эрхлэгчдийн өдөр тутмын харилцааны хэрэгсэл болсон энэхүү программыг 2011 онд 8.5 тэрбум ам.доллараар “Microsoft” компани худалдан авч эзэмших болсон билээ. Нэг үхрийн эвэр доргивол мянган үхрийн эвэр доргино гэдэг шиг “Skype”-ын амжилтыг дагаж Эстонийн олон бизнес эрхлэгчдийн дэлхийд хөл тавих шат намсаж, бизнесүүд нь эрчээ авсан. Энэ нь тус компанийн амжилт зөвхөн тухайн компанийнх бус Эстонийнх гэдгийг гэрчилнэ. Хэдийгээр “Skype”-ын эзэмшигч өөрчлөгдсөн ч төрүүлсэн эцэг нь Эстони. Тиймдээ ч тус компанийн толгой нь Эстонийн нийслэл Талин хотод байршдаг төдийгүй нийт ажиллагсдынх нь дийлэнх хувь эстоничууд хэвээр аж.

Тус улсад очоод танайх юун их техник технологи болоод явчихаа вэ гэж сонирхлоо л доо. Балтийн тэнгисийг бараадан орших гурван гүрний нэг Эстонийг өнгөрсөн 300 шахам жил Герман, Дани, Швед, Зөвлөлт Холбоот Улс толгой өндийх завдал өгөлгүй, хаяагаа мануулсан бол өнөөдөр цахим ертөнцийн ачаар тус улс хувь заяагаа өөрсдөө залж буй. Ердөө 35 настай Март Лаарын залуу Засгийн газар 1992 онд эдийн

засгийнхаа зүрхний хэмнэлд өөрчлөлт оруулах шийдвэр гаргасан. Хоёрхон жилийн дотор тэд орлогын зөрүүг үл хамаарсан тэгш татварын бодлого, чөлөөт худалдаа, үндэсний мөнгөн тэмдэгтийн болон хувьчлалын хүчтэй бодлогыг авчирсан байдаг. Мөн Засгийн газар шинээр бизнес эрхлэгчдийн замыг цэвэрлэж, компани байгуулахад ямар ч хүлээлтгүй болгож өгсөн нь гол түлхэц байв. Финлянд улс тухайн үед утасны холболтуудаа тоон систем рүү шилжүүлэхдээ, 1970-аад оны хуучны аналог системээ Эстонид үнэгүй өгье гэсэн ч тэд аваагүй агаад өөрсдийн гэсэн харилцаа холбооны тоон системээ бүтээж эхэлсэн байна. Өөрөөр хэлбэл, Эстонийн залуу сайд уламжлалт технологид бус интернэтэд хувь заяагаа даатгасан байдаг. Өнөөдөр нийт эдийн засгийн хэмжээ нь 26 тэрбум ам.доллартой тэнцэж буй бол нэг хүнд ногдох ДНБ манай улсынхаас зургаа дахин их буюу 27 мянга шахам ам.доллар бөгөөд өндөр орлоготой орнуудын тоонд ордог. “Манай нийт эдийн засагт тээвэр зуучлалын салбар 10 жилийн өмнө давамгайлах байр суурь эзэлж байсан. Харин одоогоос 3-4 жилийн дараа гэхэд Мэдээлэл технологийн салбар эдийн засгийн салбарын гол тоглогч болно” гэж харж байна хэмээн программ хөгжүүлэлтийн Нортал компанийн ТУЗ-ын гишүүн Олег Шайковски бидэнтэй уулзах үеэрээ хэлсэн. Товчхондоо, тэд мэдлэгт 100 хувь суурилсан эдийн засаг болохоор санаа шулуудаж.

ЦААСНААС ЦАХИМ РУУ

Зөвлөлтийн гэгддэг байсан улсууд өдгөө авлигалд живж байхад, эстоничууд авлигалыг үндсээр нь булгалахын тулд цахим хувьсгал хийж, Засгийн газартай холбоотой бүх төрлийн харилцааг цахимжуулж, иргэд төр хоёрын нүүр тулсан харилцааг үгүй хийж, авлигал өгөх боломжийг хазаарласан байна. Товчхондоо, цаас, тамга, урт дараалал нь “Е-Засаглалд” байраа бүрэн тавиад өгчихсөн учир авлигаас ангид орон болсон гэх. Засгийн газар нь өөрөө энэ тал дээр манлайлах үүрэг гүйцэтгэж, нээлттэй, шуурхай, байгальд ээлттэй байх үүднээс цахим танхим /e-Cabinet/

хэмээх тогтолцоог 2013 онд бүрэн нэвтрүүлжээ. Улмаар Засгийн газрын гишүүд нь цахим орчинд хэлэлцэх асуудалтайгаа танилцаж, бие биедээ асуулт тавьж урьдчилсан байдлаар санал хураадаг байна. Ингэснээр өмнө нь 4-5 цаг шаарддаг байсан хуралдаан өдгөө 30-хан минут үргэлжлэх болжээ. Тус улсад өдгөө цаасан дээр гарын үсэг зурдаг нэг ч хүн байхгүй гэдгийг Эстонийн Парламентийн дарга Эйки Нестор хэлсэн юм. Нэг л тохиолдолд цаасан дээр гарын үсэг зурдаг нь Монгол шиг орнуудын мэргэжил нэгтнүүддээ албан захиа илгээхэд гэнэ. Тэрбээр өөрөө Засгийн газрын түвшний бичиг баримтуудтай



• 16-74 насны нийт хүн амын 80 хувь интернэт хэрэглэдэг

• Нийт өрхийн 83 хувь нь интернэт холболттой

• Нийт өрхийн хүүхдүүдийн 98 хувь нь интернэт ашиглах боломжтой

• Нийт банкны гүйлгээний 98 хувь интернэтээр хийгддэг

• Орлогын татвар мэдүүлэлтийн 95 хувь интернэтээр хийгддэг

цахимаар хэрхэн танилцаж, гарын үсэг зурдагийг биечлэн бидэнд үзүүлсэн билээ.

Өдгөө эстоничуудын хүртдэг бүх төрлийн үйлчилгээ урдаа ‘e’ үсэгтэй. Энэ нь тэдгээр үйлчилгээнүүдийг бүгдийг цахимаар авч болно гэсэн утгатай. Өдөртөө бараг 2000 төрлийн e-үйлчилгээг эстоничууд тогтмол хэрэглэдэг нь e-гүй юм энэ улсад бараг байхаа болсоныг харуулж буй. Тухайлбал, эстоничуудын 30 гаруй хувь нь өдгөө сонгуулиа интернэтээр өгч, 95 хувь нь орлогын татвараа интернэтээр мэдүүлж, 98 хувь нь банкны гүйлгээг интернэтээр хийж байгаа юм. Энэхүү татвар төлөх үйл явц манай улсад хэдэн өдрийн ажил бол Эстонид ердөө л таван минутын ажил. Эгээтэй л

интернэтээр эмнэлэгт үзүүлчихгүй юм. Гэхдээ эрүүл мэндийн салбар ч 'е'-д шилжиж. Тус улсад компьютер, цахим үнэмлэхээ ашиглаад бизнес нээхэд ердөө 18-хан минут шаардагддаг байна. Тэд өндөр настнууддаа хүртэл е-үйлчилгээгээ хэрэглүүлэхийн тулд компьютерийн хэрэгслээр бүрэн тоногдсон автобусууд хот хооронд явуулж, зорчих хугацаанд нь энэ бүгдийг заах кампанит ажил явуулж байсан нь ихээхэн үр дүнд хүрсэн гэж албаны хүн хэлсэн.

Улс даяар 1998 оноос эхлэн бүх сургуулиудад компьютер суурилуулах үйл ажиллагаа эхэлж, 2000 онд тус улс интернэт дэх гарцыг хувь хүний эрх хэмээн зарласан байдаг. Өдгөө утасгүй интернэт энгийн үзэгдэл болсон төдийгүй, бараг хаа ч үнэгүй үйлчилгээ болжээ. Төрийн өмчит "Enterprise Estonia" компанийн төлөөлөгч Карли Сувисилд "Манай улсын ой модонд хүртэл утасгүй интернэт бий" хэмээн хошигносон. Гэхдээ энэ нь хошигнол гэхээсээ илүүтэй бодит үнэнд илүү нийцэхээр юм билээ. Хот, хөдөөд хаана ч интернэтгүй байна гэж үгүй. Эстонид хүүхдүүдийг төрөөс мэдээлэл технологийн тэсрэлтэт хөгжлийнх нь ирээдүй гэж үздэг тул тэднийг нэн эрт энэхүү цахим ертөнцтэй танилцуулдаг. Сургуулийн хүүхдүүд хичээлийн хуваарь, сонголт, даалгавар, дүн гэх мэт бүхий л мэдээллийг "eKool" хэмээх цахим программаар солилцох бөгөөд энэ талбар нь эцэг эхчүүдэд нь ч нээлттэй. Харин хүүхдүүд энэ программдаа тийм ч дуртай биш

гэсэн. Учир нь тэд хичээлээ таслах, даалгавраа хийгээгүй байх, муу дүн авах зэргийг эцэг эхчүүд хялбархаан мэдчихдэг. Эстоничууд тун удахгүй цэцэрлэгийн түвшинд энэхүү цахим харилцааны аргыг туршиж эхлэх гэж байна. Бидний хэдэн сэтгүүлч тус улсын "HITSA" буюу Боловсролын төлөөх мэдээлэл технологийн санд зочлох үеэрээ тавдугаар ангийн багш нар роботын тэмцээнд оролцохоор бэлдэж буйтай танилцсан. Мөн бага ангийн хүүхдүүдэд компьютерийн программчлалыг хэрхэн зааж, тоглоомон жижиг робот хийж мэдлэгээ туршдагийг мөн бидэнд үзүүлсэн.

Эстониин Засгийн газрын хувьд нийгэмд эерэг үр нөлөөтэй үйлчилгээг нэвтрүүлэх тал дээр хувийн хэвшлээ ихээхэн дэмжин ажилладаг бөгөөд жил бүр тухайн оныхоо хамгийн шилдэг е-үйлчилгээнүүдийн нэрсийг зарладаг байна. Тухайлбал энэ жилийн шилдэг е-үйлчилгээ болох гар утасны зогсоол хайх "Barking" аппликейшнд хүрэх газраа оруулахад танд боломжит зогсоолуудыг мэдээлэх ба аль нэгийг нь сонгоод төлбөрөө төлдөг. Эстоничууд үүнийгээ би өөрөө зогсоол хайх бус зогсоол намайг олдог гэх юм билээ. Мөн л шилдэг е-үйлчилгээнүүдийн нэг Цахим замын хяналт буюу тээврийн хэрэгслийг зогсоолгүйгээр хөндлөнгөөс шалгах үйлчилгээг нэвтрүүлснээр тус улс ажлын цагаар тооцбол 5000 цагийг энэ жил хэмнэсэн тооцоо гарчээ. Машинтай иргэн өөрт нь хэдэн удаа хөндөнгийн шалгалт хийснийг Засгийн цахим хуудас руу ороод мэдчихэж болох ба энэ нь нээлттэй мэдээлэл аж. Олег Шайковскитой уулзах үеэр тэрбээр "Тухайлбал, намайг энэ жил гэхэд 200 гаруй удаа шалгасан бөгөөд энэ хооронд нэг л удаа цагдаа зогсоосон. Тэгэхэд урьд өдөр нь миний төрсөн өдөр болсон учир согтуугаар жолоо барьж явах магадлалтай гэдэг үүднээс зогсоосон байсан" гэсэн юм.

Энэ бүх е-харилцааны ард цахим үнэмлэх гол үүрэг гүйцэтгэдэг. Эстони цахим үнэмлэхийг нэвтрүүлсэн анхны орон. Хүн бүхэн өөрийн



• Хүний хөгжлийн индекс 152 орноос 22 дугаарт

• Эдийн засгийн эрх чөлөөний индекс 186 орноос наймдугаарт

• Дэлхийн эрх чөлөөний индексээр нэгдүгээрт

• Бизнес хийх орчны индексээр 189 орноос 16 дугаарт

гэсэн цахим үнэмлэх, олгогдсон нууц дугаартай. Монголчуудынх шиг цахим үнэмлэх л дээ ер нь бол. Бид маш хязгаарлагдсан хүрээнд ашиглаж байгаа бол эстоничууд алхам тутамдаа хэрэглэж буй. Өөрөөр хэлбэл, сонгууль, нийтийн тээвэр, эрүүл мэнд, банк, гадаад явах, гарын үсэг зурах гэх зэрэг олон талаар ашигладаг. Энэ үнэмлэхийг хаясан ч олсон, хулгайлсан хүн нууц дугаарыг мэдэхгүй учир ашиглах боломжгүй. Тус улсад нийт 1.2 сая идэвхтэй цахим үнэмлэх бий гэнэ. Одоо энэ цахим үнэмлэхийн ид шидийг ухаалаг утсан дээр мөн ашиглаж болдог.

ИРЭЭДҮЙ РҮҮ

Газар нутгийнхаа хэмжээгээр дэлхийд 131 дүгээрт эрэмблэгддэг Эстони нэг хүнд ногдох гарааны бизнесийн тоогоор Европт тэргүүлдэг. Гарааны бизнесийн "ганган" тоглогчид ч гэсэн сул талууд бий. Энэ улсад борлуулалт маркетинг тийм ч хүчтэй биш. Жижиг орны гарааны бизнесүүд томроод ирэхээрээ гадагшаа борлуулалт хийхийн тулд менежментийн багаа аваад арилад өгсөн жишээ олон байгаа. Энэ нөхцөлд гадныхны асуудаг ганц асуулт нь Эстониин гарааны бизнесийн гайхамшиг хэр удаан үргэлжлэх вэ гэдэг юм. Гэхдээ цахим ертөнцийг бага хүн амтай улсын хувьд аврал гэж харах эстоничууд энэ асуултын хариуг олчихсон нь цахим иргэншил. Шинэ бизнес, хөрөнгө оруулалтыг

ТҮЛХҮҮР БАРИМТУУД /2014/

Хүн ам	1.32 сая
Мөнгөн тэмдэгт	Евро
ДНБ	25.90 тэрбум \$
ДНБ өсөлт	2.9 %
Нэг хүнд ногдох ДНБ	27.729 \$
Ажилгүйдлийн түвшин	7.4 %
Цалингийн хэмжээ дундаж	1107 \$
Төсвийн тэнцэл	-0.1 /ДНБ-д эзлэх %/
Худалдааны тэнцэл	-1.8 тэрбум \$
Худалдааны гол түнш	Швед, Финлянд, Латви, Орос
Гадаадын шууд хөрөнгө оруулалт	17.4 тэрбум \$
Гол экспорт, импорт	1. Тоног төхөөрөмж, эд анги, 2. Ашигт малтмал, 3. Газар тариалан, хоол бэлтгэл
Эстон нийт худалдааныхаа 78 хувийг евробусийн орнуудтай хийдэг	

Эх сурвалж: www.e-estonia.com

татах зорилготой эхлүүлсэн цахим иргэншлийн хүрээнд он гарсаар Эстони улс 119 орны 6000 иргэнтэй болоод байна.

Газрын хөрснөөс арчигддаггүй юм аа гэхэд, хамаг мэдээллээ арчуулчихвал бүрэн цахимжсан Эстони яах вэ гэдэг асуулыг Батлан хамгаалахын сайд Ханнес Хансод тавилаа. Тэрбээр “Ийм халдлага бидэнд тохиолдож байсан. Тэр тоолонд бид туршлагажиж ирсэн. Бид энэ төрлийн халдлагуудыг давж гарах талд аль ч улсаас илүү дэвшилтэт байдлаар ажилладаг” гэсэн юм. Эстонийн төр болон хувийн хэвшил энэ бүх мэдээллүүдээ үйлчилгээ бүрээр нь мэдээллийн тусдаа сангуудад байрлуулдаг. Тэдгээрийг “X-Road” хэмээх сүлжээ хооронд нь холбож, мэдээлэл солилцох талбар болж байдаг. Бүх мэдээллийг нэгдсэн нэг санд байрлуулах нь өөрөө том эрсдэл учир 170 санд ангилан байрлуулдаг байна. Интернет байгаа цагт, ямар ч цахим халдлагын үед бүхий л мэдээллийг нөөцөлж, эргээн

сэргээх боломжтой гэж тэд үзэж байна. Тиймээс Засгийн газар энэ үед ч ажлаа нэг их алдаад байхгүй яваад л байх юм гэнэ. “Enterprise Estonia” компанийн төлөөлөгч Карли Сувисилдийн хэлж байгаагаар бол газар доор зургаан интернэтийн шугам явж буй бөгөөд аль нэг нь гэмтвэл нэг нь нөгөөгөө нөхөж ажиллах юм байна. Хэрвээ бүх шугам тасарвал сансарт хөөргөсөн хиймэл дагуулаа ашиглана гэж хэллээ. Мэдээллээ арчуулахын нөгөө талд мэдээллээ өгөөд сууж байгаа хүмүүс айх болсон нийгэмд эстоничууд даяаршсан айдаст автдаггүй юм билээ. Тэртээ тэргүй сошиал сувгуудад хамаг хувийн мэдээллээ сайн дураараа өгөөд сууж байж, үйлчилгээ үзүүлэх гэсэн Засгийн газраасаа яагаад мэдээллээ харамлах ёстой гэж тэд хардаг.

Ердөө 1.3 сая хүн амтай ч хүчирхэг санаануудаараа дэлхийн технологийн ертөнцөд тод мөрөө үлдээж чадсан эстоничуудын хувьд “Том харж цараатай сэтгэх” нь үндэсний сэтгэлгээ болчихсон гэж Форбес сэтгүүл

дээр бичсэн байдаг. Эстоничуудыг төгс мэдлэгийн эдийн засагт хүргэх дараагийн шат нь е-үйлчилгээний тавдугаар үе гэж тэд тодорхойлж буй. Тэдний тодорхойлолтоор бол бид энэхүү засаглалын хувьд гурав дахь үе хавьцаа л явж буй юм билээ. Гаднын хүнд зөгнөлт кино биеллээ олсон мэт сэтгэгдэл төрүүлдэг мэт Эстонид өнгөрүүлсэн хэд хоногийн хугацаанд эстоничууд хурдтайгаар хийгээд, алдаад, засаад сайжруулаад урагшилдаг хүмүүс гэдгийг олж харлаа. Тэд бидний зорьж буй ирээдүйд амьдарч байна. Тус улсын төр энэ бүгдийг хийчихээгүй. Хувийн хэвшилд хийх хууль эрх зүйн боломжийг нь гаргаж, дэмждэг учир өдгөө өдөр бүр шинэ бүтээл, бизнес тус улсад төрдөг. Бусад хөгжиж буй улс яагаад энэхүү цахим засаглал руу шулуудаад орчихгүй байна вэ гэдэг асуултад идэж ууж болдоггүй ийм ил тод тогтолцоог ямар ч улсын шийдвэр гаргагчид тийм ч хурдан бүрэн хүлээгээд авчиж зүрхлэхгүй хэмээн Эстонийн төр хувийн хэвшлийн төлөөлөл хэллээ. ■



Зурагт Эстонийн Парламентийн дарга Эйки Несторын хамтаар. Бүгд найрамдах Эстони улсын Гадаад харилцааны яам, Эстонийн Бээжин дэх ЭСЯ, Монгол улс дахь Эстонийн Өргөмжит консулын газар болон Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэл хамтран Таллинны их сургуулийн Балтийн кино урлаг, медиа сургуульд суралцах богино хугацааны тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлж, Монголын хэвлэл мэдээллийн салбарт ажиллаж буй 7 сэтгүүлчийг шалгаруулан авч явж, Эстони улсыг зориод ирлээ

Д.Баасан: Манай салбарт маш сайхан ирээдүй бий

И.Отгон

Манай сэтгүүлийн “Үйлдвэрлэл” булангийн энэ удаагийн зочноор “Мон Ланс” компанийн захирал Д.Баасан уригдлаа. Тэрбээр Чех улсад арьс ширэн эдлэлийн зохион бүтээгч мэргэжил эзэмшиж ирсэн цагаасаа хойш энэ салбарт 30 гаруй жил хоёргүй сэтгэлээр зүтгэж яваа нэгэн. Социализмын үед гадаадад төгссөж ирсэн шинэхэн мэргэжилтэн “Монгол савхи” компанийн зохион бүтээгчээр ажиллаж, үйлдвэр аж ахуйн газрууд хувьчлагдтал тус үйлдвэртээ ажиллажээ. 25 жил тасралтгүй үйл ажиллагаа явуулж буй өөрийнхөө “Мон Ланс”-ыг жижгийн жижиг гэж тодорхойлсон Баасан захирал Монголын арьс ширэн бүтээгдэхүүн дэлхийд гайхагдах цаг хугацаа тун ойрхон ирсэн гэдэгт дэндүү итгэлтэй аж. Бидний яриа валютын урсгалыг дотогшоо чиглүүлж чадах нэг салбар арьс ширний үйлдвэрлэл атал яагаад дотооддоо санаанд хүртэл хөгжихгүй байгаа, хөгжүүлэхийн тулд юу хийх ёстой талаар өрнөсөн юм.

-Саяхан тодруулбал өнгөрсөн сарын 16-нд Аж үйлдвэрийн яамнаас зохион байгуулсан “Made in Mongolia” үйлдвэрлэлийн форумын үеэр хүндтэй зочид, төлөлөгчиддөө монгол брэндийг харуулсан цүнх өгсөн нь танай бүтээгдэхүүн байсан байна лээ. Facebook-т уг цүнхний зургийг тавьсан нь дотоод, гадаадаас маш их тандалт авсан байсан. Энэ талаар таны сэтгэгдлийг сонсьё.

-Их сайхан үйл явдал болсон. Баяртай байгаа. Монголоо гэсэн сэтгэлтэй болгон бүтээгдэхүүнийг маань хэрэглэж байхад үндэсний үйлдвэрлэгчдийн хувьд маш том дэмжлэг тэр юм. Сүүлийн үед манай хүмүүст дотоодын үйлдвэрлэлээ дэмжье, бараа бүтээгдэхүүнийг нь хэрэглэе гэсэн сэтгэхүй суух хандлага байна. Угаасаа харагдаж байна. Тэр Facebook-т тавьсан манай бүтээгдэхүүнд өгсөн лайк болон урт

гэгч нь сайхан сэтгэгдлүүдийг хараад үнэхээр урам авсан. Улам илүү сайхан хийгээд, дотоодын хэрэгцээг хангах юмсан гэсэн бодлыг өөрийн эрхгүй төрүүлж байна. Ажилчид маань хүртэл “Facebook хараад ямар гоё юм бэ. Хийсэн бүтээснээрээ бахархаж байна. Монголын ард түмэн чинь нэгнээ сайхан дэмждэг юм байна ш дээ” гээд баяр хөөрөөр дүүрэн байхыг харах сайхан байлаа. Гадаадаас ч миний мэйл хаягаар маш их захиалга орж ирсэн байсан. Сэтгэгдлээ илэрхийлж байгаа бүх хүн бүтээгдхүүн авахгүй шүү дээ. Заавал худалдаж авахдаа гол биш, нэг хэсэг нь авна, нэг хэсэг нь сэтгэлээрээ дэмжсэн. Энэ бол үндэсний үйлдвэрлэлээ дэмжье, хэрэглэе гэсэн сайхан уриалга гарч байгаатай ялгаагүй. Нөгөө талаас энэ салбарт зах зээл байна, хөгжил байна гэдгийг харуулж байгаа хэрэг. Энэ дэмжлэг нь манай арьс ширэн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрчдийн

хувьд өгсөн дүгнэлт гэж бодож байгаа.

-Монголд цүнхний олон үйлдвэр байдаг. “Мон Ланс”-ын бусдаас ялгарах давуу тал юу вэ?

- Сүүлийн үед арьс ширээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн хувьд гутал, хувцас, боловсруулах үйлдвэрүүд ч цүнх жижиг эдлэл хийдэг болсон. Өрхийн үйлдвэрлэлтэй нийлүүлээд тооцвол бараг 200-гаад үйлдвэрлэгч болох байх.

Манай компани салбартаа тасралтгүй 25 жил үйлдвэрлэл явуулж байгаа анхны хувийн хэвшлийн цүнхний үйлдвэр юм. Тэгэхээр энэ олон жилийн үйлдвэрлэлийн туршлага, олон тооны бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадал, улсынхаа татвар /НӨАТ, ААНОАТ, ЭМНД, ХХОАТ/-т оруулсан хувь нэмэр, бүтээгдэхүүний загвар дизайн чанараараа ялгарах байх гэж боддог шүү. Манай бүтээгдэхүүн ихэвчлэн захиалгаар хийгдээд голдуу экспортод гардаг. Бүтээгдэхүүнээ ОХУ,



Фотос Б.Бямба-Очир

“Мон Ланс” цүнхний анхны хувийн үйлдвэр

Казахстан, Хятад, Герман, БНСУ руу гаргаж байна.

-Дотоодод үндэсний үйлдвэрийн арьсан бүтээгдэхүүн өндөр үнэтэй байдаг. Явал бүтээгдэхүүний үнэ хямдрах вэ?

-Энд бас л жижиг, томыг ярих гээд байна. 3-5 хүнтэй үйлдвэр цөөн тооны бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. Байрны түрээс, цалин гээд зөндөө зардал гарна. Гэтэл цөөхөн юм үйлдвэрлэж гаргаж байгаа болохоор цөөн барааны нэгжийн үнэ өндөр байжийж зардлаа нөхнө шүү дээ. Бүтээгдэхүүн олон ширхэгээр гарах тусам нэгжийн үнэ буурах ёстой. Цөөн тооны үйлдвэрлэл хэзээ ч хямдрахгүй. Үйлдвэрүүд том байж, олон тоогоор үйлдвэрлэж байж ард түмэнд хямд бүтээгдэхүүн очино. Тийм болохоор манай зах зээлд дотоодын бүтээгдэхүүн үнэтэй гэж ярьдаг. Массын үйлдвэрлэл байхгүй юм чинь аргагүй. Үйлдвэрлэлд 20 хувийн ашиг маш өндөрт тооцогддог. Гэтэл манай жижиг, дунд, өрхийн үйлдвэрлэл өртгөө 100-200 хувь хийж байж амьдарч байна. Цүнхний тоног, цахилгаан, дотор бүх юм импортын. Ганцхан арьс нь л дотоодынх. Импортын бараа санаснаар хямд олдохгүй шүү дээ. Гэх мэт нөлөөлөх зүйл олон. Тиймээс бүтээгдэхүүний үнийг хямд байлгая гэвэл олон жижиг үйлдвэр биш, их хэмжээгээр үйлдвэрлэдэг том үйлдвэрүүд байх ёстой.

-Та салбарынхаа ирээдүйг хэрхэн төсөөлдөг вэ. Уг нь томорч хөгжих боломжтой салбар атал өнөөдрийг хүртэл жижиг хэвээр байгаад байна. Цаашид юунд анхаарч ажиллах ёстой вэ?

- Зовлон яривал их л дээ. Гэхдээ би хувьдаа аль болох гэгээлэг талаас нь хардаг. Манай салбарт маш сайхан ирээдүй бий гэдэгт итгэдэг. Хэрвээ зөв хөгжүүлбэл Монгол Улсын эдийн засагт маш их юм өгч чадах салбар. Өгч ч байсан түүхтэй. Дахин хэлэхэд одоо жижигрүүлж л болохгүй. Бүр жижгэрчих гээд байгаа. Тодорхой үйлдвэрүүдийг бодлогоор томруулж бусад жижиг үйлдвэрээ кластераар хөгжүүлээд аваад явах хэмжээний жишиг томоохон үйлдвэрүүдийг бий болгох хэрэгтэй. Тэр дундаа манай эцсийн бэлэн бүтээгдэхүүн

Аж үйлдвэрийн яам өнгөрсөн сарын 16-нд анх удаа “Made in Mongolia” үйлдвэрлэл эрхлэгчдийн томоохон хурал хийсэн. Уг хуралд дотоод, гадаадын 500 гаруй зочин төлөөлөгч оролцсон юм. Зохион байгуулагчдын зүгээс хүндтэй зочин болох 400 хүнд арьсан цүнх бэлэглэж, ү н д э с н и й үйлдвэрлэлээ сурталчилсан. Загвар, хийц, өнгө үзэмж ү н э х э э р ванлий уг цүнхийг аваагүй 100 хүнд гэгээн атаархал төрж, авсан хүмүүс нь сошиал ерөнцийг Монголын үндэсний үйлдвэрлэлээр амьсгалуулсан. “... Монголчууд үнэхээр сайн хийж чадаж байна. Арьс ширэн бүтээгдэхүүнээр дэлхийн брэнд бүтээх цаг болсон байна...” гэх мэт

с ай х а н



үйлдвэрлэгчид маань жижиг дундын жижиг нь гэж би хэлдэг юм /инээв/. Жижиг дундын арай том байж болно оо доо.

-Яагаад. Жишээ нь танай үйлдвэр гэхэд 25 жилийн туршлагатай, хүмүүст танигдсан биш үү?

-Үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний хэмжээ, ажиллах хүчний тоо энэ тэрийг харьцуулбал арьс ширэн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийнхээ дотор жижиг

сэтгэгдлүүд тоо томшгүй хөвөрсөн. Лайкын хэмжээ нь л бол бүр хэдэн зуун сая даваад талийсан байлаа. “Дархан нэхий” компанийн боловсруулсан арьсаар “Хишгээ фэйшн” компани загварыг нь гаргаж, “Мон Ланс” компани урласан уг цүнхийг Аж үйлдвэрийн яам зүгээр ч нэг захын арьсан эдлэлийн

үйлдвэрээс авчихаагүй бололтой. Эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрүүдийн дунд загварын сонгон шалгаруулалт явуулж, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн чадлыг шалгаад авав бололтой.

“Мон Ланс” компани форумын үеэр тараасан цүнхийг хоёр талд нь нүүртэй болгож, мөн үүргэвч хэлбэртэй болгож загварыг нь сайжруулсаар.

орохгүй л дээ. Ерөнхий объёмоор нь харьцуулахад бид дэндүү жижигхэн. Өнөөдөр манайд олон улсын том үзэсгэлэнд зардлаа даагаад явах хэмжээний үйлдвэр хэд байна гэхээр хэцүү шүү дээ. Олон улсын үзэсгэлэнгийн павилион 40-50 мянган доллар. Ам метр нь 5000, 8000 ам долларын үнэтэй. Нэгэнт оролцож байгаагийнх нэг ам метр лангуун дээр бүтээгдэхүүнээ тавина гэж байхгүй. Сайхан тохижилттой, улсынхаа нэрийг гаргаж оролцоход адаглаад 18 ам метр

талбай авмаар санагдана. Гэтэл тэр санхүүг даах газар манай салбарын жижиг, дунд үйлдвэрлэлд байхгүй. Хийц загвараар хаанахын хэнд ч гологдохооргүй бараа бүтээгдэхүүн хийж болж байна. Хийсэн бүтээснээ гадагшаа сурталчилах хүсэл сонирхол маш их байдаг. Ганцхан эдийн засагтаа баригддаг. Жишээлбэл, Италийн том үзэсгэлэнд манайх ганцаараа оръё гэж бодоход 50-60 мянган ам.доллар гаргаж байж тэнд очиж бүх юмаа хийнэ. Буудал, тээврийн зардал, ачаа тээш, павилионыхоо интрьер дизайн бүх зүйлээ цогц болгоод аваад явъя гэхэд үнэхээр хүнд. Тэгэхээр энд байхын тулд бид нэгдэх ёстой. Томорч байж гадагшаа зах зээл рүү том харж үйлдвэрлэл эрхлэнэ. Гадаадаас тэр хэмжээгээрээ захилга авна. Захиалгаа нэгдсэн журмаар авлаа, үйлдвэрүүддээ тарааж хийлгээд, экспортолдог нэгдсэн систем хэрэгтэй байгаа юм. Тэгэхгүйгээр явахад тун бэрх.

- Төр та нарын олон улсын үзэсгэлэнд оролцох бололцоог хангаад ядаж павилионых нь төлбөрийг хүртэл хийгээд өгвөл итгэл хөсөрдүүлэхгүй яваад ирэх үү ?

-Чадна гэдэгт бүрэн итгэж болно. Манай салбарт маш гоё ирээдүй байгаа гэж би дахин дахин хэлэх дуртай. Тийм болохоор их гоё хөгжүүлэх ёстой юм. Бид өнөөдөр өөр өөрсдийнхөө хэмжээнд гадаадын үзэсгэлэнгүүдэд оролцож байна. Явах тоолондоо олзтой ирдэг. Гэтэл үйлдвэрүүд хэт жижиг учраас захиалгаа дийлэхгүй хэмжээнд бий. Олон улсын үзэсгэлэнд том оролцсоноороо ямар үр дүн гардаг вэ гэдэг туршлагыг би мэддэг. Намайг "Монгол савхи" компанийн зохион бүтээгч байхад Францын үзэсгэлэнд оролцсон юм. Тухайн үед Арьс ширний үйлдвэрийн нэгдэл гэж байсан. Томч павилион ч авсан. Тэгэхэд тэр том үзэсгэлэнгээс маш их захиалга авч чадаж байсныг нүдээрээ хараад сууж байлаа. Том үзэсгэлэнд орж, том захиалга авдаг гэдгийг би эндээс харсан.

Нэгэнт бид мөнгөө гаргаж чадахгүй юм чинь яахав дээ, тэр хэрэгтэй хэрэггүй юманд зараад байдаг мөнгөнөөсөө бидний павилионыг

аваад өгч болно. "Павилионыг чинь яам аваад өгье. Та нар өөрсдөө зардлаа даагаад, Монгол Улсын нэрийг гаргасан дээд зэргийн бүтээгдэхүүн хийгээд олзоомогтой явж ирнэ шүү, нөхдүүд минь" гэвэл дор бүрнээ л хариуцлагатай хандаж, сайн явж ирэхийн төлөө хичээнэ. Төрөөс тэр их өндөр мөнгө төлөөд дэмжээд өгчихсөн байхад хүн юм чинь нэг юм бодно оо доо. Гэх мэтээр үйлдвэрүүдэд юу дутагдаж байна, хаана нь ямар дэмжлэг хэрэгтэй байна гэдгийг зөв талаас нь гярхай харах ёстой. Жижигхэн дэм өгөхөд явчих гээд байгаа үйлдвэрүүд ч байна.

-Аж үйлдвэрийн яамтай болсноор асуудал өөрчлөгдөх хандлага байна уу.

- Хэт жижигрүүлдэг нь буруу юм байна, том байж үйлдвэрлэл жижгүүдээ чирэх ёстой юм байна гэдгийг яам маань ойлгосон. Тэр ч чиглэлээр бодлогоо гаргаж байгаа бололтой юм. Энэ бол яг зөв өнцгөөс харж байна. Салбарын яамтай болсноор аж үйлдвэрлэл хөгжихэд шаардлагатай зорилт стратеги, бодлогоор хангаж чадна гэж бодож байгаа. Үйлдвэрлэлийг импортыг орлох, экспортод тулгуурлан хөгжүүлэх нь маш чухал байна. Гэхдээ тухайн салбартаа хүчин чадал өндөртэй шинэ технологи, иновацид суурилсан салбарынхаа бодлогыг тодорхойлж чадахуйц тодорхой тооны томоохон үйлдвэрүүдийг бодлогоор гаргаж ирж хөгжүүлэх нь чухал байна. Тэгвэл тэд бусад жижиг үйлдвэрүүдээ кластераар хөгжүүлэн авч явах боломжтой болно.

-Арьс ширний салбарт Чингис бондоос 140 тэрбум төгрөгийн зээл олгохоор хуваарилсан байсан. Танайх тэр зээлд хамрагдсан уу?

- Төр, засгаас арьс, ширийг дотооддоо гүн боловсруулах болон түүгээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндэсний үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгохоор болсон нь манай арьс шир боловсруулах болон бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд маш том дэмжлэг болж байгаа. Манай салбарын олон үйлдвэр уг хөнгөлөлттэй зээлд хамрагдан техник технологио шинэчлэх, үйлдвэрлэлээ өргөтгөх, бүтээгдэхүүний үйлдвэрлэлээ нэмэгдүүлэхэд анхаарч байна. Манай

компани одоогийн байдлаар зээлд хамрагдаагүй байна.

-Олон улсын үзэсгэлэнд хэр оролцдог вэ?

Өнөөдөр арьс ширний эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл том байхыг зах зээл шаардаж байна.Бид нар зүгээр гараа хумихаад суудаггүй, олон улсын үзэсгэлэнд хэр чадлаараа оролцохыг хичээдэг. Одоо манайх энэ сарын 14-нд Германы "Berlin Bazaar" үзэсгэлэнд оролцохоор явах гэж байна. Мөн Итали, БНСУ, АНУ-ын үзэсгэлэнд оролцоно. Ингээд яваад байна гэдэг зах зээл хайгаад л арьс ширэн бэлэн бүтээгдэхүүнээ экспортод гаргах бэлтгэлээ л хийж байгаа гэсэн үг. Манай үйлдвэрт Голландын цүнхний "Bulaggi" брэндийг эзэмшигч захирал Wim Walraven өнгөрсөн жил ирж сарын хугацаатай зөвлөгөө өгч, сургалт хийсэн. Тэрбээр Монголын арьс ширэн бэлэн бүтээгдэхүүн дэлхийн зах зээлд брэнд болон гарах бүрэн боломжтой, тэр цаг хугацаа ч ойрхон байна гэж тодорхойлсон. Мөн гадагшаа явахаар бидний хүчин чадлаас давсан захиалга олддог. Тийм болохоор л том зээл авч, том хөдлөхийг хүсээд байгаа хэрэг. Энд хэн нэгэн нь энэ том зээлээр яах гэж байгаа гээд гайхаад байх юм ер байхгүй.

- Манайхан арьсан бүтээгдэхүүн чанартай гэдэгт итгэдэг. Өргөн хэрэглээ болж чадахгүй байгаа нь монгол хүн хийсэн гэхээр л чанаргүй болчих юм шиг ойлголт байдаг юм болов уу. Та үүнийг юу гэж боддог вэ?

-Зүгээр манайхны цамаанзан.Хя тадынбараагчанартайгээдавчхэрэгл ээдбайгааюмуу.Үгүйш дээ. "Харсан хүн авбаа. Авсан хүн хаяваа" гэсэн үг байдаг биздээ.Тэрийг голохгүй эдэлж хэрэглээд байж, яахаараа монгол хүний хийсэн юмыг голох ёстой юм. Монгол улсаа өөд нь гаргая, үйлдвэрлэл хөгжүүлэе гэж бодож байгаа бол дотооддоо хийсэн бүтээгдэхүүнийг голох эрхгүй гэж би боддог. Чанартай болгохын тулд харин эдэлж хэрэглэж үзээд, санал сэтгэгдлээ хэлж, алдаа байвал засаж, тухайн үйлдвэр нь хэрэглэгчдийн зүгээс ирсэн санал гомдлыг нь тусгаж авдаг байх ёстой. Тэгж байж л

үйлдвэрлэл хөгжинө.

-Монгол малын арьс шир дэлхийн брэнд гаргахад шаардлага хангахаар байгаа юу?

-Бид одооноос эхлэн үйлдвэрлэл технологийн шаардлага хангасан түүхий эд бэлтгэхийн тулд малаа эрүүлжүүлэх, цаг хугацаанд нь тарилга туулга, угаалгад хамруулах, сумдад мал нядалгааны орчин үеийн цех бий болгох, малчдаас эхлээд арьс шир, түүхий эд бэлтгэгч нар дор бүрнээ хариуцлагатай ажиллах хэрэгтэй. Эрүүл, чанартай арьс шир бэлтгэж, боловсруулах үйлдвэрт нийлүүлэх, боловсруулах үйлдвэр нь техник технологио сайжруулан чанартай химийн материал ашиглан бүтээгдэхүүнээ олон улсын стандартад нийцүүлэн боловсруулсан цагт манай бүтээгдэхүүн дэлхийн брэнд болох шаардлагыг хангана.

Одоогийн байдлаар манай арьсны талбайн ашиглалт маш бага. Гэтэл импортын арьсыг 80-90 хувьтай ашигладаг. Дотоодын арьсны ашиглалтын талбай гэмтэл, хээл гээд янз бүрийн юмнаас болоод 50 хувь ч хүрдэггүй. Цүнх дээд зэргийн маш сайхан арьстай байж гоё болдог. Энэ салбараас ДНБ-ий тодорхой хувийг үйлдвэрлэхийн тулд шат шатандаа тэгээсээ эхлээд технологийн дагуу явах ёстой. Бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид нь дэлхийн зах зээлд гарах бэлтгэлээ хийж загвар дизайн, үйлдвэрлэлийн технологио сайжруулаад, брэнд гаргах бүтээгдэхүүнийхээ туршилтыг хийгээд, загваруудаа гаргаад, олон улсын үзэсгэлэнд оролцон, захиалагчаа бэлдэхэд хугацаа орно. Тиймээс бид энэ хугацааг маш зөв ашиглах хэрэгтэй байна.

-Таны ярианд бид гадагшаа гарахын тулд нэгдэж цул болох ёстой гэж дурьдлаа. Тэр их чухал байх шүү.


-Экспортын чиг баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэл манай улсад тийм ч хангалттай төвшинд хөгжиж чадаагүй байна. Бид бүтээгдэхүүнээ их хэмжээгээр экспортолж брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг хүсэж байгаа бол жижиг үйлдвэрүүд маань нэгдэн багц болж гадаад зах зээл юу сонирхож байна, юу эрэлт ихтэй байна гэдэгт тулгуурлан үйлдвэрлэлээ өргөжүүлээд явбал экспортыг маш олон төрлөөр нэмэгдүүлэх боломжтой.

Ингэхийн тулд өрхийн жижиг дунд үйлдвэрлэлээ нэгтгэн томоохон аж үйлдвэрүүдийг бий болгож том зорилготойгоор салбараа хөгжүүлэх хэрэгтэй байна.■

Project Organizer:



Project Partners:



Project Facilitators:



ARAM

Annual Reporting Award of Mongolia

ШИЛДЭГ ЖИЛИЙН ТАЙЛАН ШАЛГАРУУЛАХ ҮНДЭСНИЙ УРАЛДААН

Бүртгэл 2015 оны 11 сарын 30-ныг хүртэл.

Дэлгэрэнгүй мэдээлэл авах эсвэл бүртгүүлэхийг хүсвэл www.cgdc.org.mn

сайтруу хандах болон 7000 8084/99105111 утсаар холбогдоно уу.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ



CAREC хөтөлбөр дэд бүтцийг чухалчилж байна

Г.Орхон

Төв Азийн бүс нутгийн орнуудын хамтын ажиллагааг дэд бүтцийн асуудал хойш нь татаж буйг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Бямбасайхан энэ жилийн CAREC-ийн хөрөнгө оруулалтын чуулганы нээлтийн үеэр онцолсон. Уг бүс нутагт Монгол, Казахстан тэргүүтэй уул уурхайд суурилсан эдийн засагтай орон хэд хэд бий бөгөөд тус салбараа хөгжүүлэхэд дэд бүтцээ сайжруулах нь тэргүүний асуудал болоод байгаа аж.

Тиймээс уг асуудлыг бүс нутгийн хэмжээнд авч үзэж Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөр CAREC-ийн хүрээнд улс орнууд нэгдэн шийдвэрлэх гэнэ. Нэг үгээр, эдгээр орны эдийн засгийн хөгжил хийгээд хамтын ажиллагааг сайжруулах гарц нь сайн дэд бүтэц.

Одоогийн байдлаар хөтөлбөрийн хүрээнд тус бүс нутагт 28 тэрбум ам.долларын дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг хийх шаардлагатай байгаа аж. Цаашид дэд бүтцийн олон ажил хийгдэхээр байгаа тул ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт тэр дундаа хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт чухал байгааг чуулганы үеэр онцолж байв. Дэд бүтцийн салбарт тухайн орнуудын хөрөнгө оруулалтаас давсан их хэмжээний хөрөнгө шаардагдах тул хувийн хэвшлийнхнийг татан оролцуулах нь чухал гэж тэд үзэж байна.

CAREC-ийн Хөрөнгө оруулалтын чуулган энэ жил Монгол Улсад болсон бөгөөд энэ үеэр тус хөтөлбөрийн гишүүн орнуудын төлөөлөгчид гадаад, дотоодын хөрөнгө оруулагчидтай уулзаж уг бүс нутагт хөрөнгө оруулах ямар боломж буй, улс орнууд үр өгөөжтэй хөрөнгө оруулалтыг хэрхэн татсан туршлагаасаа хуваалцсан юм. Энэ хөтөлбөр нь ЕвроАзийн газар нутагт хөгжил, худалдаа, арилжаа наймааг дэмжих зорилгоор хамтран ажиллах 10 улсыг нэгтгэсэн түншлэл юм. Улс орнууд дор бүрнээ эдийн засаг болон дэд бүтцийн томоохон төслүүдэд улсын төсвөөсөө хөрөнгө оруулалт хийж болох ч тус бүрдээ бус нэгдэж ажиллаад үйл ажиллагаагаа уялдуулаад хөдөлвөл зардал илүү хэмнэх боломжтой юм байна. Хөтөлбөрийн хүрээнд гишүүн орнууд хоорондоо жил бүр уулзаж, ярилцдаг уламжлалтай бөгөөд хөтөлбөрийг даргалах орныг ээлжээр сэлбэдэг аж. Энэ жил Монгол Улс даргалж байгаа бөгөөд энэ хүрээнд Азийн хөгжлийн банк, “Эрдэнэс Монгол” ХХК, Монголын Бизнесийн зөвлөл хамтран CAREC хөрөнгө

оруулалтын форум болон сайд нарын хурлыг эх орондоо зохион байгуулсан нь энэ. Чуулганд 26 орны 300 гаруй төлөөлөгч оролцсныг энд тэмдэглэе.

Азийн хөгжлийн банкны Зүүн бүс нутгийн газрын захирал Аюуми Кониши “Дэд бүтэц, зам зэрэг нь дангаараа байвал үр өгөөжгүй. Тэр зам дээгүүр хүмүүс, машин тэрэг явж, бараа зөөх учиртай. Барааг хэн зөөх, ямар бизнес байхыг голдуу хувийн хэвшил шийддэг учир энэ хөрөнгө оруулалтын чуулганыг хийж байгаа юм. Энэ чуулганд бид аль болох хөрөнгө оруулах сонирхолтой бизнесийнхэнийг олноор нь урьсан. Тэд хөтөлбөрийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авснаар энэ бүс нутгийн дэд бүтцийн хамтын ажиллагааг идэвхжүүлж, бизнесийн амин сүнснийг нь бий болгох тал дээр идэвхтэй оролцоно гэж найдаж байна” гэсэн. Хятад улс төдийгүй Япон болон өмнөд Солонгос дэд бүтцийг сайжруулах замаар Европ болон Азийг холбох санаачлагыг хэд хэдэн удаа гаргаж байгаа аж. Энэ бүх санаачлагыг CAREC хөтөлбөрийн зүгээс дэмжиж байгаа гэсэн.

Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг “Монгол Улс энэ хөтөлбөрийг эхнээс нь идэвхтэй дэмжин оролцож ирсэн. Азийн хөгжлийн банк сүүлийн 25 жилийн хугацаанд манай улсын хөгжлийн гол түнш байж, олон төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хамтарч ажиллаж ирсэн. Цаашид хамтын ажиллагаагаа улс өргөжүүлэх, тус хөтөлбөрийн гишүүн орнууд, хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллах сонирхолтой байна” хэмээсэн.

CAREC хөтөлбөрийн ирэх 10 жилийн стратегит далайд гарцгүй орнуудыг хуурай газарт гарцтай эдийн засаг болгох зорилгыг дэвшүүлжээ. Энэ нь Монгол Улсын хувьд бүс нутгийн орнуудтай хамтран эдийн засгаа сэргээх боломж гэдгийг албаныхан онцолж байна. CAREC гишүүн орнууддаа НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөр, Олон улсын валютын сан, Европын сэргээн босголт хөгжлийн банк, Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагуудаар дамжуулан санхүүжилт олгодог аж. Уг хөтөлбөрийн хүрээнд зөвхөн энэ удаа дэд бүтцийн асуудлыг хөндөж буй биш бөгөөд ер нь гишүүн орнуудынхаа эдийн засгийн хамтын ажиллагааг сайжруулах хүрээнд зам тээвэр, эрчим хүч, тээвэр, худалдааны салбарт онцгойлон анхаарлаа хандуулсаар иржээ. ■



Хуурамч найзууд

ХӨРШ

Б.Үүрийнтуяа

Хятадын Гадаад хэргийн яамны төлөөлөл Өнгөрсөн есдүгээр сарын сүүлээр Нью-Йорк дахь НҮБ-ын төв байранд Украин улсын Гадаад хэргийн сайд Павло Климлинтэй хаалттай уулзалт хийж, түүнд нэгэн таатай мэдээ дуулгав. НҮБ-ын Аюулгүй байдлын зөвлөлд суудалтай болох Украины саналыг Бээжин дэмжих болсноо дуулгасан нь энэ байв. Барууны орнуудтай геополитикийн төдийгүй үзэл санааны зөрчилтэй болсон ОХУ-ын НҮБ дахь байр суурь ганхаж эхлэхэд Хятад оросуудад дэмжлэг үзүүлж байсан билээ. Харин энэ удаагийн Украинтай холбоотой асуудал хоёр хөршийн дипломат харилцаанд сэв суулгасан явдал болов. “Foreign Policy” цахим хуудаст нийтэлснээр Хятад Оросын НҮБ дахь хамгийн ойрын төдийгүй үнэ цэнэтэй түнш хэдий ч Хятад улс өөрийн ашиг сонирхлыг илүүд үзэн хоёр улсын харилцаагаа золиосонд гаргахад бэлэн буйгаа илэрхийлсэн дохиог удаа дараа илэрхийлж байна гэжээ.

Хоёр хөрш стратегийн түншүүд. Түүнчлэн АНУ-ын сүр хүчид хазаар болох зорилготой хэмээгдэж буй эдгээр улс НҮБ-д эрх тэгш байдалтай оролцох хүсэлтэй гэдэг.

Харамсалтай нь дээрх түншлэл удаан үргэлжилбэл Хятадын худалдааны түншийн харилцаанд сөргөөр нөлөөлөх зэрэг таагүй үр дүн дагуулж эхэлжээ. Хэдий тийм ч ОХУ Кремийг эзэлснээс хойш Хятад, Украин хоорондын худалдаа чамгүй өргөжсөн байна. Тухайлбал, Хятад тус улсын эрдэнэ шишийн хамгийн том импортлогч орон болсныг “Financial Times” мэдээлжээ. НҮБ-ын Ерөнхий ассемблейн гишүүн 193 орны 177 орны дэмжлэг авч, саналаа баталгаажуулсан Украин Аюулгүй байдлыг зөвлөлд хориг тавих эрх эдлэхгүй юм.

Хойд Солонгос, Ираны асуудлаар хоёр хөрш нэгдсэн байр суурь илэрхийлдэг ч нэгдмэл байдал өдөр ирэх тусам суларч байгааг Өмнөд Судан, Украин, Сири улстай

холбоотой тодорхой асуудлуудад санал зөрчилдөж байгаагаас харж болох ажээ. НҮБ-ын Аюулгүй байдлын зөвлөлийн нэгэн дипломат хэлэхдээ “ОХУ-ын Крем дэх үйл ажиллагаа болон Иранд цэргийн дэмжлэг үзүүлсээр байгаа нь Хятадын ашиг сонирхолд нийцэхгүй байгаа юм. Энэ хоёр гүрний дунд зөрчил үүсэж буй нь илт. Орос, Хятад нэгнээсээ холдсоор байна” гэжээ.

Түүний хэлснээр хоёр улсын харилцаа ийн хөрч байгаа нь аажмаар өрнөж буй процесс аж. ОХУ-ын Ерөнхийлөгчийн явуулж буй улс төрийн бодлогыг хязгаарлахын тулд барууны орнууд Хятадыг тус улсаас зайгаа барь хэмээн ятгаж байгаа. Учир нь хоёр хөршийн харилцааг царцаах хүсэлдээ хүрвэл АНУ тэргүүтэй орнууд Оросын Украин, Сирид явуулж буй үйл ажиллагаанд улс төрийн дарамт үзүүлэх боломжтой гэж үзэж байгаа аж. Дээрх хоёр орны “дотно” харилцаа АНУ олон улсын хэмжээнд яригдах чухал асуудлуудад тодорхой хэмжээний

давуу эрхтэй оролцох нөхцлийг хааж ирсэн байдаг. Тодруулбал, Ассадыг эрх мэдлээс буулгах, Сирид дайны гэмт хэргийн мөрдөн байцаалт явуулах зэрэгт Хятад, Оросын зүгээс хориг тавих дөрвөн удаагийн санал оруулсан байдаг. Мөн Хойд Солонгост хүний эрх зөрчигдөж байгаатай холбоотой асуудлыг олон улсын хэмжээнд хөндөхөд Орос Хятадын талд зогсож байлаа.

Үүгээр ч зогсохгүй хоёр хөрш НҮБ-ын Ираны эсрэг хориг арга хэмжээг няцаасаар ирсэн төдийгүй хүний эрхийг зөрчиж буй орнуудтай тэмцэх Аюулгүй байдлын зөвлөлийн хэд хэдэн удаагийн үйл ажиллагаанд сөрөг байр суурь илэрхийлж байсан билээ. Түүнчлэн сүүлийн жилд зохион байгуулагдсан НҮБ-ын харъяа хэд хэдэн хурал, чуулганд, тухайлбал, Литвад болсон Хүний эрхийн чуулган болон Украин дахь хэвлэлийн эрх чөлөөний чуулга уулзалтад Орос, Хятадаас төлөөлөл оролцоогүй байдаг.

Хэдий ийм ч ОХУ, БНХАУ-ын “найзын” харилцаанд цав үүссэнийг батлах баримт байх аж. Өнгөрсөн сард ОХУ Сирид агаарын цохилт өгөхөд Хятадын зүгээс үүнийг тийм ч таатай хүлээж аваагүй. Мөн энэ сарын эхээр Хятад барууны орнуудын хамтаар Өмнөд Суданы зэвсэгт бүлгүүдийн эсрэг хориг арга хэмжээ авах асуудалд нэгдэж буйгаа мэдэгдсэн бөгөөд дайны гэмт хэргийн шүүх байгуулахыг дэмжсэн байна. Харин Орос үүнд эсрэг байр суурьтай хандаж, хориг арга хэмжээ байдлыг улам хурцатгана гэжээ.

Үүнээс үзэхэд Орос, Хятад олон асуудалд нэгдэж байсан ч ингэх зорилго нь өөр байсан аж. Европ Аюулгүй байдлын зөвлөлийг Газар дундын тэнгист хүч ашиглахтай холбоотой хуулийн төслийг хүлээн зөвшөөрүүлэх оролдлого хийж байхад дээрх хоёр улс үүнийг эсэргүүцэж байв. Харин тэдний эсэргүүцлийн зорилго өөр байсан юм.

Орос хууль хэрэгжиж эхлэвэл тус бүс дэх барууны орнуудын нөлөөлөл нэмэгдэнэ гэж үзсэн бол Хятад тус улсын худалдаанд сөргөөр нөлөөлж, барууны орнууд Хятадын усан онгоцуудтай холбоотой асуудалд

давуу эрхтэйгээр шийдвэр гаргах боломж бүрдэнэ хэмээжээ. “Хятад, Орос нэгнээсээ зайгаа барих болсныг харуулах удаа дараагийн үйлдлүүд гарсан” хэмээн Европын Гадаад хэргийн зөвлөлийн бодлого хариуцсан

“Тэд “Бид барууны эсрэг” гэдэг тоглоом тоглож байна. Оросын эдийн засаг хүнд байгаа бол Хятад барууныхнаас тусгаарлагдахгүй байхыг эрмэлзэлж буй.”

ахлах Ричард Гован хэлжээ. Түүний онцолж буйгаар хоёр улс тодорхой асуудлуудаас үүдэн ийн зайгаа барьж байгаа эсвэл стратегийн томоохон өөрчлөлтийн нэг хэлбэр үү гэдгийг таах аргагүй байгаа аж. Гэвч тэд тийм ч хурдан бас хялбархан харилцаагаа хөсөр хаяхгүй хэмээн тэрбээр нэгэн ярилцлагадаа дурьдсан байна. Учир нь тэдэнд барууны эсрэг хамтдаа зогсох цөөнгүй асуудал бий. ОХУ-ын хувьд эдийн засгийн хориг арга хэмжээнд чөдөрлүүлээд байгаа энэ үед Хятадтай найрсаг харилцаатай байж, дипломат харилцаагаа дараагийн шатанд гаргах нь чухал болоод буй. Энэ ч үүднээс ОХУ-ын Ерөнхийлөгч Хятадын удирдагчийг нэлээд арга хэмжээнд, жишээлбэл Дэлхийн II дайны ялалтын баяртаа урин оролцуулсан. Барууны орнуудын томоохон лидерүүд Оросын урилгаас татгалзсан байдаг.

Хятад улстай харилцаа, холбоогоо улам бэхжүүлэх гэсэн Оросын оролдлого үүгээр дуусаагүй. 2013 онд тэд хоёр улсын усан цэргийн түүхэн харилцаан дахь хамгийн том арга хэмжээг Японы далайд зохион байгуулсан бол өнгөрсөн тавдугаар сард хоёр улс Газар дундын тэнгист усан цэргийн хамтарсан сургуулилт хийжээ. “Үүнээс харахад хоёр улс ийн нэгнийхээ хүчтэй дэмжигч бас

түнш болж байгаа нь тэдэнд итгэлцэл төрүүлж байгаа юм” хэмээн ОХУ-ын НҮБ дахь Элчин сайд Виталий Чуркины онцолсныг “Newsweek” хэвлэлд нийтэлжээ. Тэрбээр “Бид Хятадтай стратегийн түншлэлийн харилцаатай. Аюулгүй байдлын зөвлөлийн хувьд ч тэр.

Бид санал өгөхдөө аль болох нэгдсэн байр сууриас хандахыг эрмэлздэг ч арга барилын хувьд үргэлж адил байдаггүй. Гэхдээ бид хичээдэг” гэсэн байна. Үзэл санааны нийцэл гэхээсээ илүүтэй давуу байлын зохицолын харилцаатай гэж болох дээрх хоёр улсын цаашдын нөхөрлөл дардан замнахгүй гэдгийг олон улсын улс төрийнхөн хэлдэг. Хэдийгээр тэд хүний эрх зэрэгтэй холбоотой асуудалд зөвлөлийн эсрэг нэгдэж чаддаг ч ашиг сонирхлын хувьд өмнөд, хойд туйл мэт “авирлах” нь бий.

Засгийн газрын хараат бус байдлыг хангах, хүндрэл бэрхшээлийн ширээний ард дипломат аргаар шийдвэрлэнэ гэх урианаас илүү тодорхой зүйл эс өгүүлэх Хятадын эрх баригчид Оросыг даган баясах хүүхэд мэт харагддаг талаар “Foreign Policy” бичжээ.

Гэвч зорилгодоо хүрэхийн тулд хэнээс ч үл айх, шаардлагатай бол хүч хэрэглэхэд ч бэлэн ОХУ бодит байдал дээр Хятадын ард нуугдах хоёр дахь тоглогч гэж “Foreign Policy” тайлбарласан байна. Хэдийгээр хөршүүдийн нөхөрлөл хуурамч мэт харагдаж болох ч барууны орнууд тэднийг барууны эрх баригчдын эсрэг нэгдсэн сайн “найзууд” хэмээн төсөөлж буй аж.

Гэвч төсөөлөл тийм ч хялбар буухгүй гэдгийг Брукингс институтийн АНУ, Европын төвийн Хятадын Гадаад бодлого судлаач Филип Лэ Корре дүгнэжээ. Путинд түших тулгуур, туслах найз хэрэгтэй байсан бол Хятад түүний зүтгэлд тийм ч идэвхтэй хандаагүй гэдгийг тэрбээр дурьдаж. Филип Ле Корре “Тэд “Бид барууны эсрэг” гэдэг тоглоом тоглож байна. Гэхдээ тэдэнд санал нэгдэхгүй маш олон зүйл бий. Оросын эдийн засаг хүнд байгаа бол Хятад барууныхнаас тусгаарлагдахгүй байхыг эрмэлзэлж буй. Учир нь Хятад дэлхийн тоглогч болохыг хүсэж байгаа юм” гэжээ. ■

ДЭЛХИЙН БАНКНЫ 2015 ОНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН



Зүүн Ази, Номхон далайн орнууд

Орчуулсан Б.Туяа

Дэлхийн эдийн засгийн өнгөрсөн жилийн өсөлтийн гуравны нэгийг Зүүн Ази болон Номхон далайн орнууд бүрдүүлсэн нь бусад хөгжингүй бүс нутгийн дэлхийн эдийн засагт оруулсан хувь нэмрээс даруй хоёр дахин их үзүүлэлт юм. Хэдий хөгжингүй эдийн засгууд сэргэж, газрын тосны үнэ буурсаар буй ч бүсийн хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлт ялимгүй саарсан билээ. Зүүн Ази, Номхон далайн бүсийн хөгжиж буй эдийн засгийн ирэх хоёр жилд дунджаар 6.7 хувийн өсөлт үзүүлэхээр байгаа ч энэхүү таамаг 2014 оны 6.9 хувийн өсөлтөөс уруудсан хүлээлт юм. Ийн ухарсан таамаг дэвшүүлж буйн гол учиг Хятад улсын эдийн засгийн өсөлт 2015, 2016 онд долоон хувьд хүрч буурна гэсэнтэй холбоотой аж. Өнгөрсөн онд тус улсын өсөлт 7.4 хувь байжээ. Тэгвэл бүсийн хөгжиж буй бусад орнуудын өсөлтийн эрч ирэх онд 4.9 хувь, удаах онд 5.4 хувь байх бол үүний дийлэнхийг Зүүн өмнөд Азийн орнууд бүрдүүлнэ хэмээн таамаглаж буй.

Ядуурлын түвшин Зүүн Ази, Номхон далайн бүсийн орнуудад эрчимтэй саарч байгаа. 2002 оны байдлаар өдрийн 1.25 ам.долларын амьжиргааны түвшинтэй буюу нэн ядуу хүмүүсийн тоо бүсийн хүн амын 26.5 хувийг эзэлж байсан бол өдгөө 5.1 хувь хүртэл буурсан байна. Энэ нь 100 орчим сая хүн нэн ядуу амьдарч байна гэсэн үг. Тэгвэл 1.25-2 ам.долларын өдрийн орлоготой, нэн ядуу ангилал руу “гулсах” эрсдэлтэй 260 сая хүн байна гэсэн тоо гарчээ.

ДЭЛХИЙН БАНК БА ТУСЛАМЖ

Дэлхийн банк энэ төсвийн жилд дээрх бүс нутагт хэрэгжих 57 төсөлд 6.3 тэрбум ам.долларын санхүүжилт төсөвлөсөн. Улмаар IBRD (Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк) 4.5 тэрбум ам.долларын зээл, тусламж үзүүлэх бол IDA (Олон улсын хөгжлийн холбоо)-аар дамжуулан 1.8 тэрбум ам.доллар олгохоор болсон. Ийнхүү Ус, Эрүүл ахуй, Хүнсний аюулгүй байдал (1.2 тэрбум ам.доллар), Нийгмийн удирдлага, Хууль, Шүүх засаглал (1.2 тэрбум ам.доллар), Тээврийн (1.2 тэрбум ам.доллар) гэсэн тэргүүлэх салбаруудад зонхилон анхаарах аж. Түүнчлэн бүсийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, мөн ажлын байр, хувийн хэвшилд суурилсан өсөлт бий болгох, засаглал болон институци, дэд бүтэц ба хотжилт, цаг уурын өөрчлөлт болон эрсдэлийн менежмент гэсэн таван чухал хэсэгт чиглэсэн стратегийг дээрх бүс нутагт хэрэгжүүлэх юм байна. Эдгээрийн хүрээнд жендерийн асуудал, мөргөлдөөн ба өртөмтгий байдал, ядуурлын дүн шинжилгээ гэсэн сэдвүүдэд мөн анхаарлаа хандуулан ажиллах юм.

Зүүн Ази, Номхон далайн орнуудад хотжилт эрчимтэй өсөж, улмаар дэд бүтцийн асуудал хурцаар тавигдах болсон. Тодруулбал, 142 сая хүн цахилгаан эрчим хүчгүй амьдарч буй бол 600 сая хүн цэвэр усны хангамжид холбогдоогүй байна. Түүнчлэн хот, суурин газар руу шилжилт хөдөлгөөн эрс нэмэгдэж байгаа нь үйлчилгээний салбарын хүртээмж, бүтээмж сулрах гол нөхцлүүдийн нэг болж байна. Үүгээр ч зогсохгүй хотын захар ядуусын хороолол

ДЭЛХИЙН БАНКНЫ ЗЭЭЛД ХАМРАГДАХ БОЛОМЖТОЙ ОРНУУД

- Камбож,
- Хятад,
- Фижи,
- Индонез,
- Кирибати,
- Өмнөд Солонгос,
- Лаус,
- Малайз,
- Микронезийн холбоот улс,
- Монгол,
- Мьянмар,
- Палау,
- Папуа
- Шинэ Гвений,
- Филиппин,
- Самао,
- Соломоны арлууд,
- Тайланд,
- Тимор Листэ,
- Тонга,
- Тувалу,
- Вануату,
- Вьетнам

(2015 оны зургаадугаар сарын 30-ны байдлаар)

олширч, хүрээлэн буй орчны бохирдол нэмэгдэх шалтгаан болж байгаа аж. Мөн цаг уурын өөрчлөлтөд өртөмтгий гэгдэх дэлхийн 30 орны 13 нь дээрх бүс нутагт хамаарах бол байгалийн гамшгийн 70 хувь нь эл хэсэгт тохиолдож байгааг онцлох хэрэгтэй.

ДЭЛХИЙН БАНК БА МЬЯНМАР

Дэлхийн банкны групп, Мьянмар улс хоорондын “Country Partnership Framework for 2015”-ийг хэрэгжүүлэхээр болсон. Энэ нь тус улсын хувьд 1984 оноос хойш үзэгдсэн анхны түншлэлийн хэлэлцээр юм. Энэ хүрээнд IDA 1.6 тэрбум ам.долларын зээлийг стратегийн гэгдэх концессийн гэрээ, тоног төхөөрөмжийн зээл тусламж зэрэгт зарцуулах бол IFC (Олон улсын санхүүгийн корпораци) нэг тэрбум хүртэлх ам.долларын хөрөнгө оруулалт хийхийн зэрэгцээ 20 сая ам.долларыг техник, тоног төхөөрөмжийн зээл тусламжид олгох аж. Түүнчлэн MIGA (Олон талт хөрөнгө оруулалтын баталгааны агентлаг) хувийн зээлдэгч болон хөрөнгө оруулагчдад улс төрийн эрсдэлийн даатгалын үйлчилгээ санал болгож буй.

Дэлхийн банкны групп Мьянмар улсын ядуурал, тэр дундаа орон нутгийн ядуурлын түвшинг бууруулахад түлхүү анхаарах юм. Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, дэмжигч байгууллагуудад хөрөнгө оруулснаар оршин суугчдыг дэмжих, хувийн хэвшилд ажлын байр шинээр бий болгох замаар ядууралтай тэмцэх аж.

НОМХОН ДАЛАЙН БҮСИЙН ӨРТӨМТГИЙ БАЙДАЛ БА ТҮҮНТЭЙ ТЭМЦЭХ НЬ

Бүсийн арлын орнуудын хувьд байгалийн гамшиг болоод эдийн засгийн эрсдэлд хэт өртөмтгий байдгаас улбаалан Дэлхийн банк сүүлийн жилүүдэд энэ чиглэлд оролцоогоо нэмэгдүүлсээр ирсэн. Байгалийн аюулт үзэгдэл, гамшигт хэт өртөмтгий байх, газар нутгийн хэмжээ жижиг, тусгаарлагдсан байдгаас үүдэн дээрх эрсдэлүүд улам нэмэгддэг. Тухайлбал, өнгөрсөн гуравдугаар сард Номхон далайн өмнөд хэсэгт болсон Пам хар шуурганы улмаас Вануату, Тувалу арлууд ихээхэн хэмжээний хохирол амссан. Вануатугийн гамшгийн дараах тусламжийн үйл ажиллагаанд оролцсон Дэлхийн банк хохирлын хэмжээг 447 сая ам.доллар хэмээн тогтоосон нь тус улсын ДНБ-ий 64 хувьтай дүйж байсан юм. Сэргээн босголтод шаардлагатай санхүүжилтэд нэмэр болох үүднээс IDA 59.5 сая ам.долларыг өнгөрсөн тавдугаар сард Вануатугийн Агаарын тээврийн хөрөнгө оруулалтын төслийн хүрээнд баталсан нь арлын олон улсын нисэх онгоцны буудлуудыг сэргээн засварлахад үнэтэй хувь оруулсан. Пам хар салхины уршигаар Тувалу улс ч мөн их хэмжээний хохирол амссан. Тус улсын дэд бүтэц, тэр дундаа далайн уснаас хамгаалах далангууд олноор эвдэрч сүйтсэн байдаг. “Crises Response Window” байгууллагаас олгосон гурван сая ам.долларын тусламж гамшгийн дараах сэргээн босголтын ажилд жинтэй нөлөө үзүүлсэн.

МЭДЛЭГТ СУУРИЛСАН ТҮНШЛЭЛ БА ШИЙДЭЛ

Дэлхийн банкны группын үйл ажиллагаанд мэдлэг стратегийн чухал үүрэг гүйцэтгэсээр ирсэн.

Вьетнамын Засгийн газар, Дэлхийн банктай хамтран 2015 оны төсвийн жилд 2035 он гэхэд Вьетнам улсыг орчин үеийн аж үйлдвэржсэн орон болгох урт хугацааны хөгжлийн стратеги боловсруулахад тус болох тайлан санаачлан гаргасан. Хятадын Засгийн газар, Дэлхийн банкны групп, Дэлхийн эрүүд мэндийн байгууллагатай хамтран Хятадын эрүүл мэндийн системийг ахин судлах санаачлага гарган ажиллаж байна. Ирэх онд олон нийтэд нээлттэй мэдээлэх тус судалгаагаар тус улсын эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, хүчин чадал хийгээд мөнгөний үр ашгийг нэмэгдүүлэх, хятад иргэдийн эрүүл мэндийг дээшлүүлэхэд чиглэсэн боломжуудыг эрэлхийлж буй.


Дэлхийн банкны групп Номхон далайн арлын орнуудын төлөөллүүдтэй нэгдэн тухайн бүс нутгийн урт хугацааны хөгжлийн боломж, тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх стратегийн судалгааг боловсруулж байна.

Малайзын Засгийн газар, Дэлхийн банктай албан ёсны зөвшилцөлд газрын үсэг зурснаар тус улсын Куала Лумпур хотноо салбар оффисоо нээхээр болсон. Ингэснээр бүсийн хөгжиж буй бусад орон Малайзын хөгжлийн туршлагаас суралцах боломж бүрдэх төдийгүй дэлхий дахинд мэдлэг түгээх өндөр ач холбогдолтой. Банкны групп Зүүн өмнөд Азийн орнуудын холбоо, Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага, Номхон далайн арлуудын чуулган, Азийн хөгжлийн банк, Австралийн Гадаад харилцаа, худалдааны тамгын газар, Японы Олон улсын хамтын ажиллагааны агентлаг болон бусад байгууллагатай хамтран хөгжлийн үр нөлөөг нэмэгдүүлэхээр түншлэн ажиллаж байна. ■

Зураг 1 Зүүн Ази ба Номхон далай

Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци зээл (салбараар)


Нийт 6.3 тэрбум ам.доллар



Зураг 2 Зүүн Ази ба Номхон далай

Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциацийн зээл (чиглэлээр)

Нийт 6.3 тэрбум ам.доллар



Эх сурвалж: Дэлхийн банк

ИЛТГЭЛ

Кристан Лагард: Би тодорхой байхыг хүсэж байна

Орчуулсан Б.Энхмөнх



ОУВС-гийн захирал Кристан Лагардын өнгөрсөн есдүгээр сард Вашингтон хотноо болсон Америкийн зөвлөлийн хурлын үеэр тавьсан илтгэлийг бүрэн эхээр нь сонирхуулж байна. Тэрбээр энэ илтгэлдээ дэлхийн эдийн засагт тулгамдаж буй асуудлууд болон тэдгээрийн гарц шийдлийн талаар хурц бөгөөд шийдэмгий хэлжээ.

Өглөөний мэнд, Элчин сайд Негропонтэд талархал илэрхийлэхийн сацуу өнөөдөр намайг энд урьсан Америкийн зөвлөлд талархаж байна.

Дараа долоо хоногт Лима хотод ОУВС-Дэлхийн банкны жилийн хурлыг зохион байгуулах гэж буйдаа таатай байна. Энэ нь сүүлийн 50 гаруй жилд Латин Америкт зохиогдож буй бидний анхны хурал юм. Өнгөрсөн 50 жилд Америкийн зөвлөл нь лидерүүдийг нэгэн дээвэр дор цуглуулж Латин Америкт тулгамдсан хамгийн том асуудлуудыг шийдвэрлэх, санаа бодлоо хуваалцах тавцан болж ирсэн билээ. Өнөөдөр та бүхний зорилго маш чухал. Учир нь энэ бүс нутаг төдийгүй дэлхий даяар маш том сорилттой тулгарч байна.

Би олон улсын хэмжээний асуудалд санаа зовниж байна. Европ руу дүрвэгсдийн хүн амын шилжилт хөдөлгөөн нь Хойд Африк болон Ойрхи Дорнодын улс төр болон эдийн засгийн хурцадмал байдлыг илэрхийлэл юм. Энэхүү дүрвэгсдийн хямрал хөгжсөн эдийн засагтай орнуудын хэвлэл мэдээллийн анхаарлыг илүүтэй татаж байгаа ч энэ нь зөвхөн тэдэнд хамаарах асуудал биш юм. Зөрчилдөөн тэмцэл дэлхийн бусад хэсэгт ч өрнөж байгаа бөгөөд дэлхий даяар ойролцоогоор 60 сая

хүн нүүн суурьшсан байна.

2015 он түүхэн дэх хамгийн халуун жил болох гэж буйг бид мартаж болохгүй. Мөн Номхон далайн бүс нутагт гай гамшиг үүсгэж буй маш хүчтэй Эл Ниньо байгалийн үзэгдлийг ч мартаж болохгүй.

Эдийн засгийн тал дээр санаа зовох асуудлууд байгаа. АНУ-ын бодлогын хүү болон БНХАУ-ын эдийн засгийн удаашрал нь тодорхой бус байдал мөн зах зээлийн тогтворгүй байдал үүсгэхэд нөлөөлж байна. Дэлхийн худалдааны өсөлт огцом буурсан байна. Мөн түүхий эдийн үнийн өгцөм уналт нөөцөд суурилсан эдийн засагтай орнуудад асуудал учруулж буй.

Зүрх зүсэм мөргөлдөөн болон албадан шилжих хөдөлгөөнөөс гадна эдийн засгийн эмх замбараагүй байдал, идэвхгүй үйл ажиллагаанаас болж хүмүүс хохирч байна. Өнөөдөр дэлхий даяар 200 гаруй сая хүн ажилгүй байна, орлого болон баялгийн тэгш бус байдал нэмэгдэж байна, эмэгтэйчүүдэд цалин болон зах зээлийн боломж аль аль нь дутмаг байна. Мэдээж хэрэг үүнээс долоон дор байх боломжтой байсан. Бид хэдхэн жилийн өмнө томоохон санхүүгийн хямралаас гарсныг мартаж болохгүй. Гэхдээ дэлхийн зарим улс уг

хямралын үед ч харьцангуй тогтвортой байсныг хэлэх хэрэгтэй. Жишээ нь сүүлийн 20 жилийн хугацаанд эдийн засаг болон нийгмийн өөрчлөлт хийж олон сая иргэдийнхээ амьдралыг сайжруулсан Латин Америкийн олон орныг хэлж болно. Африкт ч бодитой ахиц дэвшил гарсан. Мөн Азийн эдийн засгийн эзлэх жин сүүлийн жилүүдэд асар ихээр өссөн хэвээр байна.

Гэвч эдгээр ололт өнөөдөр аюултай нөхцөл байдалд хүрлээ, үүний улмаас төөрөгдөж санаа зовних нь ойлгомжтой. Би "Өнөөгийн эдийн засгийн хөгжил ердөө мөчлөг үү, эсвэл илүү бүтэцтэй тогтвортой зүйл үү?" гэж асуусаар ирсэн.

Үүнд ямар ч энгийн хариулт байхгүй. Мэдээж бид хүнд хэцүү, төвөгтэй үе шатанд байна. Миний өнөөдөр хэлэх гэсэн гол санаа бол зөв бодлого, хүчтэй манлайлал, олон улсын хамтын ажиллагаагаар энэ бүхнийг зохицуулж болно гэдэг юм.

1970-1980-аад оны газрын тосны хямрал, Бреттон Вудсын тогтолцооны төгсгөл, эсвэл хуучин ЗХУ-аас шинээр тусгаар тогтносон улс орнуудад тулгарч байсан асуудлууд зэрэг өнгөрсөн бэрхшээлүүдийг эргэн санацгаая.

Хүн амын төвлөрөл, уур амьсгалын өөрчлөлт болон байгаль орчны

доройтол илүү хурц түвшинд очсон бөгөөд өнөөгийн бидний амьдарч буй дэлхий мэдээж өмнөхөөс тэс өөр. Гэвч маш өндөр эрсдэл, тодорхой бус байдал өмнө нь ч байсан бөгөөд бодлого боловсруулагчид дэлхийн эдийн засгийг энгийн байх ёстой түвшинд нь буцаан аваачиж чадаж байсан. Үүнийг л тэд дахин хийх ёстой.

Бид хаана байна? Бид юу хийх ёстой? Бид хэрхэн энэ бүхнийг боломжтой болгох вэ?

1. БИД ХААНА БАЙНА ВЭ?

Юун түрүүнд дэлхийн эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлаас эхэлж, дараагаар нь зарим үндсэн шилжилтийн асуудалд анхаарлаа хандуулцгаая.

Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал

Манай байгууллагын дэлхийн эдийн засгийн төлөвийн талаарх тайлан ирэх долоо хоногт гарна. Гэхдээ би тайланг гарахаас өмнө нэг зүйлийг хэлж чадах байна. Дэлхийн эдийн засгийн өсөлт өмнө жилийнхээс харьцангуй сул байх магадлалтай бөгөөд 2016 онд өсөлт саармагжих хандлагатай байна. Сайн мэдээ нь гэвэл хөгжсөн эдийн засгууд удаан хэдий ч сэргэж эхэлж буй юм. Дунд зэргийн сэргэлт нь Европын бүсийг бэхжүүлж байна. Мөн АНУ болон Их Британид эдийн засгийн идэвх хүчтэй хэвээр. Сайнгүй мэдээ гэвэл хөгжиж буй эдийн засгуудын өсөлт тав дахь жилдээ дараалан буурах магадлалтай.

Энэтхэг улсын хэтийн төлөв өөдрөг хэвээр байна. Хятадын өсөлт саарч экспорт давамгайлсан өсөлтөөс шилжиж байна. ОХУ болон Бразил зэрэг улс орнууд эдийн засгийн ноцтой хүндрэл бэрхшээлтэй тулгарч байна. Латин Америкийн улс орнуудын өсөлт ерөнхийдөө огцом удааширч буй. Бага орлоготой орнуудын үйл ажиллагаа улам суларч байгаа бөгөөд муудсаар байгаа гадаад орчин ч үүнд нөлөөлсөөр.

Дэлхий нийтийн хэмжээнд авч үзвэл эдийн засагт учрах хүндрэлүүд байсаар. Учир нь санхүүгийн тогтвортой байдалд хараахан хүрээгүй байна. Сүүлийн жилүүдэд эерэг үр дүн гарч байгаа ч олон улс орны санхүүгийн салбарын сул талууд

хэвээр байгаа бөгөөд шинээр гарч ирж буй зах зээлүүдэд санхүүгийн эрсдэл улам нэмэгдсэн.

Энэ бүхнээс харахад дэлхий нийтийн өсөлт хангалтгүй, тэгш бус байна. Үүнээс гадна дунд хугацааны өсөлтийн төлөв улам суларлаа. Миний өнгөрсөн жил анхааруулж байсан «шинэ дундаж» буюу удаан хугацааны туршид үргэлжлэх сул өсөлттэй нүүр тулахад маш ойрхон боллоо. Яагаад тэр вэ? Яагаад гэвэл бага бүтээмж, хүн амын хөгшрөлт болон дэлхийн санхүүгийн хямралын үр дагварууд боломжит өсөлтөд саад болж байна. Өндөр өр зээл, бага хөрөнгө оруулалт болон сул дорой банкууд хөгжсөн эдийн засгуудад тэр дундаа Европт саад болсоор байгаа бөгөөд олон шинээр гарч ирж буй эдийн засгууд хямралын дараах зээл болон хөрөнгө оруулалтын зохицуулалт хийх шаардлагатай тулгарч байна.

Эдийн засгийн их шилжилт ба улс орнууд дахь бодлогын нөлөөлөл (spillover)

Цалгих нөлөөлөл буюу бидний нэрлэдэгээр spillover болон spillback-ийг (улс орнуудад нөлөөлөх бодлогын эерэг/сөрөг нөлөөлөл) үүсгэж буй зарим эдийн засгийн их шилжилт хэтийн төлөвт асар их нөлөөлж байна. БНХАУ-ын шинэ өсөлтийн загвар руу шилжилт болон АНУ мөнгөний бодлогоо хэвийн болгох гэсэн хоёр зүйлийг эндээс онцолж хэлжэе.

Энэхүү хоёр өөрчлөлт шилжилтийн аль аль нь шаардлагатай төдийгүй зөв юм. Энэ нь БНХАУ болон АНУ-д хоёуланд нь ашигтай, дэлхий нийтэд ч ашигтай. Харин хэрхэн үр ашигтай зохицуулах вэ гэдэг сорилт тулгарч байна.

Нэгд, үндсэн өөрчлөлт шилжилтийн дунд яваа БНХАУ-ын талаар ярья. Тус улс цалин болон амьжиргааны түвшинг нэмэгдүүлэхийн тулд томоохон бүтцийн шинэчлэлийг эхлүүлсэн байгаа. Энэхүү шинэчлэлт илүү удаан, аюулгүй бөгөөд тогтвортой өсөлттэй «шинэ дундаж»-д хүргэх зорилготой. Энэхүү шинэ загвар түүхий эд давамгайлсан хөрөнгө оруулалт гэхээс илүү хэрэглээнд илүү түшиглэж байгаа юм. Өөрөөр хэлбэл, үйлдвэрлэлээс илүүтэй үйлчилгээнд төвлөрнө гэсэн



Зүрх зүсэм мөргөлдөөн болон алба замбараагүй байдал, идэвх

үг. Үүний тулд тэд илүү зах зээлд суурилсан, тогтвортой санхүүгийн тогтолцоонд шилжэх шаардлагатай болж байгаа юм. Өөрөөр хэлбэл, Хятадын бодлого боловсруулагчид нарийн тэнцвэржүүлэх арга хэмжээг авах шаардлагатай тулгарч байна. Тэд энэхүү бэрхшээлтэй шинэчлэлийг хэрэгжүүлэхдээ эрэлт болон санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах хэрэгтэй юм. Миний хэлсэнчлэн, ийм төрлийн томоохон шилжилт худалдаа, валютын ханш, хөрөнгийн зах зээл болон мөнгөний урсгалаар дамжуулан эерэг болон сөрөг нөлөөлөл үүсгэж болзошгүй.

Бид сүүлийн саруудад зарим нөлөөллүүдийг харлаа. Хөрөнгө оруулагчид Хятадын эдийн засгийн саарч буй хурдад санаа зовниж байна. Энэхүү тайван бус байдал түүхий эдийн зах зээл дэх дарамтыг нэмэгдүүлж байгаа бөгөөд хэд хэдэн түүхий эдийн экспортлогч оронд валютын уналт үүсгэлээ.

Тэдгээр улс олон жилийн турш Хятадыг экспортын гол чиглэлээ болгон түшиглэж ирсэн. Тухайлбал,



Эдэн шилжих хөдөлгөөнөөс гадна эдийн засгийн эмх
эвхгүй үйл ажиллагаанаас болж хүмүүс хохирч байна.

БНХАУ дэлхийн төмрийн хүдрийн 60 хувийг хэрэглэдэг. Гэвч хөрөнгө оруулалтаа багасгахын хэрээр Хятад улс түүхий эдийн хэрэгцээгээ багасгах болно. Үүний улмаас түүхий эдийн үнэ удаан хугацаанд сул байх магадлалтай бөгөөд бодлого боловсруулагчид, тэр дундаа түүхийн эдийн томоохон экспортлогчид энэхүү өөрчлөлтийг зохицуулах шаардлага гарна.

Хоёр дахь томоохон шилжилт АНУ мөнгөний бодлогын хүүгээ нэмэх асуудал юм. Хэдийгээр АНУ-ын төв банк тодорхой хугацаанд мөнгөний бодлогоо доогуур байлгана гэж мэдэгдсэн ч тэд сүүлийн есөн жилийн турш нэмээгүй бодлогын хүүгээ нэмэх нь зайлшгүй. Энэхүү шилжилт АНУ-д илүү таатай эдийн засгийн нөхцөлийг бий болгох төдийгүй дэлхийн эдийн засагт ч ашигтай юм.

Бага хүүгийн түвшин нь хөрөнгө оруулагчдыг ашиг эрэлхийлэхэд хүргэж үүний үр дүнд санхүүгийн эрдсэл хүлээлтийг дэмжиж мөн үнэт цаас, засгийн газрын бонд болон аж ахуйн нэгжийн зээлийн үнэлэмжийг нэмэгдүүлэхэд ач тусаа өгсөн. Тиймээс

АНУ-ын төв банк хүүгийн хэмжээг нормалчлахын хажуугаар санхүүгийн зах зээлийн тасалдал гарах эрсдэлийг бууруулах нарийн тэнцвэржүүлэх үйл ажиллагааг хийх шаардлагатай тулгарч байна.

Дахин хэлэхэд “spillover” буюу эерэг/сөрөг нөлөөлөл гарч болзошгүй юм. АНУ-ын бодлогын хүү өснө гэдэг сургаар зарим зээлдэгчдийн хувьд тэр дундаа шинээр гарч ирж буй болон хөгжиж буй эдийн засгуудын хувьд санхүүжилтийн зардал илүү өндөр болсон.

Энэ нөхцөл байдалтай эвлэрч дасах нь дэлхийн эдийн засагт зайлшгүй асуудал юм. Гэвч энэхүү үйл явц тогтмол орлоготой зах зээлд бүтцийн өөрчлөлт хийхэд төвөгтэй байж болзошгүй. Учир нь тэдний хөрвөх чадвар суларч илүү хэврэг болсон бөгөөд энэ нь үймээн болон тасалдал үүсгэх нөхцөл юм.

Хөгжсөн эдийн засгуудыг эс тооцвол бусад улс илүү өндөр хүүгийн хэмжээнд өмнөхөөс илүү бэлтгэлтэй байдаг болсон байна. Хэдий тийм боловч миний бие тэдний гэнэтийн цочролд хэр бэлтгэлтэй байгаад санаа зовниж байна.

Яагаад гэж үү? Учир нь олон хөгжиж буй эдийн засгууд дэлхийн санхүүгийн хямралын үед санхүүгийн мөчлөг болон мөнгөний эсрэг арга хэмжээг зоригтойгоор авч байсан. Тэд хэрэгтэй үед энэхүү бодлогуудыг ашиглан дэлхийн эдийн засгийг манлайлж чадсан. Мөн сүүлийн таван жилийн хугацаанд тэд дэлхийн өсөлтийн бараг 80 хувийг эзэлсэн.

Ерөнхийдөө эдгээр бодлогын арга хэмжээнүүд нь хувийн хэвшлийн санхүүгийн хөшүүрэгтэй зэрэг нэмэгдсэн бөгөөд олон улс орнууд ам.долларын өрөнд унасан.

АНУ-ын бодлогын хүү нэмэгдэж, ам.доллар чангарахад валютын ханшийн тэнцвэргүй байдал үүсэж магадгүй бөгөөд үүний улмаас аж ахуйн нэгж, банк болон улсын хооронд хортой цикл үүсч аж ахуйн нэгжүүд өрөө төлөх боломжгүйд хүрэх бололцоотой. Хамгийн гол нь бүгд идэвхтэй бодлогын зохицуулалт хийх хэрэгтэй, ялангуяа шинээр гарч ирж буй хөгжиж буй эдийн засгууд.

2. БИД ЮУ ХИЙХ ЁСТОЙ ВЭ?

Хангалттай диагноз хийлээ. Юу хийх ёстой вэ? Энэ бол миний хоёр дахь асуулт.

Хэдийгээр шилжилтийн явц нь эрсдэл дагуулдаг сул талтай ч эрэлтийг дэмжиж, санхүүгийн тогтвортой байдлыг хадгалж, мөн бүтцийн шинэчлэлтийг хэрэгжүүлснээр энэ бүхнийг зохицуулж болохыг бид мэднэ.

Ихэнх эдийн засагчид энэ жорийг хүлээн зөвшөөрч надтай санал нийлэх байх. Гэхдээ өнөөдөр би маш тодорхой байхыг хүсч байна. Өмнө нь хэлсэнчлэн, бид яг одоо арга хэмжээ авах шаардлагатай бөгөөд бид бодлогын хүчин чармайлтаа эрчимжүүлэх хэрэгтэй байна. Миний бие бодлого боловсруулагчдыг өнөөгийн бэрхшээлүүдийг даван туулахын тулд бодлогын шинэчлэлт хийхийг уриалан дуудаж байна.

"Шинэчлэлт" гэдгээр би юуг хэлж байна вэ?

Эрэлтийн талаар ярихад, АНУ магадгүй Их Британиас бусад хөгжсөн эдийн засгуудад уян хатан мөнгөний бодлого шаардагдсаар байх болно. Гэхдээ бүх л хөгжсөн эдийн засгууд «spillover» буюу эерэг/сөрөг нөлөөллийн эрсдэлийг өөрсдийн шийдвэр гаргалтдаа бүрэн тусгах хэрэгтэй, мөн тэдний харилцаа энэ хүрээнд маш тодорхой байх ёстой. Энэ нь бодлогын шинэчлэлтийн маш чухал хэсэг юм.

Евро бүс 900-гаад тэрбум еврогийн чанаргүй зээлийг шийдвэрлэх замаар шинэчлэлт хийх боломжтой. Энэ нь санхүүгийн хямралын шийдэгдээгүй үлдсэн гол асуудлуудын нэг юм. Хуримтлагдсан чанаргүй зээлийг шийдсэнээр банкууд аж ахуйн нэгж болон өрхүүдэд өгөх зээлийн нийлүүлэлтээ нэмэгдүүлэх боломжтой болох юм. Энэ нь мөнгөний нийлүүлэлтийн чадавхийг түргэсгэж, төлөв байдлыг сайжруулж, мөн зах зээлд итгэх итгэлийг бэхжүүлэх болно.

Хөгжиж буй эдийн засгууд томоохон компаниудын гадаад валютын эрсдэлд тавих хяналтаа сайжруулах нь чухал. Тэд банкуудын уян хатан байдлыг хангахын тулд аж ахуйн нэгжийн гадаад өрийн асуудлыг макро-санхүүгийн хэрэгслүүдийг

ашиглан шийдвэрлэх хэрэгтэй. Энэ нь санхүүгийн тогтвортой байдалд тустай бөгөөд аж ахуйн нэгж, банк болон улсын хооронд үүсч болзошгүй хортой циклийн эрсдэлийг бууруулна.

Дэлхий нийтийн хувьд захиргааны шинэчлэлтийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, банк бус байгууллага болон сүүдрийн банкуудын ил тод байдал ба хяналтыг сайжруулахад онцгой анхаарч ажиллах шаардалгатай. Дэлхий даяар үйл ажиллагаатай системт санхүүгийн байгууллагуудын шийдвэрлэх тогтолцоо хангалтгүй байсаар байгаа бөгөөд энэ нь бидний өмнө байгаа бас нэг томоохон шинэчлэл юм.

Санхүүгийн хувьд улс орнууд аль болох уян хатан, өсөлтийг дэмжсэн



Эдийн засгийн тал дээр санаа зовох асуудлууд байгаа. АНУ-ын бодлогын хүү болон БНХАУ-ын эдийн засгийн удаашрал нь тодорхой бус байдал мөн зах зээлийн тогтворгүй байдал үүсгэхэд нөлөөлж байна.



бодлого баримтлах хэрэгтэй. ОУВС санхүүгийн дэмжлэг үзүүлэх боломжтой хөгжсөн эдийн засгуудыг төрийн хөрөнгө оруулалт тэр дундаа чанар бүхий дэд бүтцэд хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэхийг зөвлөсөөр байна. Найдвартай дунд хугацааны төсвийн төлөвлөгөө маш чухал хэвээр байгаа, ялангуяа АНУ болон Япон улсуудад.

Бодлогын өөрчлөлт хийх боломжтой түүхий эд экспортлогч орнууд өнөөгийн түүхий эдийн бага үнэд өөрсдийн бодлогыг тохируулахын тулд энэ аргыг мөн хэрэглэх хэрэгтэй. Бусад нь өсөлтийг дэмжсэн татварын шинэчлэлт, эрчим хүчний үнийн шинэчлэл зэрэг санхүүгийн тэнцвэржүүлэлтэд түшиглэх хэрэгтэй.

Колумб, Норвеги болон Боствана зэрэг түүхий эдийн экспортлогчид гэнэтийн цочролоос сэргийлэхийн

тулд түүхий эдийн оргил үеийг өөрсдийн төсөв, санхүүгийн бүтцийг бэхжүүлэхэд ашиглаж чадсан. Ингэснээр тэд шаардлагатай санхүүгийн зохицуулалтыг хийж, улмаар өсөлтийг хадгалах боломжтой нөхцөлд очсон. Үүнийг бусад орнууд харж суралцах хэрэгтэй.

Эцэст нь хэлэхэд бүх улс орнууд өөрсдийн эдийн засгийн бүтцээ хөдөлмөр болон бүтээгдэхүүний зах зээл, дэд бүтэц, боловсрол, эрүүл мэнд болон худалдааны салбартаа шинэчлэлт хийх замаар сайжруулах хэрэгтэй.

3. БИД ХЭРХЭН ЭНЭ БҮХНИЙГ БОЛОМЖТОЙ БОЛГОХ ВЭ?

Миний сүүлчийн бөгөөд хамгийн чухал асуулт бол «Хэрхэн энэ бүхнийг боломжтой болгох вэ?».

Ердөө л бодлогын зөвлөгөө өгөх нь мэдээж хэрэг амархан. Харин энэ бүхнийг хэрэгжүүлэхэд, ялангуяа өсөлт бага тодорхой бус байдал их байгаа үед чадварлаг бөгөөд ухаантай бодлого гаргах шаардлагатай. Үүнээс гадна бодлогууд зөвхөн үндэсний хэмжээнд хэрэгжих бус харин дэлхий нийтийн хандлагад хувь нэмрээ оруулж байх нь маш чухал. Уур амьсгалын өөрчлөлт, худалдаа, шилжилт хөдөлгөөн, мөн дэлхийн санхүүгийн аюулгүй байдлын сүлжээ зэрэг олон асуудалтай энэ үед олон улсын хамтын ажиллагаа урьд өмнөхөөс илүү чухал ач холбогдолтой болж байна.

Өнгөрсөн долоо хоногт Нью Йорк хотноо Тогтвортой хөгжлийн зорилтууд батлагдсанд би маш их баяртай байгаа. Энэ нь арванхоёрдугаар сард Парис хотноо болох Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх дээд хэмжээний уулзалтаар чухал гэрээ тохиролцоонд хүргэнэ гэж найдаж байна.

Ойрхи Дорнод болон Европын дүрвэгсдийн хямралыг жишээ болгон авч үзье. Энэ нь зөвхөн хүмүүнлэгийн асуудал төдий биш, энэ нь хүн бүрт нөлөөлдөг эдийн засгийн асуудал юм. Хүн бүр үүнд туслалцаа үзүүлэх үүрэгтэй. ОУВС ч өөрсдийн хувь нэмрээ оруулах болно. Бид энэ хямралын манай гишүүн орнуудад үзүүлж буй эдийн засгийн үр нөлөөг судалж байна. Тодорхой бодлогын зөвлөмж ч өгөх болно. Бид хөтөлбөрийнхөө

дэмжлэгээр санхүүгийн туслалцаа өгч байгаа бөгөөд Йордан, Ирак болон Тунис зэрэг улс хэдийнэ туслалцаа авсан байгаа.

Үндэсний болон дэлхийн хэмжээнд өсөлт болон эдийн засгийн тогтвортой байдлыг шийдвэрлэх эрхийнхээ дагуу бид өөрсдийн гол үйл ажиллагаа, хяналт ажиглалт, зээл олголт болон чадавхиа боловсронгуй болгосоор байна. Бид цаашид гишүүн орнууддаа шилжилтийн үед тулгарч болох асуудлуудад нь үзүүлэх дэмжлэгээ нэмэгдүүлэх тал дээр тохиргоо хийж байна.

Тохиргоо гэж би юуг хэлж байна вэ?

Бидний зорилго бол «AIM» гэх гурван хэмжүүрийн хүрээнд сайжрахыг зорьж буй. Үүнд: илүү шаламгай, илүү нэгдмэл, мөн гишүүдэд чиглэсэн гэх зорилт багтана.

- Нэгдүгээрт, илүү шаламгай гэдэг нь тухайбал өөрсдийн бодлогын зөвлөмжөө богино болон дунд хугацааны эрсдэлүүдэд чиглүүлэх. Эдийн засгуудын хоорондын уялдаа холбоог шинжлэх нь бидний ажлын шинж тэмдэг болж байна.

- Хоёрдугаарт, илүү нэгдмэл гэдэг нь макро-санхүүгийн холбоосууд манай таамаглал болон эрсдэлийн үнэлгээнд түлхүү тусгагдаж буй мөн санхүүгийн хамралтын хүрээ, уур амьсгалын өөрчлөлт болон Тогтвортой хөгжлийн зорилтуудын дараах бодлогын дэмжлэгүүд зэрэг тогтвортой өсөлтөд хамааралтай чухал макро асуудлууд ч багтаж байна.

- Гуравдугаарт, гишүүдэд чиглэсэн гэдэг нь улс орнуудад чиглэсэн дэмжлэг болон бүх улсыг хамарсан туршлагыг сайжруулах юм. Би гишүүн орнууддаа зочлох үеэр шилдэг практик туршлагауудаа солилцох нь хамгийн үнэтэй хувь нэмэр юм байна гэдгийг ойлгож авсан.

Ирэх долоо хоногт Лима хотод болох хурлын үеэр 188 гишүүн орнуудын өмнө энэ зорилтуудын талаар илүү дэлгэрэнгүй ярих болно. Харин одоо маш чухал ганц зүйлийг нэмж хэлье. Манай Сангийн үр дүн гишүүдийн үзүүлэх дэмжлэгээс хамаардаг. Тиймээс, 2010 онд санаачилсан Ноогдлын болон засаглалын шинэчлэлийг батлах нь

манай гишүүн орнуудын дунд явагдаж байгаа динамик өөрчлөлтүүдийг тусгахад нэн чухал үүрэгтэй бөгөөд манай сангийн гишүүн улс орнуудын хэрэгцээг хангахад өнөөдөр, хойшид ч чухал ач холбогдолтой юм. Үнэн хэрэгтээ энэ нь дэлхийн санхүүгийн аюулгүй ажиллагааны амин зүрх шүү дээ. Би АНУ-ын Конгрессыг аль болох түргэн баталж өгөхийг шамдуулж байгаа. Энэ нь АНУ-ын ОУВС-д гүйцэтгэдэг чухал үүрэг хариуцлагатай нийцэж байгаа бөгөөд маш энгийнээр хэлэхэд дээрх ярьсан шилжилтийг зохицуулахад зайлшгүй шаардлагатай юм.

ДҮГНЭЛТ

ОУВС-гийн үүсгэн байгуулагч Жон Мейнард Кейнсийн хэлсэн үгнээс иш татаж илтгэлээ өндөрлөө.

Тэрбээр Их хямралын үед ийн бичсэн байдаг. “Асар их эдийн засгийн хөгжил дэвшлийн эрин үе дууссан гэх хүмүүс олон байдаг. Гэвч би үүнийг өнөөдөр тохиолдож байгаа зүйлийн талаарх маш буруу ойлголт гэж бодож байна. Бид хөгшрөлтөөс үүдэлтэй үе мөчний өвчнөөр шаналж байгаа хэрэг биш, харин хэт хурдацтай өөрчлөлтөөс үүддэг өсөлтийн өвдөлтийг мэдэрч байна, өөрөөр хэлбэл нэг эдийн

засгийн мөчлөгөөс нөгөө рүү шилжиж байна” гэсэн.

Кейнсийн реализм болон өөдрөг бодол зөв байсан гэдэг нь мэдээж хэрэг батлагдсан. Түүний хэлсэн үгээр илтгэлээ төгсгөх нь тохиромжтой гэж бид бодлоо.

Тийм ээ, тодорхой бус байдал байна. Тийм ээ, эдгээр сорилтууд үнэхээр хүнд байна. Тийм ээ, зөв бодлого, хамтын ажиллагаагаар бид гэрэлт ирээдүйд хүрэх боломжтой. ■

Вашингтон ДС. 2015.09.30

ГАЗРЫН ТОС

Дэлхийн газрын тосны үнийн уналт болон Монгол

О.Түвшин

WTI and Brent Crude Oil



Монголд газрын тос байнга анхаарлын төвд байдаг халуухан сэдвүүдийн нэг биш бол бусад орны эдийн засгт гол түүхий эдийн үүрэгтэй байдаг. Сүүлийн нэг жилийн хугацаанд хангамж болон эрэлтээс хамааралтай янз бүрийн хүчин зүйлс газрын тосны үнийг бууруулахад хүргэсэн. Олон улсад газрын тосны зах зээлд ашигладаг хоёр гол индекс байдаг. WTI (Баруун Техасын) индексийг Хойд Америкийн газрын тосны салбарт голлон ашигладаг бол дэлхийн бусад оронд "Brent Crude Index" буюу Хойд Тэнгисийн индексийг түлхүү ашигладаг. Хоёр индексийн илэрхийлсэн үнэ ерөнхийдөө ойролцоо ч «Brent Crude» индексийн үнэ ялимгүй өндөр байх хандлагатай байдаг аж.

Их хямралын оргил үед буюу 2008 оны зургадугаар сард нэг баррель газрын тосны үнэ 147 ам.долларт хүрч түүхэн дэх хамгийн өндөр ханшид хүрсэн юм. Гэвч 2008 оны зуны төгсгөлөөс газрын тосны үнэ огцом буурч эхэлснээр 2009 оны хоёрдугаар сар гэхэд нэг баррель нь 44 ам.доллар

болсон байлаа. Үүний дараагаар дэлхийн зах зээлийн хямрал сэргэж эхэлсэн төдийгүй газрын тосны үнэ ч өндийж 2014 оны аравдугаар сар хүртэл 80-100 ам.долларын хооронд хэлбэлзэж байсан ч төд удалгүй өнөөдрийн ханш руу уруудаж эхэлсэн юм.

Дэлхийн газрын тосны нийлүүлэлт хэтэрчээ. Үүнд ОХУ болон Иракийн аль аль нь Исламын улсын бослогыг үл харгалзан газрын тосны үйлдвэрлэлээ нэмэгдүүлсэн нь нөлөөлсөн байна. Сүүлийн жилүүдэд АНУ өөрийн газрын тосны салбараа өргөжүүлж боловсруулсан газрын тосны хамгийн том үйлдвэрлэгч болсноор барахгүй байгалийн хийн цэвэр экспортлогч болоод байгаа билээ. АНУ эрчим хүчний эх үүсвэрээ дотооддоо үйлдвэрлэх болсон нь Саудын Араб болон Нигер зэрэг улс Ази болон бусад хөгжиж буй эдийн засгуудыг эрэлхийлж, орлого олох шаардлагатай тулгарч байгаа юм.

Дэлхийн эрэлтийн хувьд Европын холбооны эдийн засаг сул байгаа нь ажиглагдсан бол дэлхийн газрын тосны хамгийн том импортлогч орон болох БНХАУ «шинэ дундаж»-д шилжих шилжилтийн явцад яваа нь эрэлтийг сааруулахад хүргэжээ. Юанийн ханш сүүлийн үед буурч эхэлсэн нь ч хятадуудад импорт хийхэд илүү үнэтэй тусаж байгаа юм. Үүнээс гадна Хятадын эдийн засгийн удаашрал таамаглаж байснаас ч илүү хүнд нөхцөл байдалтай байгаа гэх хүмүүс олон бий.

Хэдий бүх зүйл тодорхой биш ч Мүүдис агентлаг газрын тосны үнэ 70 ам.долларт энэ арван жилийн эцэс хүртэл хүрч чадахгүй хэмээн таамаглажээ. Үүнээс гадна ОПЕК-ийн дараагийн хурал ирэх арванхоёрдугаар сарын 4-нд болохоор товлогдсон бөгөөд тэд үйлдвэрлэлийн хэмжээг бууруулах магадлал тун бага юм. Хэдийгээр зарим гишүүн орнууд

үнэ өсгөхийн тулд үйлдвэрлэлийг багасгах хүсэлтэй байгаа ч Саудын Араб мэт АНУ-ын бусад холбоотнууд үүнийг эсэргүүцэж байгаа аж. Мөн цөмийн хөтөлбөрөөсөө болж олон улсын хориг арга хэмжээ авахуулсан Иран улс цөмийн хэлэлцээрт хүрч байгаа бөгөөд оны сүүл гэхэд хориг арга хэмжээг хүчингүй болгох магадлалтай байна. Энэ нь Иран улсын газрын тосны үйлдвэрлэл аль хэдийнэ хэтрээд байгаа дэлхийн газрын тосны нийлүүлэлтэд нэмэгдэнэ гэсэн үг юм.

Газрын тосны хямд үнэ дэлхийн улсуудад ашигтай байна уу эсвэл хохироож байна уу гэдэг нь тухайн улс газрын тосны экспортлогч уу эсвэл цэвэр импортлогч уу гэдгээс хамаарна. Газрын тос эдийн засгийн голлох салбарын үүрэг гүйцэтгэдэг улсууд бага үнийн сөрөг нөлөөг ихээхэн мэдэрч буй. Бразил, Нигер, Иран зэрэг газрын тос экспортлогч орнуудын төсвийн орлого ихээхэн буурсан. Харин Монгол шиг цэвэр импортлогч оронд газрын тосны хямд үнэ ашигтай тусаж байгаа юм.

Гэсэн хэдий ч дэлхийн газрын тосны үнэ ам.доллараар илэрхийлэгддэг, харин төгрөгийн ханш суларсаар байгаа нь үнийн бууралтыг төдийлөн мэдрүүлэхгүй байна. 2014 оны аравдугаар сараас хойш дэлхийн газрын тосны үнэ хоёр дахин буурсан бол төгрөгийн ханш бараг 17 хувиар суларсан. Түүнчлэн Монгол Улсын инфляцийн түвшин өнгөрсөн есдүгээр сарын байдлаар 4.9 хувьтай гарсан. Эдгээр нь шатахууны үнэ буурахгүй байх зарим шалтгаан болж буй юм.

Нэг литр шатахууны үнэ ямар байхыг тодорхойлдог олон хүчин зүйл байдаг. Газрын тосыг олборлоод тээврийн хэрэгслийн түлшний сав руу шууд хийдэггүй шүү дээ. Ерөнхийдөө шатахууны тал үнэ нь л түүхий газрын тос гэж ойлгож болох аж. Харин шатахууны үнийн дөрөвний нэг нь түүхий газрын тосыг түлш, дизель эсвэл бусад боловсронгуй түлш болгох үйл явцын зардал юм. Үлдсэн нь тээвэрлэлт, худалдаа болон татвар зэрэг зардал эзэлдэг.

Харин Монгол Улсад бензиний үнэ Засгийн газрын зохицуулалтаас ихээхэн хамааралтай. Газрын тосны үнэ өндөр байх үед дотоодын нефтийн бүтээгдэхүүн импортлогч нарт татаас өгч хэрэглэгчдэд арай хямд түлш худалдан авах бололцоог олгосон. Харин үнэ нь буурч эхлэхэд үнийг тогтвортой байлгаж нэг литр бензиний үнийг 1,550 төгрөгт барихын тулд Засгийн газар импортын татварыг нэмсэн бөгөөд энэ ханш 2013 оноос одоог хүртэл бараг л хэвээр байгаа юм.

Шатахууныхаа 91 хувийг импортоор авдаг Монол Улсын хувьд газрын тос боловсруулах үйлдвэр барих асуудал аж үйлдвэрийг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд яригдаж байгаа ч одоогийн байдлаар энэ нь яриа төдий зүйл ба ямар ч тодорхой төлөвлөгөө байхгүй байгаа юм. Газрын тос боловсруулах үйлдвэр баригдлаа ч манай газрын тосны импортыг бууруулахад урт хугацаа шаардагдах төдийгүй уг бүтээгдэхүүний импорт экспортын тэнцэлд ямар ялгаа авчрахыг таахад бэрх.■

Дэлхийн алдартай сэтгүүлд сурталчилгаа байршуулах ховорхон боломж

MONGOLIAN
ECONOMY

Дэлхий
2016

Дэлхийн нийтийн ирээдүйн таамаг
The Economist Таны ирэх
жилийн хөтөч

Дэлхийн эдийн засгийн замын зураг бүтэн жилийн турш тантай хамт

The Economist сэтгүүлийн The World in-2016 жилийн дугаарыг Монгол дахь
албан ёсны тусгай зөвшөөрөл эзэмшигч Mongolian Economy сэтгүүл
монгол хэлээр эрхлэн гаргах гэж байна. 2016.01 сард танд хүрнэ

Утас 94092904, 94092905, 70115476, 70115477
www.marketing@mongolianeconomy.mn
www.info@mongolianeconomy.mn